

MONGOLIAN ECONOMY

Монголын хөрөнгийн бирж
Азийн тэргүүлэх бирж болох урт
замын аянд

Бүтээн байгуулалтыг түргэвчлэх
Хөгжлийн банк

2011. Хоёрдугаар сар. №001

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

Дэлхийн шинэ хандлага НОГООН ХӨГЖИЛ



headstart focus plus improves the power of concentration and reduces stress!

ТАНЫ АМЖИЛТЫН ТҮЛХҮҮР

headstart®

focus plus

*Sharpens your senses.
Not your pulse!*

- ✓ Төвлөрөлтийг нэмэгдүүлнэ
- ✓ Стресс, ядаргаа тайлна
- ✓ Олон витаминь найрлагатай
- ✓ Хэрэглээнд тохирсон савалгаатай
- ✓ Спортоор хичээллэгсэд
- ✓ Оюутан сурагчдад
- ✓ Өндөр ачаалалтай бизнес эрхлэгчид
- ✓ Эрүүл амьдралын баталгаат хүнс

Таны биед ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр оюун санаа, сэтгэн бодох чадвар бүхий л мэдрэхүйг сайжруулах эрүүл мэндийн ундаа

Headstart focus plus тархи сэргээгч ундааг тогтмол хэрэглэвэл анхаарлаа төвлөрүүлэх, сэтгэл санааг тогтвортой болгох, оюун ба биеийн стресс ядаргаа тайлах ид шидийг та мэдэрнэ.

INTERNATIONAL OLYMPIC COMMITTEE,
INTERNATIONAL ANTI-DOPING COMMITTEE
байгууллагуудын баталгаат бүтээгдэхүүнээр
бүртгэгдсэн.

АМТАЛЖ УУ.



Orderable on the internet-shop:

www.headstart.at

Эрхлэгчийн зурвас

Монголын эдийн засгийн хөгжил хурдсаж байгаа энэ үед “Mongolian economy” сэтгүүл мэндэлж, анхныхаа дугаараар уншигч та бүхэнтэйгээ учран золгож байгаадаа туйлын баяртай байна.

Монголын өдөр тутмын “Өнөөдөр” сонинд эдийн засаг, бизнесийн сэдвээр дагнан бичиж, 10-аад жилийн туршилага хуримтуулсан бидний хэдэн сэтгүүлч олон нийтэд эдийн засаг, санхүү, бизнесийн чиглэлийн мэдлэг мэдээллийг цогцоор нь хүргэх хэмжээний мэргэжлийн сэтгүүл гаргах хүсэл мөрөөдөлдөө хөтлөгдөн энэхүү сэтгүүлийг үүсгэн байгуулсан билээ.

Анхныхаа дугаартаа эдийн засгийн томоохон сэдвүүдийг хөндөхийн зэрэгцээ малчны хотонд очиж, малчдын бодол санааг сонсож, мөн олон зуун өрхийн амьжиргааны эх үүсвэр болсон Барс захаас сурвалжлага хийж, дотоодын нийт бүтээгдэхүүний 80 гаруй хувийг үйлдвэрлэдэг бизнесмэнүүдийн санаа бодлыг хуваалцах зорилгоор “Шинэ санаа ба бизнес” мөн төр, хувийн хэвшлийн хоорондын мэдээллийн гүүр болох үүднээс “Түншлэл” булан нээлээ. Бид хөрөнгийн биржийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх, хөрөнгийн бирж, хувьцааны мэдлэгийг ард иргэдэд түгээн дэлгэрүүлэх, мөн байгаль орчноо хайрлан хамгаалах үйлсэд тодорхой хувь нэмэр оруулж ажиллахын тулд хөрөнгийн зах зээл болон байгаль орчны холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, байнгын булан хөтөлж явуулахаар төлөвлөж байна. Мөн эдийн засгийн бүх салбарын бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэхийн зэрэгцээ асуудал хөндсөн нийтлэл, ярилцлага сэтгүүлийн үндсэн булангуудын нэг байх юм.

Түүнчлэн эрдэмтэн доктор, судлаачидтай хамтран ажиллаж, тэдний үгийг уншигчдадаа хүргэхэд анхаарч ажиллах болно.

Сэтгүүлийн маань эхний дугаарын хувьд алдаж оносон зүйлүүд бий байх. Анхны уншигч болсон та бүхэн санал бодлоо илгээгээрэй. Бид дараа дараагийн дугаартаа та бүхний санал бодлыг тусган авч, улам чанартай, сайн сэтгүүл гаргахын төлөө хичээн ажиллах болно.

Д.Бэхбаяр

Үүсгэн байгуулагч,
Эрхлэгч: Д.Бэхбаяр
8800 2389

Үүсгэн байгуулагч,
Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал
8800 6228

Англи хэлний редактор:
J.Itofo

Сэтгүүлч:
Д.Мөнхчимэг
9191 3154
Ц.Болормаа
9976 6275

Дизайнер:
Б.Пүрэвсүрэн

Маркетингийн менежер:
Б.Энхцэцэг
8881 4870

Утас/Факс: 976 - 7011 0064

Вэб: www.mongolianeconomy.mn
И-мэйл: info@mongolianeconomy.mn

Хаяг:

Улаанбаатр, СБД 6-р хороо,
Бага-Тойруу
37Б, Байр - 206 тоот

Борлуулах цэгүүд:

“Интер ном”
“Аз хур”
“Номин” супермаркетууд
“Зиг заг” автосервис
“Миний дэлгүүр”
супермаркетууд

“Улаанбаатар принт”
ХХК-д хэвлэв

“Mongolian Economy” сэтгүүлийн тухай

Монголын эдийн засаг, бизнесийн орчин дотооддоо төдийгүй гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээхэн татаж байгаа энэ үед “Mongolian Economy” сэтгүүлийг гаргаж байгаадаа баяртай байна.

“Mongolian Economy” сэтгүүл бөмбөрцгийн анхаарлын төвд ороод буй Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн мэдээ мэдээллийг нийтэлж, олон нийтийн эдийн засгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зэрэг цаг үеийн дуудлагаар мэндэлж буй билээ.

Манай сэтгүүлийн гол зорилго нь эдийн засаг, санхүү, бизнесийн мэдээ мэдээллийг үнэн бодитойгоор мэдээлэхээс гадна бизнесийн эрүүл орчин бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн хоорондын мэдээллийн гүүр болж ажиллах юм. Түүнчлэн эдийн засаг, бизнесийн байгууллагуудын хоорондын мэдээлэл түгээх уялдаа холбоог сайжруулахад ихээхэн үүрэгтэй байх болно.

Мөн манай сэтгүүл байгаль орчны асуудлыг байнга хөндөж, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулахаар “Ногоон хөгжлийн төлөө” гэсэн уриа дэвшүүлэн тавьснаа дуулгая. Түүнчлэн дэлхийн эдийн засаг, санхүү, бизнесийн талаарх мэдээ мэдээлэлд зай талбай харамгүй зориулахаас гадна бизнес эрхлэгчдэд хэрэгтэй зөвлөгөө, илтгэл, судалгаа шинжилгээний материалыг ч сонирхолтой байдлаар хүргэж байх болно.

“Mongolian Economy” сэтгүүл нь 14 хоног тутам, монгол-англи хэл дээр хэвлэгдэн гарна. Толгой эргэм том тоо, нойр хүргэсэн хатуу хэллэг бүхий эдийн засаг, санхүүгийн мэдээ мэдээллийг ойлгож товч тодорхой, үнэн зөв, баримттай бичих нь хамгийн чухал бөгөөд энэ чиглэлээр олон жил ажиллаж, багагүй туршлага хуримтлуулсан сэтгүүлчдийн баг бүрдсэн гэдгийг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Түүнчлэн аливаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус, бие даасан байдал нь нийгэмд нэн чухал байдаг билээ. Тиймээс манай сэтгүүл энэхүү байдлыг хадгалахыг хамгаас чухалчилж эдийн засаг, бизнес, санхүүгийн чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагууд, компаниудтай хамтран ажиллаж байна.

Сэтгүүлийг үүсгэн байгуулагч, Эрхлэгч:

Д.Бэхбаяр нь Завхан аймгийн Дөрвөлжин суманд 1976 онд төрсөн. МУИС-ийн Монгол хэл судлалын ангийг дүүргэсэн. 2010 онд МҮХАҮТ-ын Гадаад худалдааны академийг төгссөн. 2000-2009 онуудад “Өнөөдөр” сонины Эдийн засаг, бизнесийн мэдээллийн албаны сэтгүүлчээр, 2008 онд “Байгаль орчин, шинжлэх ухаан” сэтгүүлийн Хариуцлагатай нарийн бичгийн дарга, 2009-2010 онд МҮХАҮТ-ын “Бизнес ба Хөгжил” сэтгүүлийн Эрхлэгчээр тус тус ажиллаж байсан.

Монголын өдөр тутмын томоохон сонин “Өнөөдөр”-т ажиллах хугацаандаа олон арван эдийн засгийн мэдээ, нийтлэл бичиж, 2001 онд Оны шилдэг эдийн засаг, бизнесийн сэтгүүлч, Эрчим хүчний сэдвээр бичдэг оны шилдэг нийтлэлч, МСНЭ-ийн Ган үзэгтэн, С.Зоригийн нэрэмжит авлигын эсрэг “Өнөөдөр үгүй бол хожимдоно” нийтлэлийн уралдаанд, хүнд суртлыг халах цуврал нийтлэлээрээ тэргүүн байр эзэлж байсан.

Мэргэжлээ дээшлүүлэх чиглэлээр 2002 онд Монголын



Зүүн гар талаас: И.Отгонжаргал, Д.Бэхбаяр

хэвлэлийн хүрээлэн болон “Financial Times” сониноос зохион байгуулсан эдийн засгийн сэтгүүлчдийн сургалт, мөн ондоо Хавайд болсон АНУ-ын “East West center”-ийн Ази, Америкийн эдийн засгийн сэтгүүлчдийн сургалт, 2004 онд Монголын хэвлэлийн хүрээлэн болон АНУ-ын USAID, Монголын нээлттэй нийгмийн хүрээлэн зэрэг байгууллагаас зохион байгуулсан сургалтад тус тус хамрагджээ. Түүнчлэн Япон, БНСУ, Тайвань зэрэг орны эдийн засаг, бизнесийн салбартай танилцсан.

Мөн 2007 онд УИХ, Засгийн газрын зарим гишүүдтэй АНУ-ын “Рио Тинто”, “Тибоди” компаниудын нүүрс, алтны уурхайтай танилцаж, хариуцлагатай уул уурхайн талаар цуврал нийтлэл бичсэн.

Сэтгүүлийг үүсгэн байгуулагч, Орлогч эрхлэгч:

И.Отгонжаргал нь Увс аймгийн Өндөрхангай суманд 1978 онд төрсөн. Сэтгүүлч мэргэжилтэй.

2000-2007 онд “Өнөөдөр” сонины Эдийн засаг, бизнесийн мэдээллийн албаны сэтгүүлч, 2007 оны гуравдугаар сараас 2011 оны нэгдүгээр сар хүртэл тус сонины Эдийн засаг, үйлдвэрлэл, бизнесийн мэдээллийн албаны даргаар ажиллаж байв. Отгонжаргал нь дээрх хугацаанд эдийн засаг, бизнесийн чиглэлээр уншигчдын талархлыг хүлээсэн олон арван нийтлэл, сурвалжлага бичиж нийтлүүлсэн. Тухайлбал, 2002 онд С.Зоригийн нэрэмжит авлигын эсрэг “Өнөөдөр үгүй бол хожимдоно” нийтлэлийн уралдаанд “Гаалийн байцаагчийг царайчилсан махны экспорт” гэсэн нийтлэлээрээ дэд байрын шагнал хүртэж байжээ.

МСНЭ-ийн Ган үзэгтэн, Хэвлэл мэдээллийн салбарын тэргүүний ажилтан, МҮХАҮТ-аас шалгаруулдаг “Lady Entrepreneur-2010” шалгаруулалтын Хэвлэл мэдээллийн салбарын Онцлох хагатайгаар тодорч байв.

Эдийн засаг, бизнесээс гадна хөдөө аж ахуйн чиглэлээр дагнан бичиж, тариан талбай, малчны хотноос олон сурвалжлага, тэмдэглэл бичиж байсан учраас Хөдөө аж ахуйн салбарын тэргүүний ажилтан, “Атар-III аян”-ы ойн медаль тус тус хүртсэн байна.

Мөн өнгөрсөн хугацаанд БНСУ, Энэтхэг, Египет зэрэг улсад төр, засгийн тэргүүнүүдийн айлчлалын сурвалжлагад явж, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж байжээ.

7-15 Хөрөнгийн зах зээл

- 7 Монголын хөрөнгийн бирж Азийн тэргүүлэх бирж болох урт замын аянд
Б.Болд: Хөрөнгийн зах зээлд
- 10 сүүлийн 20 жилд хийгээгүй хөрөнгө оруулалт 2011 онд орж ирнэ
- 12 Дэлхийн биржүүд “Дэр нэгтгэж” эхэллээ
- 14 Арилжаа хийхэд тохиромжтой үе мөн үү?

18-31 Эдийн засаг

- 18 Туулай жилийн төсөв үсрэнгүй хөгжилд хүргэх үү, өвчин дагуулах уу?
- 20 Хүнсний хямралын айдас, байгалийн баялгийн амт
Ч.Ганхуяг: Хямралыг хүмүүс
- 22 хоорондын харилцааны үнэт зүйлс алдагдсантай холбон тайлбарласан
- 24 140 мянган ажлын байр уу, 21 мянган төгрөг үү?
- 26 Нэг бодлого, дөрвөн байр суурь
- 24 140 мянган ажлын байр уу, 21 мянган төгрөг үү?
- 28 Бүтээн байгуулалтыг түргэвчлэх Хөгжлийн банк
Д.Лхагвасүрэн:
- 30 Малаа салхи сөрүүлж бэлчээрлүүлэх дуртай

32-43 Уул уурхай

- 32 Хариуцлагатай уул уурхай Монголд
- 33 Нүүрсний Монгол дэлхийн тавцанд...
- 35 “Coal Mongolia 2011” чуулга уулзалт Монголын нүүрсийг үнэд хүргэхэд туслана
- 36 Их бүтээн байгуулалтын өмнөх бужигнаан
- 38 17 элемент буюу Монголд ховор биш ховор металл
- 41 Төмөр замын шинэ бодлого
- 42 Дэлхий ногоон эрчим хүч рүү

44-46 Байгаль эх

- 44 Ус амьдрал
- 46 Усгүй хөгжил ?

47-65 Бизнес

- 47 “Тамирчин” малын мах үнэд орох цагаар
- 49 PPP хөгжлийг хурдасгах түлхүүр
- 50 Бизнесмэнүүд бол үнэндээ нийгмийн зарц шүү дээ
- 57 “Барс” зах жилдээ 1600 вагон хүлээж авдаг
- 59 Америк мөрөөдлийн биелэл буюу “Алиман” компанийн эцэг
- 62 Өрсөлдөн тэмцэлдэх хэрэггүй
- 64 Төслөө хэрхэн танилцуулах вэ?
- 65 Бизнесийн завсарлага

66-68 Market Data



...Биенээ хүндлэх, хайрлах хандлага, сурсан мэдсэнээ хуваалцах, гэр бүл дотроо ч үнэт зүйлсийг төлөвшүүлж чадахгүй байна... (22)



...Уралын нурууг давж чадахгүй олон оныг үдсэн монгол малын мах экспортод хэрэглээний зориулалтаар гарч эхэллээ... (47)



...Байгалийн үнэт баялаг усаа хайрлан хамгаалах, зүй зохистой ашиглах нь улс орны оршин тогдох, хөгжихийн эх үндэс болдог... (44)

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, хөрөнгөжье, монголчууд аа

Монголын хөрөнгийн бирж гэдэг үржил шимт хөрстэй, байриил сайтай дэлгүүрийг үнэд оруулах цаг айлслаа. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд нойрмоглосон тус байгууллагын ирээдүй өдрөөс өдөрт өнгө жавхаа нэмэн гэрэлтэж байна. Үүнийг манайхан өөрсдөө биш, дэлхий бидэнд цаг минут тутамд ойлгуулах боллоо. Тухайлбал, 2010 оны дэлхийн хамгийн өндөр өсөлттэй индексээр Монголын ТОП-20 тодорсон тухай “Bloomberg” мэдээлсэн.

Тавантолгойн нэлээн хувьцааны ханиийг өнгөрсөн намар 100.000 төгрөгт хүрэхэд бид “нөөх” гэж дуу алдаж байсан бол сүүлчийн хоёр, гуравхан сарын дотор нэг ширхэг хувьцааных нь ханиш 1.2 сая төгрөг давчихлаа. Энэ бүхнийг хараад алив тэр хувьцаа гэдгийг сонирхоод үзье гэсэн бодол танд төрөхгүй байна гэж үү. Гэнэт ухаан орж, хувьцааны арилжаанд оролцох гэхээр үйл хөдлөлөө юунаас эхлэхээ мэдэхгүй, учрыг нь олж, хужрыг нь тунгаах асуудал цөөнгүй тулгарч байна уу?

Монголын хөрөнгийн биржийг хөгжүүлэхтэй холбоотой мөн ард иргэдэд бирж, хувьцааны талаар мэдлэг өгөхөд алхам тутамд тулгарах мэдэхгүй, чадахгүй асуудлуудад манай “Mongolian Economy” сэтгүүл нийтлэлийн бодлогоо чиглүүлж, зай талбайгаа харамгүй зориулах болно. Тиймээс “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, бүгдээрээ хөрөнгөжье Монголчууд аа” гэдэг уриаг манай сэтгүүл анхны дугаарынхаа тэргүүн нүүрэнд дэвшүүлэн тавьж байна. Манай редакци багаар яривал хөрөнгийн биржийн тухай мэдлэг, мэдээллийг ерөнхий боловсролын сургуулиас нь зааж эхэлье, томоор яривал хөрөнгийн зах зээлийн хөгжлийн гол түлхүүр үндэсний институциональ хөрөнгө оруулагчдыг олноор төрөхөд сэтгүүлчдийнхээ хурц үзэг, уран харааг чиглүүлэх болно.

Сүүлийн үед олонтаа сонсогдох болсон IPO, институциональ хөрөнгө оруулалт гэсэн хөрөнгө санхүүгийн дэлхийн хөгжлийг Монголд ойртуулсан мэргэжлийн чухал үг хэллэг Долоон буудлын Долгор эмээг ч гижигдэж эхэллээ. Эмээ зээ хүүгээрээ компьютер асаалгаад, хувьцааны арилжаанд оролцоод сууж байх цаг тун ч ойрхон байна. Цаашилаад төсвийн цоорхойг нөхөхөөс хэтэрдэггүй Тэтгэврийн сан, Нийгмийн даатгалын мөнгийг хөрөнгийн зах зээлд оруулж, таны миний цалингаасаа шимтгэлд суутгаж, хөгширэхөөрөө хэрэглэхээр хуримтлуулсан мөнгө хаана байришиж, хэдэн төгрөг болж өсч байгааг хараад сууж байх цаг ч нэг их удахгүй ирнэ. Гагцхүү энэ бүхэнд монголчуудад суралцах зүйл их бий. Бид манай хөрөнгийн биржийг гаднын туршилагатай баг удирдаж гоё болгоно хэмээн найдаад суух биш, Монголын хөрөнгийн бирж гэдэг тэр том дэлгүүрт дотоодын байгууллага, хувь хүмүүс ч гэсэн бараа нийлүүлж, худалдан авагч болж гол тоглогч болох учиртай.

Хамаг хөрөнгө мөнгөө гаднын хүнээр мануулчихаад гүндүүгүй монгол зангаараа хэвнэг суух биш, дэлхийн тэн хагасыг эзэлж явсан монголчууд бид өөрсдийнхөө зориг, хөдөлмөрт найдах цаг ирлээ, итгээрэй.

Монголын хөрөнгийн бирж Азийн тэргүүлэх бирж болох урт замын аянд

Д.Мөнхчимэг



Таны санхүүгийн мэдлэг хэр сайн юм бол оо? Ингэж асуухад таны толгойд арилжааны хэдэн банк, улсын төсөв орж ирж байвал... уучлаарай, “муу” дүн тавихаас өөр аргагүй нь. Санхүү гэдэг ойлголтод банкуудаас гадна хөрөнгийн зах зээл, даатгал зэрэг олон бүрэлдэхүүн байдгийг таг мартсан байна шүү дээ. Уул уурхай даган Монголд орж ирэх их мөнгөний урсгал эрүүл чийрэг санхүүгийн салбарыг шаардаж байна. Тийм ч болохоор Ерөнхий сайд хөрөнгийн зах зээлээ хөдөлгөөнд оруулах санаачилга гаргаж, Төрийн өмчийн хороо (ТӨХ) Лондоны хөрөнгийн биржтэй хамтран ажиллах гэрээ байгууллаа. Гэхдээ үүнийг хийхэд иргэд бидний оролцоо ихэд чухал гэдгийг сануулах нь зүйтэй болов уу.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 336 хувьцаат компанийн ихэнх нь бодитой үйл ажиллагаа явуулдаггүй нь тогтоогдсон. Хуулийн дагуу хувьцаат компани жилийн тайлангаа хэлэлцэж, бэлтгэн, нийт хувьцаа эзэмшигчдэдээ хүргүүлэх ёстой. Тэгвэл Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын дийлэнх хэсэг нь холбогдох материалаа ирүүлдэггүй, тэр ч байтугай ногдол ашгаа тогтмол тараадаггүй. Олон улсын жишгээр санхүүгийн зах зээл дэх

хөрөнгө оруулалтыг арилжааны банк, хөрөнгийн зах зээл хоёр нь тэнцвэртэй бүрдүүлж байдаг. Гэтэл манай санхүүгийн зах зээл дэх хөрөнгө оруулалтын 95-96 хувийг арилжааны банкууд дангаараа бий болгож байгаа нь эрүүл тогтолцоо яав ч биш. Энэ бүх асуудлыг Лондоны хөрөнгийн бирж шийдэж чадах болов уу?

Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагааг сайжруулахын тулд олон улсын мэргэжлийн багаар удирдуулахаар болж, уралдаант шалгаруулалт зарлаад даруй бүтэн жил улирчээ. Эхний шалгаруулалтад 11 улсын 10 баг оролцсоноос Лондоны хөрөнгийн бирж, Франкфуртын хөрөнгийн бирж, “Korean exchange”, “Nasdaq OMX”+“Mosdaq” консорциум тунаж үлдсэн боловч уралдаант


шалгаруулалтыг цуцалсан тухай мэдээлэл цацагдсан. Тэгвэл шинэ оны босгон дээр ТӨХ Лондоны хөрөнгийн биржтэй хамтран ажиллах гэрээ байгуулснаар бүтэн жил дуншсан дээрх асуудал нэгмөр шуудрав. Удаа ч үгүй Лондоны хөрөнгийн биржийнхэн Монголын хөрөнгийн биржийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөгөө боловсруулахаар Улаанбаатарт хүрэлцэн ирэв. Лондоны хөрөнгийн бирж группийн олон улсын хамтын ажиллагаа хариуцсан захирал хийгээд гүйцэтгэх хорооны гишүүн, түүний охин компани болох “Millenium IT”-гийн захирал Антони Виерсинг нар манай сэтгүүлчидтэй уулзсан. Ингэхдээ Монголын хөрөнгийн биржийг Азийн тэргүүлэх бирж болгох зорилготой гэдгээ ч уламжилсан юм.

Лондоны хөрөнгийн бирж “Millenium IT” программ хангамжийг Монголын хөрөнгийн биржид нэвтрүүлэх санал тавьсан билээ. Гэхдээ бүх зүйл ирэх дөрөвдүгээр сарын 20-нд “Master service agreement” гэрээг байгуулснаар тодорхой болох тухай ТӨХ-ны Монголын хөрөнгийн биржийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч.Чинзориг онцолсон.

Ингэхэд “Millennium IT” гэж юу хэлээд байна вэ? Шри Ланк улсын энэхүү компанийг 2009 онд Лондоны хөрөнгийн бирж өөртөө нэгтгэж авчээ. “Тус компанийг эзэмшсэнээр манай бирж дэлхийн хамгийн хурдтай арилжааны платформтой болсон. Энэ нь түргэн шуурхай, үр ашигтай, өртөг багатай, хэрэглэгчийн хүсэл сонирхолд нийцсэн үйлчилгээ явуулахад тусалж чадна” хэмээн Лондоны хөрөнгийн биржийн захирал Хавиер Ролет тэмдэглэжээ.

“Millennium IT” компанийн программ хангамжийг эдүгээ ▶

Та хөрөнгийн зах зээлийг хэр сайн мэдэх вэ?



(Эх сурвалж: <http://www.mse.mn>)

Монголын хөрөнгийн биржийн мэргэжилтнүүд “Та хөрөнгийн зах зээлийг хэр сайн мэдэх вэ?” гэсэн санал асуулгыг өөрийн цахим хуудсанд байриуулжээ. Үг асуулгад 3877 хүн оролцсоноос 71.8 хувь нь “сайн мэдэхгүй”, “огт мэдэхгүй” хэмээн хариулсан байх юм. Гэтэл цаана нь интернэтэд ордоггүй, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас гэж юу байдгийг ч огт мэдэхгүй хүн олон бий. Дээрх судалгааны үр дүнгээс хөрөнгийн зах зээлийн талаарх монголчуудын мэдлэг хэтэрхий чамлалттай байгаа нь харагдаж байна.

Лондоны металлын бирж, ICAP ашиглаж байгаагийн зэрэгцээ АНУ-ын AMEX, Бостоны хөрөнгийн бирж зэрэг 22 хөрөнгийн бирж хэрэглэж буй аж. Лондоны хөрөнгийн бирж ч өөрийн арилжааны системд энэ хоёрдугаар сарын 14-нөөс дээрх программ хангамжийг суулгаж буй. “Millennium Exchange” гэх арилжааны уг систем нь хамгийн хурдан гэдгээр рекорд тогтоосон тухай мэдээлэл өнгөрсөн аравдугаар сард цацагдсан. Хурднаас гадна дээрх систем нь хялбар бөгөөд хямд учир олон орны хөрөнгийн биржийг өөртөө татаж буй ажээ.

1801 онд байгуулагдсан Лондоны хөрөнгийн бирж эдүгээ 70 орчим орны 2600 гаруй компанийн хувьцааг арилжаалж буй бөгөөд 3.8 их наяд ам.долларын зах зээлийн үнэлгээгээрээ дэлхийд толгой цохино. Мөн уул уурхайн компаниудын бүртгэлээр уг бирж дэлхийд тэргүүлдэг ажээ. “Rio Tinto”, “BHP Billiton”, “Anglo American”, “Xstrata” зэрэг уул уурхайн “акулууд” Лондоны хөрөнгийн биржид хувьцаагаа арилждаг бөгөөд манай хойд хөршийн “Газпром”, “Лукойл”, “Роснефть” зэрэг томоохон компани ч уг биржид бүртгэлтэй байдаг.

Монголын “Петровис”-ийн охин компани болох “Петро Матад” ч Лондоны хөрөнгийн биржээс хөрөнгө босгосон билээ. Энэ нь манай орны хувьд гадаадын зах зээлд IPO хийсэн анхны үндэсний компани болсныг сануулах юун. Тус компанийн хувьцааны үнэ анх монгол мөнгөөр тооцоолоход 800 төгрөг байснаа нэг жилийн дотор 4000 төгрөгт хүрч, тав дахин өссөн нь Лондоны хөрөнгө оруулагчид Монголын компаниудад хэр ээлтэй болохыг харуулна. Монголчуудын Лондоны хөрөнгийн биржтэй хамтарч ажиллах цар хүрээ зөвхөн техник технологиор хязгаарлагдахгүй.

“Манай групп гаднын томоохон хөрөнгө оруулагчдыг Монголд нэвтрүүлж, дэд бүтэц болон хөрөнгө оруулалт талаас нь хамтарч ажиллана. Энэ нь жижиг, дунд үйлдвэрүүд хөгжихөд ч нэмэртэй” хэмээн Антони Виерсинг онцолсон юм. Тэрбээр мөн энэ оны сүүлч гэхэд Монголын хөрөнгийн биржид бүтцийн өөрчлөлт хийнэ хэмээн итгэлтэй ярьсан.

Гэрээг ойролцоогоор гурван жилийн хугацаатай хийх бөгөөд Лондоноос таван хүний бүрэлдэхүүнтэй баг ирэх бололтой. Одоогийн Монголын хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээ хоёр тэрбум ам.долларт хүрэхгүй байгаа ч ойрын хэдэн жилийн хугацаанд энэ үзүүлэлт 25 тэрбумд дөхөж очих магадлалтайг Антони Виерсинг мөн онцолсон. “200 жилийн түүхтэй Лондоны хөрөнгийн бирж бусдыг бодвол нөр их дадлага, туршлага хуримтлуулсан. Тиймээс бид Монголын компаниудад зөвхөн хөрөнгө босгох нөхцөлийг бүрдүүлэх бус, тэдний нэр хүндийг олон улсын тавцанд өсгөж өгнө” гэж Лондоны хөрөнгийн биржийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн газрын захирал Трэйси Пиерс тэмдэглэж байсан билээ.

Европт “№1” гэгдэх Лондоны хөрөнгийн бирж яагаад Монгол оронд ийнхүү анхаарал хандуулах болов оо? 200 жилийн замналын хажууд хэтэрхий жулдах 20-хон настай Монголын хөрөнгийн зах зээлийг Лондоныхон бүтэн жил гаруй хугацаанд судалжээ. “Ер нь бид хөгжиж буй орнуудад анхаарал тавьж, судалгаа хийгээд олон арван жил болж байна. Лондоны хөрөнгийн биржийн нийт активын 12 хувь нь хөгжиж буй орнуудад хамаарч байгаа нь чамлахааргүй үзүүлэлт. Бид ОХУ, Энэтхэг, Бразил зэрэг оронд ажилласан туршлагатай” хэмээн Трэйси Пиерс тайлбарласан.

“Гадаадын компаниуд Монголын ашигт малтмалын нэрийг барьж, мөнгө босгож болоод байхад бид яагаад чадахгүй гэж” хэмээн Ерөнхий сайд С.Батболд тэмдэглэж, Монголын хөрөнгийн зах зээлийг дэлхийн жишигт нийцүүлэх санаачилга гаргаж байсан үеийг санаа. “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн 20-30 хувийг гадаадын биржид өмчлүүлэх замаар менежментийн шинэ арга барил, дэвшилтэт технологи нэвтрүүлнэ гэсэн санааг С.Батболд сайд цухалзуулсан удаатай. Монголын хөрөнгийн бирж хэдийнэ хувьчлагдах компаниудын жагсаалтад багтчихсан яваа. Энэ тухай харин албаны хүмүүс тайлбар өгөхөөс цааргалж байгаа юм. “Эхлээд тус компанийн үйл ажиллагааг сайжруулж, дараа нь

л хувьчлах эсэхийг шийдвэрлэнэ” хэмээн Ч.Чинзориг тэмдэглэсэн билээ.

Монголын хөрөнгийн биржийг дэлхийн жишигт нийцүүлэхийн тулд хөрөнгө мөнгө ихээхэн шаардлагатай нь мэдээж. Энэ мөнгийг менежментийн баг өөрөө босгох уу, манай Засгийн газар гаргах уу гэдэг асуудал тодорхой бус хэвээр. “Үүнийг менежментийн баг, ТӨХ, Засгийн газар хоорондын хэлцлээр шийдвэрлэнэ” хэмээн Ч.Чинзориг хэлж байна.

Монголын эдийн засаг хөгжлийн шинэ шатандаа гарч буйг мэргэжилтнүүд тэмдэглэсээр. Хэдхэн жилийн өмнө монгол компани олон улсын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгоно гэдэг мөрөөдөл төдий байсан бол өнөөдөр “Петро Матад”, “Mongolian mining corporation”, “Хүннү коал”, “Харанга ресорсез” зэрэг компани Лондон, Хонконг, Австралийн хөрөнгийн биржид хувьцаагаа арилжаалж байна. Засгийн газар Монголын хөрөнгийн биржийг дэлхийн жишигт хүргэнэ гэсэн зорилготой ажиллаж байна. Гэвч Лондоны хөрөнгийн бирж тус компанийг удирдлаа гээд бүх зүйл өргөс авсан мэт бүтчихгүй нь ойлгомжтой.

Хөрөнгийн зах зээлийн хөгжил юу юунаас илүү иргэд биднээс шалтгаална гэвэл буруудахгүй ээ. Удахгүй монгол хүн бүр “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаа эзэмшигч болно гэж байгаа. Лондоноос ирэх “ээд” Монголын хөрөнгийн биржийн менежментийг мянга сайжруулаад ч хувьцааны талаарх иргэд, бизнес эрхлэгчдийн ойлголт маруухан байгаа цагт “Азийн тэргүүлэх бирж” гэдэг үг хэзээ ч Монголын хөрсөнд буухгүй болов уу.

Товчхондоо, 1990-ээд оны цэнхэр, ягаан тасалбарын сургамж давтагдаад өнгөрөх аюултай. Тиймээс бид хөгжлийг хүсч байгаа бол юуны түрүүнд хөрөнгийн зах зээлийн тухай мэдлэгээ зузаатгах хэрэгтэй болжээ. Иргэд арилжаанд идэвхтэй оролцож, хувьцаат компаниуд олон улсын жишгийн дагуу үйл ажиллагаа явуулж, мэдээллээ ил тод байлгах нь Азийн тэргүүлэх бирж болох урт замд хөл тавих хамгийн эхний алхам болох учиртай. ■

Ногоон хөгжлийн төлөө



Монголын эдийн засаг,
бизнесийн сэтгүүл



www.mongolianeconomy.mn

Б.Болд:**Хөрөнгийн зах зээлд сүүлийн 20 жилд хийгээгүй хөрөнгө оруулалт 2011 онд орж ирнэ**

Д.Бэхбаяр

Ньюком группийн гүйцэтгэх захирал Б.Болдтой хөрөнгийн зах зээлийн тухай ярилцлаа. “Ньюком” нь 2000 гаруй ажилтантай, “Мобиком”-ын хамгийн том хөрөнгө оруулагч, мөн дотоодын нислэгийн зах зээл дээр тэргүүлэгч “Изинис” компанийг 100 хувь эзэмшигч, Монголын анхны салхин парк байгуулах “Клин Энержи” компанийг үүсгэн байгуулагч юм.

Харин тус группийн гүйцэтгэх захирлыг АНУ-д хоёрт ордог хөрөнгө оруулалтын “JPMorgan” банкинд 10 гаруй жил ажиллаж, хөрөнгө санхүүгийн салбарт арвин туршилага хуримтлуулсан хүн гэж үздэг. Тиймээс ч тэрхүү туршилага мэдлэг боловсролыг нь харгалзан Монголын хөрөнгийн биржийн /МХБ/ Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар томилсон биз ээ. Манай сэтгүүл ч хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, ард иргэдэд мэдлэг мэдээлэл өгөх зорилгынхоо хүрээнд Б.Болд захиралтай хамтран ажиллаж, хөрөнгийн бирж, санхүүгийн зах зээлийн талаар цуврал ярилцлага, нийтлэл бичихээр төлөвлөж байна.

-Өнөөдөр манай улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил ямар түвшинд явж байна, ямар саад бэрхшээл байна вэ?

-Хөрөнгийн зах зээл хурдтай хөгжихгүй байгааг ганц биржийн менежмент ч юм уу, эсвэл зөвхөн гадаадын хөрөнгө оруулалттай холбож тайлбарлавал өрөөсгөл хэрэг болох болов уу. Олон зуун жилийн туршид хөрөнгийн зах зээлээ үр дүнтэй хөгжүүлж ирсэн улс орны жишгийг харахад хөрөнгийн зэх зээл дээр голлон оролцогчдыг ерөнхийд нь



таван бүлэгт хувааж болдог. Энэ бүлэг тус бүр дээр ямар саад тогтор байгааг бага ч болов тайлбарлавал илүү тодорхой дүр зураг харагдах байх.

Нэгдүгээр хэсэгт хөрөнгө оруулагч нар орно. Хөрөнгө оруулагч бол хөрөнгийн зах зээл дээр хамгийн чухал үүрэг гүйцэтгэгчид байдаг. Хөрөнгө оруулагчдыг дотор нь институциональ буюу байгууллагын хөрөнгө оруулагч, бие даасан буюу хувь хүн гэж хувааж болно. Институциональ дотроо тэтгэврийн сан, даатгалын компани, хөрөнгө оруулалтын сан, банк, гадаадын сангууд, хедже сан зэрэг багтдаг. Монголын хөрөнгийн зах зээлийг харахад өнөөдөр хувь хүн буюу бие даасан хөрөнгө оруулагчид дийлэнх хувийг эзэлж байна. Хамгийн гол нь манай хөрөнгийн зах зээлд бие даасан хөрөнгө оруулагчдын оруулж буй хөрөнгө бага хэмжээтэй байдаг учраас хөрөнгийн хөрвөлт сайн үүсч чаддаггүй.

-Гаднын бирж дээр байгууллагын болоод бие даасан хөрөнгө оруулагчдын харьцаа ямар байдаг юм бол. Ийм хөрөнгө оруулагчдын давуу болон сул тал юу байх вэ?

-Гадаадын биржүүдэд бие даасан хөрөнгө оруулагчдын эзлэх хувь тун бага. Харин Хонконгийн хөрөнгийн бирж дээрх хөрөнгийн 70-90 хувь нь бие даасан хөрөнгө оруулагчдынх байдаг. Томд тооцогдох байгууллагын хөрөнгө оруулагчдын ихэнх нь Лондон, Нью-Йоркт байрлаж, тэндхийн хөрөнгийн зах зээлд оролцдог гэж хэлж болно. Бие даасан хөрөнгө оруулагчдын сул тал нь эдгээр хүмүүсийн дийлэнх хувь нь богино хугацаанд үнэт цаасны үнийн зөрүүн дээрээс орлого олох зорилготойгоос болж үнийн хэлбэлзэл өндөр байдаг. Харин байгууллагын хөрөнгө оруулагчид урт хугацаанд хөрөнгө оруулдаг. Гэхдээ дан гаднын байгууллагын хөрөнгө оруулагчдыг оруулж ирэх нь бас сул талтай. Тэд

хөрөнгө оруулах, эсвэл хөрөнгөө эргүүлэн татах үед хөрөнгийн болоод валютын зах зээл дээр хэт хэлбэлзэл үүсдэг. Тиймээс хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхийн тулд Монголдоо дотоодын гэсэн байгууллагын хөрөнгө оруулагчдыг бий болгож, тэр дундаа тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сан болон хедже сан зэргийг байгуулан, эдгээрийг хөрөнгийн зах зээлд оролцох таатай нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байгаа юм.

-МХБ-д бүртгэгдсэн мөртлөө арилжигддаггүй олон хувьцаа байдаг. Үнэт цаас худалдаж авъя гэхээр сонголт багатай. Тэгэхээр шинээр үнэт цаас гаргах компаниуд зах зээлд дээр зайлшгүй хэрэгтэй байгаа биз дээ?

-Тэгэлгүй яахав. Үнэт цаас гаргагчгүйгээр хөрөнгийн зах зээлийг төсөөлөх боломжгүй. Энэ нь хоёрдугаар бүлэгт багтах оролцогчид болно. Засгийн газар, орон сууцны корпораци, томоохон компаниуд энэ бүлэгт багтах оролцогчид байдаг. Өнөөдөр МХБ дээр гарсан үнэт цаасны 50 гаруй хувь нь арилжаанд огт ордоггүй. Мөн гадны сангууд Монголд орж ирээд үнэт цаас худалдаж авъя гэхээр тэдний шаардлагад нийцэхүйц үнэт цаас тун ховор байдаг. Тиймээс ирэх таван жилийн дотор бид дотоодын компаниуд тэр дундаа олон нийтэд сайн танигдсан компаниудыг, түүнчлэн гадаадын бирж дээр хүлээн зөвшөөрөгдөж, арилжаа нь явагдаж буй Монголд үйл ажиллагаа эрхэлдэг “Southgobi Sands” гэх мэт гадаадын компаниудыг, бас стратегийн ач холбогдолтой орд газруудын үнэт цаасны цөөн ч болтугай хувийг нь МХБ дээр гаргах замаар энэхүү нийлүүлэлтийн асуудлыг шийдэх хэрэгтэй байна.

Дээр таван бүлэг оролцогчид байдаг тухай дурдсан. Тэгэхээр гуравдугаарт нь хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагч хоёрыг хөрөнгийн бирж дээр холбож өгөхөд гол үүрэг гүйцэтгэдэг мэргэжлийн байгууллагуудыг оруулж байгаа юм. Энд брокер дилерийн компаниуд, underwriter буюу үнэт цаасыг анхдагч зах зээл дээр гаргах мэргэжлийн байгууллагууд, үнэт цаасыг үнэлж, ангилал тогтоодог, хувьцааны үнэлгээ хийдэг байгууллагууд

буюу хөрөнгө оруулалтын банкууд, хуулийн зөвлөгөө өгөх компаниудыг нэрлэж болно. Энэ дунд бас гол үүрэг гүйцэтгэгчид бол үнэт цаасны үнийн өөрчлөлтийг судалж, тухайн үнэт цаасыг авах эсвэл зарах санал гаргадаг судалгааны байгууллагууд юм. Хөрөнгө оруулагчид энэхүү байгууллагуудын гаргасан санал дээр үндэслэн өөрсдийн хөрөнгө оруулах эсэхээ шийдвэрлэдэг.

Дөрөвдүгээрт, эдгээрийн гол цөм болох хөрөнгийн биржийг нэрлэе. Аливаа хөрөнгийн биржид итгэх итгэлгүйгээр хөрөнгийн зах зээл хөгжсөн түүх хаана ч байхгүй. Тиймээс ч МХБ-ийн засаглал, менежмент, бүтэц, дүрэм журам, төлбөр тооцооны арга зам бүгдийг сайжруулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнд хүргэх нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд шууд нөлөөлөх хүчин зүйлүүд болно.

Тавдугаарт, хөрөнгийн зах зээл дээрх шударга өрсөлдөөнийг хянаж, хууль, эрх зүйн хэрэгжилтийг баталгаажуулдаг, зохицуулах байгууллагууд багтана. Монголын хувьд Санхүүгийн зохицуулах хороо, МХБ-ийн Хяналтын алба зэрэг байгууллага, алба энэ бүлэгт багтаж байгаа юм. Зохих мэдээллийг олон нийтэд ил байлгах, мэдээллийг олон нийтэд хүртээлтэй болгохыг үнэт цаас гаргагч болон бусад байгууллагаас шаардах, зах зээл дээрх хяналтыг хангалттай тавих замаар зөрчлийг цаг алдалгүй илрүүлж, зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх гээд олон үүрэг хариуцлага эдгээр байгууллагад оногддог. Гэвч дотоодын хүчин чадал, нөөц бололцоо болон хууль эрх зүйн тодорхойгүй орчин зэргээс хамаарч энэхүү үүрэг хариуцлагыг бүрэн дүүрэн гүйцэтгэх орчин хангалттай бүрдээгүй байна.

-Энэ бүгдийг цогцоор нь бүрдүүлж, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд төрийн зүгээс ямар дэмжлэг шаардлагатай вэ?

-Эдгээр олон асуудлыг шийдэх, бэрхшээлийг давахад төрийн зүгээс бүрэн дэмжлэг шаардлагатай нь ойлгомжтой. 2010 онд Монгол Улсын Засгийн газар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд онцгой анхаарч, идэвхтэй ажиллаж эхэллээ. Мөн энэ хүрээнд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх ажлын хэсгийг Ерөнхий

сайдын захирамжаар байгуулж, багагүй ажил хийгээд байна. Юуны түрүүнд МХБ-ийн засаглал, менежментийг сайжруулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийг өөрчилж, мэргэжлийн болоод бие даасан төлөөллийг оруулсан. Засгийн газар, Төрийн өмчийн хорооноос дорвитой арга хэмжээ авсны үр дүнд дэлхийд санхүүгийн төв гэдгээр алдаршсан Лондоны хөрөнгийн биржийн баг МХБ-ийн менежментийг хариуцаж ажиллахаар болж байна. Гэхдээ энд нэг зүйл хэлэхэд гаднын биржид менежментийг нь шилжүүлж хариуцуулна гэж ярьж байгаа болохоос биш МХБ-ийг хувьчлах тухай яриагүй. Энэ хоёрыг ялгаж салгаж ойлгох хэрэгтэй.

-Тэгэхээр 2011 онд манай хөрөнгийн биржид нэлээд өөрчлөлт орно гэж ойлгож болох уу?

-Бидний өнөөдөр МХБ дээр ашиглаж байгаа техник технологи бол 1990-ээд оны эхээр анх хөрөнгийн бирж байгуулагдахад л нэвтрүүлсэн, тухайн үедээ шилдэгт тооцогдож байсан. Үүнээс хойших 20 жилд дорвитой ямар ч хөрөнгө оруулалт хийгээгүй иржээ. Гэтэл та сүүлийн хорин жилд компьютер технологи хэр өөрчлөгдсөнийг мэдэж байгаа. Тиймээс МХБ-ийн менежментийг өгөхдөө “Millennium IT” гэсэн технологийг манай бирж дээр суурилуулж, олон улсын жишигт нийцүүлэх ажлыг давхар гүйцэтгэх шаардлага тавьж байгаа юм. Энэ нь дэлхийн санхүүгийн төв болсон Лондоны хөрөнгийн бирж болон Лондоны металлын бирж зэрэг дэлхийд танигдсан биржүүдэд нэвтрүүлсэн, дэлхийд хамгийн хурданд тооцогдох технологи.

Саяхан Лондоны хөрөнгийн бирж групп нь Торонтогийн хөрөнгийн бирж групптэй нэгдэж, дэлхийд тэргүүлэх байгууллага болохоор гэрээ байгуулчихлаа. Тэгэхээр ирээдүйд монголчуудын хувьд Лондон болон Торонтогийн хөрөнгийн биржтэй холбогдоход асуудалгүй болно гэсэн үг. Үүнээс гадна иргэдэд гэрээсээ интернэтээр хувьцаа худалдан авах боломж тун удахгүй бүрдэнэ. Энэ бүгдийн суурийг тавьж, 2011 онд томоохон хөрөнгө оруулалт хийж, хөрөнгийн зах зээлийг шинэчлэх болно.

Даяаршил Монголд юу авчрах вэ?



Дэлхийн биржүүд “дэр нэгтгэж” эхэллээ

М.Чимэгээ

2011.02.09 Лхагва гариг. Энэ өдөр дэлхийн санхүүгийн зах зээлийн түүхэнд тэмдэглэгдлээ. Торонтогийн хөрөнгийн биржийг эзэмшдэг Канадын “TMX” группийг Лондоны хөрөнгийн биржийн толгой “LSE Group” худалдан авахаар болсон тухай мэдээлэл энэ өдрийн өглөө цацагдав. Гэтэл хэдхэн хормын дараа ХБНГУ-ын “Deutsche Boerse” болон Америкийн NYSE нэгдлийн чухал асуудлуудаа нэг тийш болгосон тухай шуугиан дэгдсэн юм.

“Дөрвөн талбар дайнд бэлтгэж эхэллээ. Байлдааны шугам Лондон, Торонтогийн хөрөнгийн бирж, түүний өрсөлдөгч болох Нью-Йорк-Франкфуртыг дайрч байна” хэмээн “The Sunday Telegraph” сонины тоймч Жеймс Квин нийтлэлээ гарчиглажээ. Тийм ээ, дэлхийн биржүүд ийм томоохон хэлэлцээр давхар давхар хийж байсан тохиолдол урьд хожид үзэгдэж байсангүй. 2006 онд Нью-Йоркийн NYSE Францын “Euronext” биржийг худалдаж авсан нь хамгийн том хэлцэл болж байсан түүхтэй.

Гэтэл өнөөдөр Лондон-Торонтогийн 4.2 тэрбум фунтийн нэгдлийг Нью-Йорк-Франкфурт 14.4 орчим тэрбум фунтийн нэгдлээр бут цохих нь тэр! “New York Post” сонины хоёрдугаар сарын шинэхэн дугаарын эхний нүүрт “Achtung! германчууд Нью-Йоркийн хөрөнгийн биржийг авч байна” гэсэн гарчиг ярайв. ХБНГУ-ын “Deutsche Boerse” болон Америкийн NYSE биржийн

хэлэлцээр бөмбөрцгийн анхаарлыг хамгийн ихээр татаж байгаа юм. Нэгдсэн компани “DB NYSE Group” гэсэн нэртэй байх бөгөөд төв байр нь Амстердам хотод байрлах ажээ. Уг шинэ компанийн 60 хувийг Германы тал эзэмших учраас Уолл-Стрийт байр сууриа алдаж байна гэж зарим шинжээч дүгнэж буй. Нэгдсэн талбарт бүртгүүлсэн компаниудын зах зээлийн үнэлгээ 15 их наяд ам.долларт хүрч, дэлхийд тэргүүлнэ хэмээн шинжээчид дүгнэж байгаа юм. Сонирхуулахад, “Deutsche Boerse” болон “NYSE Euronext” 2008 оноос л нэгдлийн тухай ярьж эхэлсэн боловч дэлхийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралаас болж, энэ асуудал түр хойшлоод байжээ.

Дээрх дуулиантай зэрэгцэн бас нэгэн шуугиан чих дэлсэв. Сингапур-Австралийн хөрөнгийн бирж нэгдэж чадвал ашигт малтмалын компаниудын бүртгэлээр Торонтогийн хөрөнгийн биржийг бут цохих хандлагатайг “BNP Paribas” банкны шинжээч Эли Дарвиш тэмдэглэжээ. Сингапурын SGX өнгөрсөн аравдугаар сард ASX биржийг 8.4 тэрбум австрали доллараар худалдаж авах санал тавьсан ч ногоон тивийнхэн хариу өгөх гэж яарахгүй байгаа юм. Гэтэл энэхүү нэгдэлд зах зээлийн үнэлгээгээрээ дэлхийд тэргүүлж эхэлсэн Хонконгийн хөрөнгийн бирж хүртэл оролцох сонирхлоо албан ёсоор илэрхийлсэн нь бас

нэгэн сонирхолтой дүр зургийг бий болголоо. Гэвч Азийн биржүүдийг засаг нь маш нарийн хянадаг тухай зарим мэргэжилтэн онцлоод, Хонконгийн хөрөнгийн бирж Австрали, Сингапуртай нэгдэнэ гэдэг үнэмшилгүй сонсогдож байгааг тэмдэглэжээ.

Монголчуудын сонирхлыг хамгийн ихээр татах нэгдэл бол мэдээж Торонтогийн хөрөнгийн биржийг “LSE Group” худалдан авах болсон явдал. Ингэхдээ 3.2 тэрбум ам.долларын үнийн санал тавьж, таван сарын турш хэлэлцсэний эцэст уг асуудал шуудрах шатандаа ороод байна. Өөрөөр хэлбэл, 5700 км-ийн зайд орших хоёр талбар нэгдэхэд бэлэн боллоо. Ингэж чадвал “LSE Group”-ийн нэг жилийн үйл ажиллагааны зардал 56 сая ам.доллараар багасах боломжтойг “Bloomberg” мэдээлжээ. Нэгдсэн биржид 6700 орчим компани бүртгэлтэй байх ба тэдний зах зээлийн үнэлгээ 5.9 их наяд ам.доллар болох төлөвтэйг шинжээчид тооцоолсон аж. “LSE Group” нэгдсэн компанийн хувьцааны 55 хувийг эзэмшихээр болсон бол үлдсэн нь “TMX” группийн мэдэлд орох юм.

Энэхүү нэгдлийн талаар Торонтогийн хөрөнгийн биржийн захирал Томас Клоэт мэдэгдэхдээ Хойд Америкийн тоглогчид Европт саадгүй нэвтрэх боломж бүрдэж байгааг онцолсон байна. “Торонтогийн бирж ашигт малтмалын компаниудаар дагнадаг.

Лондоны хувьд ч уул уурхайн салбар чухал агаад эрдэс баялгийн томоохон компаниуд бүртгэлтэй байгаа. Энэ хоёр бирж нэгдсэнээр уул уурхайн компаниудад илүү боломж нээгдэж, Лондон-Торонтод давхар бүртгэлтэй болоход сайнаар нөлөөлнө” хэмээн “Deutsche Welle” компанийн шинжээч Андрей Гурков “Вести”-д өгсөн ярилцлагадаа тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, Канадын эрх баригчид энэхүү нэгдлийг хүлээн зөвшөөрч, “LSE Group” санасандаа хүрч чадвал Австрали, Сингапурын хөрөнгийн бирж дээр ахиад Хонконг нэмэгддэг байлаа ч айлтгүй болж байна гэсэн үг.

Монголын хөрөнгийн биржийг удирдах менежментийн багаар Лондоны хөрөнгийн бирж тодорч, албан ёсоор гэрээ хэлэлцээр байгуулаад удаагүй байна. Ийм үед “LSE Group” Торонтогийн хөрөнгийн биржийг худалдаж авч байгаа нь монголчуудад яаж нөлөөлөх бол? Төрийн өмчийн хорооны “Монголын хөрөнгийн бирж”-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч.Чинзориг “Лондоны хөрөнгийн бирж манайхтай байгуулсан гэрээний зүйл, заалтад өөрчлөлт орохгүй. Энэ утгаараа хоёр бирж нэгдэж байгаа нь манайд ямар ч сөрөг нөлөөгүй. Харин ч бидний хувьд илүү боломж нээж байна. Монголын компаниуд зөвхөн Лондоны биржид биш, Хойд Америкийн хөрөнгийн зах зээлд хувьцаагаа арилжих боломж бүрдэнэ” гэж ярьсан юм. “Ирээдүйд монголчууд Лондон болон Торонтогийн хөрөнгийн биржтэй холбогдоход асуудалгүй болно” хэмээн “Монголын хөрөнгийн бирж” компанийн ТУЗ-ийн дарга Б.Болд тодотгожээ. Ингээд бодохоор дэлхийн биржүүдийн даяаршил Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд сайныг ерөөж байна. Харин одоо дээрх нэгдлүүдийн “гол дүрүүд”-ийг товч танилцуулъя.

Лондоны хөрөнгийн бирж



1801 онд байгуулагдсан Лондоны хөрөнгийн бирж нь “LSE Group”-ийн бүрэлдэхүүнд багтдаг. Уг бирж 70 орчим орны 2600 гаруй компанийн хувьцааг арилжаалж буй бөгөөд тэдгээрийн зах зээлийн үнэлгээ 3.8 их наяд ам.долларт хүрсэн байна. Мөн уул уурхайн компаниудын бүртгэлээр Лондоны хөрөнгийн бирж дэлхийд тэргүүлдэг ажээ. “Rio Tinto”, “BHP Billiton”, “Anglo American”, “Xstrata” зэрэг “акулууд” уг биржид хувьцаагаа арилждаг бөгөөд манай хойд хөршийн “Газпром”, “Лукойл”, “Роснефть” зэрэг томоохон компани ч бүртгэлтэй байдаг юм. Монголын “Петровис”-ийн охин компани болох “Петро Матад” ч Лондоны хөрөнгийн биржээс хөрөнгө босгосон билээ. 2008 оны тавдугаар сард 35 пенсээр үнэлэгдэж байсан “Петро Матад” компанийн хувьцааны ханш эдүгээ 122 пенсээс давж байгаа юм.

Торонтогийн хөрөнгийн бирж



Канадын хамгийн том бирж болох Торонтогийн хөрөнгийн бирж нь зах зээлийн үнэлгээгээрээ Хойд Америкага дөрөвдүгээрт эрэмбэлэгддэг. “TMX Group”-ийн бүрэлдэхүүнд багтах уг бирж уул уурхай, нефть хийн компаниудын бүртгэлээрээ дэлхийд тэргүүлдэг ажээ. 1852 онд үндэс сууриа тавьсан Торонтогийн хөрөнгийн бирж 1878 онд албан ёсоор бүртгүүлж, үйл ажиллагаагаа эхэлсэн байна. Эдүгээ Торонтогийн хөрөнгийн бирж 1500 орчим компанийн хувьцааг арилждаг бөгөөд тэдгээрийн зах зээлийн үнэлгээ 2.1 их наяд ам.доллараас давж байгаа юм.

“Cameco” корпораци, “Canadian Natural Resources”, “Canadian Oil Sands Trust”, “EnCana Corporation”, “Husky Energy”, “Imperial Oil”, “Nexen” зэрэг Канадын томоохон уул уурхайн компани уг биржид бүртгэлтэй байдаг. Түүнчлэн Монголд үйл ажиллагаа явуулдаг “Ivanhoe Mines”, “Centerra Gold”,

“Entree Gold”, “SouthGobi Energy Resources” болон бусад компани Торонтогийн хөрөнгийн биржид хувьцаагаа арилждаг билээ.

Хонконгийн хөрөнгийн бирж



Азидаа Токиогийн хөрөнгийн биржийн дараа буюу хоёрдугаарт жагсдаг Хонконгийн хөрөнгийн бирж нь “Hong Kong Exchanges and Clearing” холдингийн мэдэлд байдаг. Эдүгээ уг биржид 1413 компани бүртгэлтэй байдгийн зах зээлийн нийт үнэлгээ 2.7 их наяд ам.доллараас давж байна. 1891 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн Хонконгийн хөрөнгийн бирж 1986 оны аравдугаар сарын 6-нд бүтцийн өөрчлөлт хийж, шинээр үүсэн байгуулагджээ.

2010 оны аравдугаар сард Ухаа худагт үйл ажиллагаа явуулдаг “Энержи ресурс” буюу “Mongolian mining corporation” Хонконгийн хөрөнгийн биржид IPO хийж, 650 сая ам.доллар босгосон билээ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлд гарсан эхний өдрөө долоон хонконг доллараар үнэлэгдэж байсан тус компанийн хувьцааны ханш эдүгээ 10.28 хонконг долларт хүрсэн байна.

Австралийн хөрөнгийн бирж



1987 онд Австралийн Парламент зургаан тусдаа үйл ажиллагаа явуулдаг байсан хөрөнгийн биржийг нэгтгэснээр Австралийн хөрөнгийн биржийн үндэс суурь тавигджээ. 2006 онд Австралийн хөрөнгийн бирж “Sydney Futures Exchange” биржтэй нэгдсэнээр өнөөгийн ASX буюу “Australian Securities Ex-

» change” бий болсон байна. 2010 оны наймдугаар сард бүтцийн өөрчлөлт хийж, “ASX Group”-ийн мэдэлд очсон уг биржид “BHP Billiton”, “Rio Tinto” зэрэг уул уурхайн “акул” хувьцаагаа арилждаг юм. Санхүү, уул уурхайн компаниудын бүртгэлээр дэлхийд толгой цохих Австралийн хөрөнгийн бирж сүүлийн үед монгол компаниудад нэлээд ээлтэй байгааг сануулах юун.

Монголд нүүрсний хайгуулын үйл ажиллагаа явуулдаг “Hunnu coal” компани 2010 оны хоёрдугаар сард Австралийн хөрөнгийн биржид IPO хийж, 20 сая австрали доллар босгосон билээ. Тэгвэл мөн оны арванхоёрдугаар сард Монголын төмрийн хүдрийн хайгуулын “Naganga resources” компани IPO хийж, 25 сая австрали доллар босгосон юм.

Сингапурын хөрөнгийн бирж



SGX нь 1999 оны сүүлчээр байгуулагдсан хөрөнгө оруулалтын “залуухан” холдинг юм. Уг холдингийн мэдэлд байдаг Сингапурын хөрөнгийн биржид 774 бүртгэлтэй бөгөөд тэдгээрийн зах зээлийн үнэлгээ 650 тэрбум сингапур долларт хүрээд байгаа аж. Манай урд хөршийн компаниуд Сингапурын хөрөнгийн биржээс ихээхэн мөнгө босгодог юм байна.

Нью-Йоркийн хөрөнгийн бирж



Уолл-Стрийтийн нэрийн хуудас NYSE нь зах зээлийн нийт үнэлгээгээрээ дэлхийд тэргүүлнэ. Нью-Йоркийн хөрөнгийн биржид бүртгүүлсэн компаниудын үнэлгээ эдүгээ 13.4 их наяд ам.долларт хүрч байгаа юм. 1792 онд хувьцааны 24 брокер “Buttonwood Agreement” гэрээг байгуулснаар уг биржийн түүх эхэлсэн гэж үздэг. Гэвч 1863 онд л өнөөгийн “New York Stock Exchange” нэрээ олж авчээ.

Франкфуртын хөрөнгийн бирж



1993 онд байгуулагдсан “Deutsche Boerse” групп нь 2001 онд Лондоны хөрөнгийн биржтэй нэгдэхээр хэлэлцэж байсан ч бүтээгүй. Уг группийн мэдэлд байдаг Франкфуртын хөрөнгийн бирж нь дэлхийн томоохон биржүүдийн

Судалгаа

Арилжаа хийхэд тохиромжтой үе мөн үү?

МХБ (Монголын хөрөнгийн бирж)-ийн үзүүлэлт улирлын хэв шинжтэй гэж үздэг эдийн засагчид цөөнгүй бий. Зуны улиралд завсаргүй ажиллаж байсан барилга уул уурхайн ихэнх ажил өвөл зогсдог билээ. Түүнчлэн гадаадын жуулчид -40 хэмийн хүйтнээс дайжиж байгаа нь аялал жуулчлалын салбарт ч хүчтэй нөлөөлдөг. Үр ашигтай зах зээлийн онолоор хөрөнгө оруулагчид байгалийн энэ цаг уурын нөлөөллөөс хамааран томоохон биржүүдээс ашиг олох боломж ховор гэж үздэг. Гадаадын бирж дээр Зул сарын үеэр зарим хувьцааны үнэ тухайн компанийн орлого өссөнөөс хамаарахгүйгээр өсдөггүй. Хэдий тийм боловч МХБ-ийн арилжааны идэвх болон хувьцааны үнийн өсөлт улирлын нөлөөллөөс хамаарах хандлага байна. МСС судалгааны баг сүүлийн дөрвөн жилд Монголын хөрөнгийн биржийн

арилжааны үзүүлэлтийг судалж үзлээ. Бид хөрөнгийн биржийн нийт зах зээлийн үнэлгээ, Топ 20 индексийн өөрчлөлт болон арилжааны үнийн дүн зэргийг судалсны үндсэн дээр МХБ-ийн арилжаанд улирлын нөлөөлөл тодорхой хэмжээгээр байдаг гэсэн дүгнэлт гаргаж байна.

Ойрын болон урт хугацаанд МХБ-д нөлөөлж болох хэд хэдэн хүчин зүйл байна:

- Хятадын эдийн засгийн өсөлт
- Ашигт малтмалын үнэ
- Гадаадын хөрөнгө оруулалт болон ашигт малтмалын тухай хууль, тэдгээрийн өөрчлөлт
- Лондоны хөрөнгийн биржээс хийх өөрчлөлт, шинэчлэлт

Эдгээр хүчин зүйлээс гадна МХБ-д орох болон гарах хөрөнгийн урсгал биржийн үзүүлэлтэд нөлөөлнө. Ихэнх

гадаадын хөрөнгийн бирж дээр ийм хандлага байдаг ч МХБ нь хэмжээний хувьд жижиг тул багахан хэмжээний хөрөнгийн орох, гарах урсгал арилжаанд ихээр нөлөөлөх боломжтой байдаг.

Үндсэндээ хөрөнгийн биржийн улирлын хэлбэлзэлд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчид нөлөөлж байна.

Гадаадын хөрөнгө оруулагч:

Зуны улиралд гадаадын жуулчид болон хөрөнгө оруулагчид Монголд олноор ирдэг билээ. Есдүгээр сарын үеэр ажлын шугамаар ирж буй хөрөнгө оруулагчдын тоо ихэсдэг ч арваннэгдүгээр сарын үеэр багасч, өвлийн улирал буюу ялангуяа нэгдүгээр сарын үеэр маш цөөхөн харагддаг. Үүнээс улбаалан зуны саруудад гаднын хөрөнгө оруулалт ихсэх, энэ хөрөнгө


оруулалт нь уг судалгаагаар ажигласан хувьцааны үнийн өсөлтийг тайлбарлаж болох юм.

Дотоодын хөрөнгө оруулагч:

Гадаадын хөрөнгө оруулагчидтай харьцуулахад дотоодын хөрөнгө оруулагчид биржийн арилжаанд арай өөр хандлагаар оролцдог нь ажиглагддаг. Тухайлбал барилга, уул уурхай, хөдөө аж ахуйн секторт ажилладаг хүмүүсийн орлого улирлын шинжтэй байдаг. Хавар болон зуны үед хөрөнгө, санхүүжилтийн хэрэгцээ өсч эсрэгээр намар, өвлийн үед хөрөнгийн хуримтлал бий болж биржийн арилжааны өсөлтийг нэмэгдүүлдэг.

МХБ-ийн үзүүлэлтүүд

Дараах графикаас харахад биржийн үзүүлэлт есдүгээр сараас эхэлж өсөн арванхоёрдугаар сар хүртэл буураад эргээд дөрөвдүгээр сар хүртэл өсдөг хандлага байгааг ажиглаж болно.



Улирлын хэлбэлзэл, цаг хугацаагаар
(2007 оны 9 сар – 2008 оны 4 сар)

МХБ нь 2007 оны зургадугаар сараас харьцангуй идэвхтэй байсан. Доорх графикт 2007 оны есдүгээр сараас 2008 оны дөрөвдүгээр сар хүртэл зах зээлийн үнэлгээ болон ТОП 20 индексийн үзүүлэлтийг харууллаа. Индекс 2007 оны есдүгээр сард оргил цэгтээ хүрээд, арванхоёрдугаар сар хүртэл гурван сарын турш унасан байна. Улмаар 2008 оны гуравдугаар сарын сүүлч хүртэл хоёр дахь өндөр цэгтээ хүрсэн байна.



Тодруулга: Top 20 Индекс 9 сарын 1-нээс 12 сар, 1 сараас 4 сар хүртэлх

өөрчлөлтийг хувиар харуулав

2008 оны 9 сар – 2009 оны 4 сар

Дэлхийн санхүүгийн хямралаас шалтгаалсан ашигт малтмалын үнийн уналт Монголын эдийн засагт сөргөөр нөлөөлсөн ба 2008 он нь МХБ-ийн хамгийн муу үзүүлэлттэй жил байсан. Бусад хөгжиж буй улсын адил Монголын эдийн засаг ашигт малтмалын экспортоос хамааралтай байдаг. 2004 онд уул уурхайн салбараас орж ирж буй орлого ДНБ-ийн таван хувьтай тэнцэж байсан бол 2007 онд 25 хувь болж өссөн ба зэс, нүүрс, цайр, ноолуур, газрын тос болон алт нийт экспортын орлогын 81 хувийг бүрдүүлж байсан. Эдгээр ашигт малтмалын үнэ буурахад (2009 оны 1 сарын үед зэсийн үнэ 64 хувиар унасан) Монголын хөрөнгийн биржид тодорхой хэмжээгээр нөлөөлсөн ба банкны зээл олголт зогсон, хувьцааны үнэ богино хугацаанд унаж эхлэхийн зэрэгцээгээр хувьцаа эзэмшигчид алдагдлаас зайлсхийн өөрсдийн хувьцаагаа зарахад хүрсэн.

2008 оны гуравдугаар сараас эхлэн 11 сарын турш хөрөнгийн зах зээл уналтад орж, 2009 оны хоёрдугаар сарын эхээр тогтворжсон ба 2009 он долодугаар сараас эргээд сэргэж эхэлсэн.

Доорх графикаас харахад улирлын хэлбэлзэл 2008 оны хувьд ажиглагдахгүй байгааг ашигт малтмалын үнийн өөрчлөлттэй холбон тайлбарлаж болно.



Тодруулга: Top 20 Индекс 9 сарын 1-нээс 4 сарын 1-ний хооронд хэрхэн өөрчлөгдсөнийг хувиар харуулав

2009 оны 9 сар – 2010 оны 4 сар

Хямралын дараа 2009 оны сүүлчээр Монголын эдийн засаг эргэн сэргээж МХБ эргээд улирлын циклдээ орж эхэлсэн.

2007 оны хувьд оргил цэг нь есдүгээр сар байсан бол 2009 оны хувьд биржийн үзүүлэлт аравдугаар сард хамгийн өндөр түвшиндээ хүрсэн. Top 20 Индекс аравдугаар сараас эхлэн

хоёр сарын турш унан арванхоёрдугаар сарын үед 25 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа ба 2007 онтой адил 2010 оны нэгдүгээр сараас эхлэн дөрөвдүгээр сар хүртэл өсч эхэлсэн.



Тодруулга: Top 20 Индекс 9 сарын 1-нээс 4 сарын 1-ний хооронд өөрчлөлтийг хувиар харуулав

2010 оны 9 сар- 2010 оны 12 сар

2010 оны есдүгээр сард Top 20 Индекс 15,039 пункт буюу өөрийн өмнө хүрч байгаагүй дээд түвшиндээ хүрсэн. 2010 оны хувьд 2007 болон 2009 онтой ижил зуны саруудад хувьцааны үнэ өсч байсан ба өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй хурдан буюу есдүгээр сарын сүүлчээс индекс өсч эхэлсэн.



Тодруулга: Top 20 Индекс 9 сарын 1-нээс 12 сарын 1-ний хооронд өөрчлөлтийг хувиар харуулав

MICC судалгааны баг сүүлийн дөрвөн жилд Монголын хөрөнгийн биржийн арилжааны үзүүлэлтийг судалж үзлээ. Бид Хөрөнгийн Биржийн нийт зах зээлийн үнэлгээ, Top 20 индексийн өөрчлөлт болон арилжааны үнийн дүн зэргийг судалсны үндсэн дээр МХБ-ийн үзүүлэлт улирлын нөлөөллөөс тодорхой хэмжээгээр хамаардаг гэж үзэж байна.

Судалгаа хэвлэсэн өдөр: 2011.01.05
Судалгааг бичсэн: Томс Флахий,
Золзаяа Энхбат



ШИНЭ МОНГОЛЫН
СОНГОЛТ



Вэб: www.kmm.mn И-мэйл: info@kmm.mn Утас: 50111212, 99114716, Факс: 50111214

Highline Cruiser

SORENTO



KIA MOTORS
MONGOLIA

Туулай жилийн төсөв үсрэнгүй хөгжилд хүргэх үү, өвчин дагуулах уу?



М.Чимэгээ

Эдийн засгаа эргэж нэг харахуй. Зэсийн үнийн уналт, төсвийн алдагдал, банк, барилгын салбарын доройтол гээд хэцүү бүхнийг аль хэдийнэ ардаа орхижээ, бид. 2010 онд манай эдийн засаг зургаан хувиар өссөн бол энэ онд уг үзүүлэлт 10 хувьд хүрэх таамаглал бий.

Ирэх 10 жилд Монголын нэг хүнд ногдох орлого дөрөв дахин нэмэгдэнэ гэсэн тооцоог олон улсын байгууллагууд гаргасан. Зэс, алт, нүүрс, ураны нөөцөөрөө Казахстан, Австралийг нийлүүлсэн мэт их нөөцтэй Монгол орон дэлхийн эдийн засгийн тавцанд хамгийн өндөр өсөлттэй улс болох боломжтойг “Ренессанс капитал” хөрөнгө оруулалтын банкны шинжээч Роланд Нэш бичиж байв. Тэр ч байтугай Азийн дараагийн “Бар”, “Монголын чоно” эдийн засагтай орон болно гэсэн томъёоллыг ч гаргаж амжсан. Эдийн засагчид манай ирээдүйг ийнхүү гэгээлгээр харах учир шалтгаан бий.

2010 онд Монголд шингэсэн

гадаадын шууд хөрөнгө оруулалт түүхэнд анх удаа нэг тэрбум доллараас нэлээд давсан. Харин энэ онд дээрх үзүүлэлт гурван тэрбум долларт хүрч магадгүйг мэргэжилтнүүд тооцоолжээ. Товчхондоо, туулай жил санхүү, эдийн засгийн шинэ үе, өндөр өсөлт, монголчуудын хэзээ ч хараагүй их мөнгийг даллаж байна. Энэ завшааныг ашиглан иргэдийнхээ амьжиргааг дээшлүүлж, бизнес эрхлэгчдийнхээ үйл ажиллагааг өргөтгөх нөхцөлийг бүрдүүлж чадах эсэх нь төр засгийн бодлогоос л хамаарах юм.

Ямартай ч 2011 оны Монголын эдийн засгийн өнгийг шинжихүй.

Эрх баригчдын эдийн засгийн бодлогыг харуулах хамгийн том баримт бол мэдээж төсөв. Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойших хамгийн том, данхар төсөв бол 2011 оных болж байна. ДНБ-ий 52.1 хувьд хүрсэн туулай жилийн төсөв нь төр эдийн засагт тохойгоо хүртэл гар дүрж эхэлсний дохио болох шиг. Үүнийг эрх баригчид эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн

эхлэл хэмээн тайлбарлаж байна. Үнэн гэж үү?

ДНБ-ий өсөлт (хувиар)



Үсрэнгүй хөгжил гэж бид яг юу хэлж, ойлгоод байгаа юм бэ? Эдийн засаг тоон утгаараа өсөөд байхыг хэлж байна уу, эсвэл Монголын иргэн бүрийн аж амьдрал дээшлэхийг хэлээд байна уу? Энэ хоёр ойлголтын хооронд ихээхэн ялгаа байгааг түүхийн хуудас гэрчилнэ. Монголын эдийн засаг 2006 онд 8.6, 2007 онд бүр 10.2 хувиар өсөж байсан. Гэтэл аль 1990-ээд онд ядуурлын түвшин

35 гаруй хувьтай байсан бол өнөөдөр ч энэ дүр зураг хэвээр байна шүү дээ. Товчхондоо, эдийн засгийн өсөлт хэчнээн өндөр гарлаа ч энгийн иргэдийн амьжиргаа нэг түвшиндээ байсаар. Харин одоо төсвийн задаргаандаа эргээд анхаарлаа хандуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвөөс 2011 онд дөрвөн их наяд төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн нь орлогоосоо 780 орчим тэрбум төгрөгөөр давж, манай нийт эдийн засгийн 10 хувьтай дүйцэж, рекорд тогтоожээ. Тэр их зарлагынхаа дийлэнх хэсгийг дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролын салбарт шингээвэл бас ч гэж аргатай. Ажлын байр бий болж, монгол хүн эрүүл саруул амьдарч, сурч боловсрох нөхцөл сайжрах байлаа. Гэтэл ийм чиглэлийн хөрөнгө оруулалт өнгөрсөн оныхоос ч буурсан байгааг юу гэж ойлгох вэ?

2010 оны төсвийн тодотголоос үзэхэд хөрөнгө оруулалтад 664 тэрбум төгрөг зарцуулсан байна. Гэтэл 2011 оны батлагдсан төсвөөс үзэхэд энэ тоо 627.7 тэрбум төгрөг болж буурсан байх юм. Эрүүл мэндийн салбарт ердөө 54.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийхээр төлөвлөжээ. Гэтэл улс төрийн амлалт биелүүлэхэд үүнээс 16 дахин их буюу 805.2 тэрбум төгрөг төсөвлөсөн нь данхайсан төсвийн зарлагыг тав хуваасны нэгтэй тэнцэж байгаа юм. Ингэхэд хүн бүрт 21 мянган төгрөг тараалаа гээд Монгол Улс үсрэнгүй хөгжилд хүрнэ гэдэгт Та итгэж байна уу?

Дээрх 21 мянган төгрөгийг тараахад манай төсвийн чадал, чансаа даанч хүрэлцэхгүй. Дэлхийн зах зээл дэх зэс, алт, нүүрсний үнэ өндөр байвал л энэ мөнгийг тараах эх үүсвэр бүрдэх юм. Аз болж туулай жилийн гараа амжилттай болж, Лондоны металлын биржид тонн зэсийн үнэ 10 мянган ам.доллараас давсан бол Нью-Йоркт унци алт 1350 ам.доллараас дээш үнээр арилжаалагдаж байна. Энэ эрчээрээ яваад байвал бид ч сар бүр 21 мянган төгрөгөө авсаар байх нь, ашгүй дээ. Гэхдээ дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ өсдөг шигээ буурдгийг санацгаая.

2008 оны зун 8000 ам.долларт хүрсэн тонн зэсийн үнэ хагас жилийн дотор 2770 ам.доллар болтлоо шалдаа буухад манай төр, засаг яалаа даа? Хуримтлуулсан юмгүй хөөрхий эрх баригчид маань бүсээ чангалж, бадар барьсан. Бэлэн мөнгө тараахаа больж, бүр хүүхдүүдээс хүртэл хэдэн бор юмаа “харамласан” бус уу. Дахиад ийм байдалд орохгүйн тулд өнгөрсөн зургадугаар сард УИХ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль баталсан.

Уг хуулийн гол санаа нь орлого ихтэй үед нөөц бүрдүүлж, хэцүү үед түүнийг зарцуулахад оршиж буй. Гэтэл нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох, тухайн жилийн төсвийн зарлагын өсөлтийн хэмжээ ДНБ-ий хоёр хувиас хэтрэхгүй байх зэрэг дээрх хуулийн амин судас болсон шаардлагууд 2013 оноос л үйлчилж эхлэхээр заасан байгаа юм. 2011 оны төсвийн алдагдлыг ДНБ-ий 10 хувьтай дүйцэх хэмжээнд баталсан нь УИХ өөрөө гаргасан хуулиа уландаа гишгэж буйг харуулна. За за, амны бэлгээс ашдын бэлгэ. “Ашигт малтмалын үнэ өссөөр байх болтугай!” хэмээн ерөөхийн хажуугаар төсөв тэлж байгаа нь монголчууд бидний хийж бүтээж байгаа зүйлээс бус, уул уурхайн зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс л хамаарч байгааг сануулах гэсэн юм.

Төсвийн зардал
(ДНБ-д эзлэх хувиар)



Уул уурхай гэснээс 2005 онд эрдэс баялгийн салбар манайд орж ирсэн гадаадын нийт хөрөнгө оруулалтын 58 хувийг эзэлж байсан бол өнөөдөр энэ үзүүлэлт 80 хувьд дөхөж очих нь. 2010 оны байдлаар

Монголын уул уурхайн салбар ДНБ-ий 30, экспортын 85 гаруй хувийг бүрдүүлж байсан бол туулай жилд энэ хэмжээ улам л тэлэхээр байгааг анхаарууштай. Зөвхөн “Айвенхоу майнз” компани л гэхэд энэ онд Оюутолгойн уурхайн барилгын ажилд 2.3 тэрбум ам.доллар зарцуулахаар болсноо зарласан. Хажуугаар нь Тавантолгойн асуудал шуударч байгаагаас энэ онд ийшээ ихээхэн мөнгө урсаж орох нь гарцаагүй боллоо. Туулай жилд Монгол оронд гурван тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх таамаглал байгааг дээр дурдсан шүү дээ. Их мөнгөний сураг сайхан л дуулдана, гэхдээ...

1959 онд Нидерланд улсад байгалийн хийн олон орд байгааг мэдэхэд улс орнууд их хэмжээний хөрөнгө энэ нутагт оруулах болсон. Бэлэн мөнгөнд хууртагдсан голландчууд 1970-аад онд хүнд бэрх цагтай нүүр тулсан билээ. Их мөнгө дандаа сайн сайхныг авчирдаггүйг харуулсан энэ туршлага хожим нь “Голланд өвчин” хэмээн нэрлэгдэж, Саудын Араб, Нигер, Мексик зэрэг орныг нэрвэж дөнгөсөн. Харин Монгол Улс энэ томоохон сорилтын өмнө өнөөдөр ирээд байгааг олон улсын байгууллагын мэргэжилтнүүд анхааруулж буй.

“Голланд өвчин” гэдгийг хамгийн энгийнээр тодорхойлбол үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш хэт чангарч, уул уурхайгаас бусад салбар өрсөлдөх чадвараа алдахыг хэлнэ. Тэгвэл 2010 онд ам.долларын эсрэг дэлхийн хэмжээнд хамгийн ихээр чангарсан мөнгөн тэмдэгтээр манай “төгрөг” шалгарсан тухай “Bloomberg” мэдээлсэн. Үүний зэрэгцээ 2010 онд уул уурхайн салбар Монгол Улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын 71 хувийг эзэлж байхад харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт ердөө нэгхэн хувь нь ногдсон байх жишээтэй.

Голланд өвчний үүр болж, баялгийн хараал тусахгүйн тулд ашигт малтмалын орлогоороо уул уурхайн бус салбаруудаа босгож ирэх шаардлага тулгамдаж байна. Ингэж байж л Монгол Улс үсрэнгүй хөгжилд хүрч, манайд орж ирж буй их мөнгө энгийн иргэдийн амьдралд өөрчлөлт авчрах тухай эдийн засгийн

2011 оны эдийн засгийн төлөв байдлыг та хэрхэн үзэж байна вэ?

Л.Энхтайван:

/Санхүү, эдийн засаг, бодлогын судалгааны төвийн тэргүүн/

-Өнгөрсөн онтой харьцуулахад эдийн засгийн өсөлт хурдасна. Гэхдээ хүлээж буй өсөлт гадуур ярьж байгаа шиг дээшлэхгүй л болов уу. Хамгийн гол нь эдийн засгийн өсөлт эрүүл, зах зээлийнхээ зарчмаар явах ёстой. Буруу тийшээ хазайхаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд авах шаардлагатай.

“Голланд өвчин” гэдэг нь манайд улам л мэдрэгдээд байна шүү дээ. Энэ нь бүтээн байгуулалт, нийгэм, иргэдийн сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх вий. Харин манай улсын гадаад нөхцөл байдал гайгүй байна. Дэлхийн зах зээл дэх зэс, алтны үнэ харьцангуй тогтвортой байх хандлагатай байгаа нь сайн хэрэг.

Ч.Отгочулуу:

/Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн захирал/

-Туулай жилийн эдийн засгийг өөдрөгөөр харж байгаа. 2011 онд ДНБ 10 хувиар өснө гэсэн таамаглал байгаа нь биелэх болов уу. Монголын экспортод жин дардаг зэс, нүүрсний үнэ нэлээд өндөр байх төлөвтэй. Энэ нь мэдээж манай эдийн засагт эерэг үр дагавартай. Түүнчлэн Оюутолгой, Тавантолгойн бүтээн байгуулалт ч баялгийг бий болгож байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх хандлагатай. Үүний хажуугаар банк санхүү, хөрөнгийн зах зээлийн шинэтгэл эдийн засагт нэлээд сайнаар нөлөөлөх байх. Мэдээж бэлэн мөнгө тарааж байгаагаар холбоотойгоор инфляци өсөх эрсдэл бий. Гэхдээ өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ тийм ч айхтар өсөхгүй гэж найдаж байна. ■

Глобал эдийн засаг

Хүнсний хямралын айдас, байгалийн баялгийн амт



Дэлхийн эдийн засаг 2008 оноос яагаад хямарч эхэлсэн бэ?

Ертөнцийн хүмүүс улам бүр завгүй болохын хэрээр гэр бүлийнхэндээ тавих анхаарал халамж хомс болж, бие биенээ гэх сэтгэл дутаж, үр хүүхдүүдтэйгээ тоглож наадахаас өгсүүлээд хүмүүсийн хоорондын үнэт харилцаа алдагдсанаас болсон гэсэн сонирхолтой дүгнэлтийг Давосын дэлхийн эдийн засгийн чуулганд

оролцогчид хийсэн. Түүнчлэн хямрал айлчилсан бас нэгэн шалтаг нь цаг уурын өөрчлөлттэй холбоотой гэдгийг мөн эл уулзалтаар тодорхойлсон. Тиймээс ч сүүлийн жилүүдэд дэлхий нийт хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг руу шилжих чиглэлд явж байгаа бол дээрх уулзалтаар цэнхэр эдийн засгийн тухай асуудал шинээр гарч ирсэн билээ. Тиймээс 2011 оноос дэлхийн улсууд цэнхэр, ногоон эдийн засгийн хөгжилд оюун бодлоо уралдуулж, түлхүү анхаарахаар тохиролцов.

Дэлхийн банкнаас гаргасан 2011 оны дэлхийн эдийн засгийн төлөвд дурдсанаар дэлхийн эдийн засаг хямралын дараах байдлаас сэргэлтийн үеийн өсөлтийн шатанд аажмаар хийгээд тууштай шилжиж байгаа аж. Түүнчлэн тус төлөвд дэлхийн эдийн засгийн өсөлтийн бараг тэн хагас нь хөгжиж байгаа орнуудад

ногдож байгаа хийгээд эдийн засгийн чадамж өмнөд бүс рүү шилжиж байна хэмээн тэмдэглэсэн нь ч бий. Тиймээс Европын холбоо, АНУ зэрэг дэлхийн эдийн засгийг тодорхойлогч орнууд сүүлийн үед эдийн засгаа өсгөх биш, яаж энэ хэмжээнд нь тогтоон барих вэ гэж толгойгоо гашилгах болжээ.

Дэлхийн эдийн засагт хямрал цаашилсан хэдий ч хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт харанга дэлдэж магадгүй байна. Тухайлбал, тунистууд Ерөнхийлөгчөө огцруулж, хүнсний өндөр үнийг тэвчиж чадаагүй Египетэд эмх замбараагүй байдал хэдийнэ бий болсон. Тэрбайтугай, баян цатгалан байдлаараа дэлхийд дээгүүр жагсдаг Саудын Арабад өргөн хэрэглээний барааны үнэ энэ онд есөн хувь хүрч өсөх төлөвтэй байгааг эдийн засагчид тооцоолжээ. Улаан буудайн тариалалт арвинтай ОХУ өнгөрсөн зун их хэмжээний ургац алдсан

бол Авсртали орон үер ус, далайн шуургад ч мөн л ургацаа алдчихаад уруу царайлж сууна. Н Ү Б - ы н Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын судалгаагаар махнаас бусад хүнсний таваарын ханш, ялангуяа элсэн чихэр, улаан буудайн үнэ хэт өссөн тухай таагүй мэдээ дуулдав. Индонезид орсон ширүүн бороо тутаргын талбайг нь сүйтгэж, Засгийн газар нь цагаан будааны эрэлд морджээ. 2011 онд иймэрхүү хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой бараан мэдээлэл дэлхийн өнцөг булан бүрт дуулдахаар байна. БНХАУ-д гэхэд л сүүлийн дөрвөн сарын турш банкны зээлийн хүү нэмэгдсэн нь орон сууц, үл хөдлөх хөрөнгө болон хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлсөн хэмээн ажиглагчид дүгнэжээ. Хятадын Засгийн газар үнийн өсөлтөд анхаарах болно гэдгийг албаны хүмүүс онцолсон байна.

Хүнсний үнэтэй холбоотой иймэрхүү бараан мэдээлэл дэлхийн өнцөг булан бүрт гэнэт дуулдаж байгаа ч биш юм. Давосын уулзалтыг угтаж, 580 гаруй нэртэй улстөрч, эдийн засагч, эрдэмтэд оролцож бэлтгэсэн

“Даяаршлын эрсдэл-2011” илтгэлд хамгийн их эрсдэл дагуулах нь цаг уурын өөрчлөлт гээд дэлхийн эдийн засагт нэг их наяд орчим ам.долларын хохирол учруулна гэжээ. 37 төрлийн эрсдэлд дүгнэлт өгснөөс хамгийн томоохон нь цаг уурын өөрчлөлт орж байгаа бөгөөд санхүүгийн хямрал, геополитикийн үл ойлголцол зэргийн дагуулах эдийн засгийн хохирол нь тус бүр нэг их наяд ам.доллар байхаар жагсаажээ. Хамгийн хэцүү нь өнөөдөр нэгэнт үүссэн цаг уурын өөрчлөлтийн дээрх эрсдэлийг багасгах ямар ч арга байхгүй гэдгийг Дэлхийн эдийн засгийн чуулганд оролцогчид онцолсон байна. Тиймээс дэлхий нийтээр зөвхөн ногоон биш, цэнхэр эдийн засагт анхаарах хэрэгтэйг ч зөвлөсөн аж. Эдийн засгийн чадамж өмнөд бүс рүү шилжиж байна гэсэн Дэлхийн банкны дүгнэлтийг хятадын ДНБ-ий огцом өсөлт улам бүр баталгаажуулсаар. Өнгөрсөн оны дөрөвдүгээр улирлын байдлаар тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 9.6-9.8 хувьтай гарчээ. Уг нь бол шинжээчид урд хөршийн эдийн засгийн өсөлтийг буурна хэмээн таамаглаж байсан ч


өнгөрсөн оны арваннэгдүгээр сард 5.1 хувьд хүрч, сүүлийн 28 сард байгаагүй дээд амжилт тогтоосон удаатай.

Мөн түүнчлэн 2011 онд дэлхийн эдийн засгийн гол хүчин зүйл нь байгалийн баялаг болж хувирч байна. Өндөр технологидоо дулдуйдан бусдаас түүхий эд авч боловсруулаад буцаан зардаг одоогийн хэв маяг үгүй болсноор байгалийн баялаггүй орнуудын эдийн засаг уналтад орж эхэлжээ. Өнөөдөр Энэтхэг, Вьетнам зэрэг урьд нь төдийлөн анхаарал татаж байгаагүй орнуудын эдийн засаг жилд 10 орчим хувиар өсч байгаа бол газрын тосны асар их нөөцтэй Бразил, нүүрс, үнэт металлын нөөц ихтэй Чили, Канад, Перу зэрэг орнууд хөрөнгийн биржийн гол тоглогчид болж, дэлхий нийтийн хэрэгцээний дийлэнхийг хангах аж. Манай улс ч эдгээр орны тоонд багтаж эхэлсэн байгаа.

Тэгэхээр туулай жилийн дэлхийн эдийн засгийн өнгийг шинжвээс Давосын уулзалтаар уриалсан цэнхэр,ногоон өнгийг чухалчилсан хүнсний бүтээгдэхүүний үнийн айдас, байгалийн баялгийн амтыг мэдэрсэн жил байх бололтой. ■

Ногоон эдийн засаг

Дэлхийн шинэ хандлага ба ногоон хөгжил



Өмнөд Солонгос далайгаар хүрээлэгдсэн ногоон улс мөртлөө Засгийн газраас нь ногоон хөгжлийг эрчимтэй дэмжиж, тусгай бодлого боловсруулан ажиллаж байна. Бүр мужаараа, дүүргээрээ, гудамжаараа ногоон болохын төлөө солонгосчууд идэвхи

санаачилгатай ажиллаж байна. Харин төрөөс нь орчин тойрноо, компанийн үйлдвэрлэлээ ногоон болгоход анхаарч ажилласан байгууллага, хувь хүнийг урамшуулан, үйл ажиллагааг нь дэмждэг аж. Ер нь дэлхийн олон улс орон уламжлалт хөгжлийн загвартаа өөрчлөлт хийж, дэлхийн хөгжлийн шинэ хандлагыг даган бодлого, төлөвлөгөөгөө боловсруулаад явж байна.

Харин манайх шинэ хөгжлийн аянд хөл нийлүүлэн алхах талд нэлээд хойрго хандаад байна уу даа гэсэн бодол төрөх. Нэгэн эрдэмтний манай улсыг хөгжлийг яст мэлхийн хурдтай зүйрлэсэнтэй адил ногоон хөгжилд ч мөн тийм байдлаар хандаж байна. Нөгөө талаар уул уурхайн баялагтаа хамаг анхаарлаа төвлөрүүлээд байгаль орчны асуудлыг хойш нь тавиад буйг эрдэмтэн докторууд ярьж, хэлсээр байгаа билээ. МҮХАҮТ-аас ногоон эдийн засаг, бизнесийг хөгжүүлэх анхны санаачилгыг гаргаж, олон ажлыг эхлүүлсэн. Тухайлбал, 3 Ц буюу цэвэр байгаль орчин, цэвэр хүнс, цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд, тухайлбал, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааг ногоон

хөгжил рүү чиглүүлэх, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах, оны шилдэг компаниудыг шалгаруулан урамшуулахдаа ногоон чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлыг нь голлох зэрэг арга хэмжээг авч ажиллаж байгаа. Мөн “Бизнесийн орчны шинэтгэлийн жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд заасны дагуу Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих үндэсний хөтөлбөр (“Таван 20”)-ийг боловсруулаад байна.

Хөтөлбөрийн үндсэн зорилго нь 20/20/20/20 буюу 2020 он дуустал хугацаанд

- эрчим хүчний үр ашгийг 20 хувиар нэмэгдүүлэх,
- сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг суурилагдсан чадлын 20 хувьд хүргэх,
- хүлэмжийн хийн ялгарлыг 20 хувиар бууруулах,
- байгальд оруулах хөрөнгө оруулалтыг 20 хувиар нэмэгдүүлэх,
- “Ногоон худалдан авалт”-ыг Засгийн газар, орон нутгийн төсвийн нийт худалдан авалтын 20 хувьд хүргэхэд чиглэжээ.

Одоо уг хөтөлбөрийг Засгийн газартай хамтран амьдралд буулгаж, хэрэгжүүлэх л ажил үлдээд байгаа аж.

Хэдийгээр төрийн бус байгууллагуудаас байгаль эхээ хайрлан хамгаалах, байгаль дэлхийд хал балгүй үйлдвэрлэл явуулах санаачлага гаргаж, ажиллаж байгаа ч хамгийн гол нь төрийн зүгээс тууштай дэмжиж, хөрөнгө оруулалт хийж, хөгжин дэвшихийн дэлхийн шинэ өнгө төрхтэй хөл нийлүүлэн хурдацтай алхах шаардлагатай байна. ■

Ч.Ганхуяг:

Хямралыг хүмүүс хоорондын харилцааны үнэт зүйлс алдагдсантай холбон тайлбарласан

Сангийн дэд сайд Ч.Ганхуягтай уулзаж, Дэлхийн эдийн засгийн чуулган болон Монголын эдийн засгийн форумын талаар товч ярилцлаа.

-Дэлхийн эдийн засгийн чуулганаас ямар шинэ санаа өвөртлөн ирсэн бэ?

-Гуравдугаар сард болох Монголын эдийн засгийн чуулган болон Донорын техникийн зөвлөгөөнд Давосын форумын багийнхан ирж оролцохоор боллоо. Уул уурхайтай, ялангуяа хариуцлагатай уул уурхай, ил тод байдал, авлигагүй уул уурхайтай холбоотой салбар дугуй ширээний ярилцлагууд зохион байгуулахаар болсон. Мөн зарим нэг томоохон төслүүд дээр хамтарч ажиллах шийдвэрт хүрсэн байгаа.

Дэлхийн залуу манлайлагчынхаа хувьд хэд хэдэн шинэ санааг хэрэгжүүлэхээр ярилцсан. Дэлхийн залуу манлайлагчдаас 11 хүнийг сонгоод Монголын сайн дурын сайн санааны элчээр сонгон шалгаруулж, Засгийн газрын дэргэд зөвлөл байдлаар ажиллуулах санаа байна. Тэдгээр элч жилд нэг удаа хүрч ирээд Монголын нөхцөл байдалтай танилцаад бусад оронд ийм байдаг, танайд ийм байвал ямар вэ гэсэн байдлаар санал бодлоо хуваалцаж ажиллахаар төлөвлөгөөнд тусгаад явж байна. Дэлхий даяар явах



энэхүү төслийн анхныхыг туршилтын байдлаар Монголд хэрэгжүүлнэ. Монголд дэлхийн залуу манлайлагчдыг зөвлөлийг байгуулж, дэлхийтэй харилцах харилцаагаа улам сайжруулж, тэдэнтэй ойрхон ажиллъя. Газрын хөрсөнд нуугдах их баялгаасаа болоод үндсэрхэг үзэл гаргахаас зайлсхийж, харилцан ашигтай нэг дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн гэдгээ санаж ажиллах ёстой монголчууд бид.

-Өнөө жилийн Дэлхийн эдийн засгийн чуулганы онцлог юу байв?

-Бодит шинэ нөхцөл байдалд бид дэлхий нийтээрээ мөрдөх үнэт зүйл юу вэ гэсэн утга бүхий уриатай зохион байгуулагдсан. Чуулганы хурлын сэдвүүд маш өргөн цар хүрээг хамарсан байдаг. Технологийн, эрүүл мэнд, байгаль орчин, аюулгүй байдал, эрсдлийн удирдлага, санхүүгийн шинэ арга хэрэгсэл, төрийн дэмжлэг, засагт оролцох оролцоо, харилцааны технологи, бизнесийн стратеги, байгалийн баялгийг хэрхэн удирдахав, ядууралтай хэрхэн яаж тэмцэхэв гэх мэтээр өргөн хүрээнд болсон. Хятад,

Энэтхэг, Бразил улсуудын хөгжлийн сэдвээр тусдаа салбар хуралдааныг зохион байгуулсан. Хамгийн гол нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн зохицож амьдрах, улс орнууд ямар бодлого явуулах, байгалийн энэ үзэгдэлтэй хэрхэн яаж тэмцэхэд анхаарал хандуулах чиглэлээр гол асуудлуудыг хөндөж ярилцсан байгаа.

Ер нь таван өдрийн турш өглөөнөөс орой хүртэл үргэлжлэх хуралдаануудад бүгдэд нь суух ямар ч боломжгүй. Миний хувьд дэлхийн эдийн засгийн чуулганд дэлхийн залуу манлайлагчийн хувиар хоёр дахиа оролцлоо. Санаа бодлоо хуваалцах, шинэ санаа дэвшүүлэх, ойлголцлыг нэмэгдүүлэх боломж олгосон хурал болдог. Дэлхийн эдийн засгийн чуулган нь хамгийн ажил хэрэгч, үр дүнтэй, улс орнуудын өндөр албан тушаалтнууд нэг дор уулздаг хурал гэж ойлгодог. Монгол Улсыг төлөөлж Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцсон. Дэлхийн залуу манлайлагч гэж 700 гаруй хүн байдаг. Үүнээс 100-г нь урьж оролцуулсан. Анхны хуралд оролцоод амалсан ажлуудаа ажил хэрэг болгосон учраас



Фотог: Б.Бямба-Очир

намайг тус чуулганд хоёр дахь удаагаа оролцох боломж олгосон.

-Ямар амлалтууд байсан бэ?

-Даян дэлхийн нэр төрөө эрхэмлэх өдрийг Монголдоо хоёр жил дараалан тэмдэглэсэн. Сургуулийн хүүхдүүдэд нэр төртэй амьдрах, нэр төрөө хайрлан эрхэмлэж явахын утга учир, эцэг эхээс хайрласан нэрээс гадна хийсэн бүтээсэн ажил үйлсээрээ сайшаагдаж, олны дунд дурсагдаж явах талаар цуврал лекцүүд зохион байгуулсан. Дэлхийн эдийн засгийн форумын Дэлхийн залуу манлайлагчдын форумас санаачилсан тамхинаас гарах, тамхины хорт зуршлаас урьдчилан сэргийлэх төслийг дунд сургуулиудад эхлүүлсэн. Энэхүү төсөл мөн дэлхий даяар хэрэгжих юм. Дээр нь даяар мөрдөх бизнесийн андгайг хэрэгжүүлж байна.

Хэдэн жилийн өмнөөс эхэлсэн дэлхийн эдийн засгийн хямрал юунаас үүдэлтэй талаар ярилцахад хүмүүсийн хоорондын харилцааны үнэт зүйлс алдагдсантай холбоотой гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг. Биенээ хүндэлж хайрлах хандлага, сурсан мэдсэнээ хуваалцах, гэр бүл дотроо ч үнэт зүйлсийг төлөвшүүлж чадахгүй байна. Хүүхэдтэй кино нь зодоон цохионтой хүүхдийн сэтгэхүйд сөргөөр нөлөөлөхүйц, телевизээр нь ч ихэнхдээ л элдэв муу зүйлсийг гаргаж байна. Эцэг эхчүүд үр хүүхэддээ цаг гаргаж чадахгүй байна. Үүний нэг жишээ нь би өөрөө юм. Бид үр хүүхэд, ач зээтэйгээ чин сэтгэлээсээ тоглож наадаж чаддаг бил үү. Тэгэхээр энэ нь өөрөө нийгмийн харилцааг эрүүл бус болгоход нөлөөлж буй тухай ярьж байна. Ялангуяа дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж буй бизнесийн удирдагчид ёс зүйтэй байх ёстой. Зөвхөн ашгийн төлөө бус ажиллахыг өнөөгийн нийгэм шаардах боллоо. Өөрөөр хэлбэл, бизнесмэнүүдийн гаргаж буй шийдвэр орчин тойрон, улмаар иргэд, улсад ч эерэгээр болон сөргөөр нөлөөлдгийг олон жишээ харуулна. Тухайлбал, Багануур дүүрэг дэх архины үйлдвэрийн буруутай үйл ажиллагаанаас хэдэн хүн хохирсон билээ, мөн алтны зарим компанийн хууль бус үйл ажиллагаанаас байгаль орчин хэр бохирдож, сүйтгэгдсэнийг харж болно.

Сайн бизнесийн жишээ ч олон бий. Нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, өнчин өрөөсөн, зовсон зүдэрсэн хүмүүст сайхан сэтгэл гаргаж ажиллаж буй олон компани бий манайд. Цаг үеэ дагасан нийгмийн өөрчлөлттэй уялдан бизнесийн удирдагчид, ялангуяа бизнесийн удирдлагын чиглэлээр сургуулиа төгсөхдөө Анагаахын их сургуулийн оюутнууд шиг бизнесийн андгай өргөж, гарын үсэг зурж, түүнийхээ дагуу ажиллаж амьдрая. Энэхүү сайн санааны аяны утга учир, ач холбогдлыг манай олон компанийн удирдлага ойлгон нэгдэж, гарын үсэг зурсан. Тухайлбал, MCS электроникс, Ньюком, Мобиком, Петровис гэх мэт. Хамгийн гол нь бизнесмэнүүд миний хариуцлагагүй шийдвэр хувь нийлүүлэгч, ажилтнууд, харилцагч үйлчлүүлэгчид, улмаар

ард иргэд, улсад сөргөөр нөлөөлөх вий гэдгийг ухамсарлан ойлгодог байх ёстой.

-Монголын эдийн засгийн чуулганыг хоёр дахь жилдээ зохион байгуулах гэж байна. Ямар асуудлуудыг хэлэлцэхээр төлөвлөж байгаа вэ?

-Ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байна. Өмнөх жил ярилцаагүй сэдвээр зохион байгуулъя гэсэн зарчмын шийдвэр гаргасан. Хүний хөгжил, боловсролын шинэчлэл, компанийн засаглал, санхүүжилт, Төрийн албаны шинэчлэл, байгалийн нөөц ба зөв засаглал, нийгмийн хамгаалалын шинэчлэл гэсэн сэдвүүдийн хүрээнд харилцан ярилцаж, улс орныхоо хөгжлийн төлөө санал бодлоо уралдуулна.

Гол онцлог нь Дэлхийн эдийн засгийн форумас төлөөлөгчид ирж оролцоно. Гурав дахь өдөр нь Монголын хөрөнгө оруулалтын чуулга уулзалт болно. Энэхүү уулзалтад хувийн хэвшлийн компаниуд оролцож, асуудлаа ярьж, тодорхой төслүүдийг хөрөнгө оруулагчдад тавьж танилцуулах боломжтой. Хэлбэрийн хувьд Дэлхийн эдийн засгийн форумын зарчмаар явуулна. Өнөө жил Харвардын их сургуулийн профессор Жеффри Франкел Монголын эдийн засгийн чуулганд ирж оролцож, “Байгалийн баялгийн хараал, судалгаа” нэртэй лекц уншина. Монголчууд бидний хувьд асар их баялаг дээр сууж байгаа нь үнэн. Гэхдээ баялгаа эдийн засгийн эргэлтэд оруулахдаа маш зөв бодлого явуулж, иргэддээ тустай, байгальдаа ээлтэй байх талд хатуу зогсох шаардлагатайг өнөөдрийн нөхцөл байдал харуулаад байгаа. Тиймээс баялгийн хараал яагаад болдог талаар энэ хүн ярих болно.

-Та Сангийн дэд сайдын суудалд суугаад удаагүй байна. Энэхүү албандаа хэр дасаж байна вэ?

-Хоёр сар гаруй хугацаанд ажиллалаа. Ажлын цар хүрээ өргөн, хийх ажил ихтэй, хариуцлага өндөр алба юм. Би ажлыг ажил гэж хүлээн авдаг. Өмнө нь олон ажил хийж үзсэн. Миний амьдралд, мэргэжлийн хүний хувиар нэг шинэ үеийг тодорхойлсон, дайрах ёстой алба байж гэж хүлээн авсан. Дэд сайдын ажлын хүрээнд гааль, татварын газрууд багтаж байна. Үндэсний нягтлан бодох бүртгэлийн үнэдэсний хорооны дарга, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилготой Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ахлагчаар томилсон. Банк санхүүгийн байгууллагыг тогтвортой илүү сайн хөгжүүлэх, сайн ажиллаж чадахгүй байгаа банкуудын үйл ажиллагааг сайжруулах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх гэх мэтчилэн хийх ажил, шийдэх асуудал их байна. Монголын хөрөнгийн биржийн удирдлагыг солихоор хөрөнгийн зах зээлийг хөгжүүлчихнэ гэж ойлгож болохгүй. Ийм зах зээлд оролцдог хөрөнгө оруулагчдын бүтцийг өөрчлөх, даатгалын салбар, брокер дилерийн байгууллагуудыг чадавхжуулах, тэтгэврийн сангийн шинэчлэлийг хийх зэргээр цогцоор нь шийдэх шаардлагатай л даа. Мөн Засгийн

газраас бонд гаргах, иргэдэд мөнгө өгвөл хэрхэн ямар арга замаар тараавал эдийн засагт нөлөөлөх нөлөөлөх бага байх уу гэсэн асуудлууд байна.

-Олон иргэн бэлэн мөнгө тараахын оронд тэр мөнгөөрөө ажлын байр бий болговол илүү үр дүнтэй гэсэн байр суурьтай байгаа шүү дээ?

-Бэлэн мөнгө тараах нь зөв, буруу гэсэн байр суурь явж байгаа. Уг нь сонин сэтгүүлийн газрууд иргэдийн дунд түүвэр судалгаа хийгээд асуудлыг гаргаад ирвэл улстөрчид цаашдын шийдвэрүүдээ харж үзэх боломжтой гэж бодогдох юм. Ард иргэдийн хэдэн хувь нь мөнгөө авах, хэдэн хувь нь улсаас өгөх мөнгийг ирээдүйн хуримтлал үүсгээд явах талаар тодорхой судалгаа хийх талаар судалгааны газрууд ч бас санаачилга гаргаж болно шүү дээ.

-Төсвийн тогтвортой байдлын хуулиар төсвийн алдагдлыг 5,5 хувиас хэтрүүлж болохгүй гэсэн заалт бий. Энэ жилийн төсөв энэ заалтыг нэлээд зөрчиж батлагдсан нь эдийн засагт хэр нөлөөлөх бол?

-Төсвөөсөө илүү олон ажлыг санхүүжүүлнэ гэж байгаа бол олсноосоо илүү их хэмжээний мөнгийг эдийн засагтаа оруулаад хөрөнгө оруулалт хийж, өсөлтийн

суурийг ханганаа гэж ойлгож болно. Төсвийг тооцох аргачлал олон байдаг тул тал талаас нь харж тайлбарлаж болно шүү дээ.

-Туулай жилд эдийн засгийн өсөлт нэлээд өндөр гарах судалгаа байгаа.

-Монголын эдийн засаг өндөр өсөлттэй хэвээр байна. Бид хямралаас сайн гарч чадлаа. Өнөөдрийн өсөлтийг хадгалаад нэмэгдүүлэх талаар ярьж байна. Манай улс 2015 он хүртэл маш өндөр өсөлт үзүүлэх төлөв харагдаж байгаа тул тэрхүү хамгийн өндөр өсөлтийг үзүүлэх хэмжээний хөрөнгө оруулалтын шийдвэрүүдийг өнөөдөр гаргах ёстой. Тиймээс дэд бүтэц, уурхай, цахилгаан станц, төмөр зам гэсэн томоохон төслийг санхүүжүүлэх Хөгжлийн банкнийг байгуулья, Засгийн газар бондоо гаргая гэж яриад байгаа юм. Өмнө нь байгаагүй өндөр өсөлт ирнэ хэмээн сайхан яриад гараа хумхин зүгээр суугаад байх уу, хөдөлмөрлөх үү гэдэг нь өөр асуудал. Монголын эдийн засгийн форум ч энэ асуудлаар ярилцаж, хариу өгөхөд том нөлөө үзүүлнэ гэж бодож байна. Уул урхайн салбарын хувьд манай улсын цаашдын эрчимтэй хөгжлийн зөвхөн

гарааны нөхцөл байдлыг хангаж өгөх зүйл гэж ойлгох ёстой. Өөрөөр хэлбэл, аль болох олон талт эдийн засгийн бүтцийг бий болгож, жуулчлал, үйлдвэрлэл, тээвэр, боловсрол, эрүүл мэнд, технологийн салбарыг эрчимтэй хөгжих гарааны нөхцөлийг уул уурхайгаас орж ирэх мөнгө олгох юм гэж бодож санаж ажиллавал тогтвортой хөгжинө.

-Сүүлийн үед эрсдэлийн удирдлагын тухай ихэд ярих боллоо. Энэ нь манай эдийн засгийн хүрээ өргөжиж, өндөр өсөлт харагдаж байгаатай холбоотой юү?

-Бид эрсдэлээ байнга тооцож ажиллах ёстой. Зэсийн үнэ өсөж, буурдгийг мэддэг хэрнээ мэддэггүй юм шиг шийдвэр гаргаж болохгүй. Зэсийн үнэ буурч, дэлхийд ноолуурын хэрэглээ багасаж магад шүү, бэлчээрийн даац хэтрэх вий хэмээн асуудалд хандаж, санаж бодож хийх талаас томоохон шийдвэр гаргадаг бол бидний ирээдүй улам найдвартай аюулгүй болох юм гэдэг нь эрсдэлийн удирдлага. Банк зээл өгөхдөө олон зүйлсийг харж тооцдог шиг эрсдэлийг төр, засаг болон үндэсний хэмжээнд ярьдаг болговол бид эрсдэлээ зөв тооцож, зөв ярьж, зөв шийдвэр гаргаж, улмаар бүтээлч

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилд

140 мянган ажлын байр уу, 21 мянган төгрөг үү?

Должин гуай гурван настай зээ хүүгийнхээ гараас хөтлөн банкны урт дараалалд зогсохдоо “Ишш, энэ хүүхдийн эх хурдхан л сургуулиа төгсөж, ажилд б्रोосой билээ” хэмээн санаа алдав. Тэрбээр гарын уртай юм болохоороо нэг оёдлын цех байгуулж, хувцас хийж борлуулах сонирхолтой. Гэхдээ оёдлын цахилгаан машин, бага сага бөс бараа авахад бараг хоёр сая төгрөг хэрэг болно. Ажилгүй юм болохоор зээл ч олдохгүй. Олдлоо гэхэд арилжааны банкны зээл өндөр хүүтэйгээс гадна барьцаа хөрөнгөнөөс эхлээд дааж давшгүй шалгууртай. “За тэр ч яах вэ, Хүний хөгжил сангийнхаа мөнгөөр хэдэн кг мах, гурил аваад харья даа байз. Нээрээ махны үнэ дахиад нэмэгдчихээгүй байгаа?”...

Уг нь Должин гуай нэгэн оёдлын үйлдвэрт ажилладаг байжээ. Охин нь дөнгөж нэгдүгээр курст байхдаа хөл хүндтэй болсон учир ээж нь ажлаасаа гарч хүүхэд асрахаас өөр зам байсангүй. Их сургуулиа орхин Мэргэжлийн

үйлдвэрлэлийн сургалт үйлдвэрлэлийн төв /МСҮТ/-д орсон Сараа охин нь овоо хэдэн төгрөгийн “цалин” авчихдаг болохоор энэ гурав хоёр идэхгүй, хоосон хонохгүй болгоод л явна. Мөн Хүний хөгжил сангаас сар бүр нийт 63 мянган төгрөг авч эхэлсэн болохоор өнөө маргаашаа аргацааж болж л байна. Гэхдээ Должин гуайн хувьд сардаа 21 мянган төгрөг зүгээр аваад суух биш, 210 мянган төгрөгийн цалинтай ажил олж хийх нь дээр шүү дээ, мэдээж.

Засгийн газар 2011 оныг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарласан нь жаахан ч гэсэн найдвар төрүүлж буй мэт. Улсын хэмжээнд ажил хөдөлмөр эрхлээгүй хүний тоо 103.1 мянгад хүрч, ажилгүйдлийн түвшин 8.6 хувьтай байна гэсэн мэдээллийг салбарын яамнаас өгчээ. Тэднээс ажил идэвхтэй эрж хайж буй нь 38-40 мянга орчим байдаг бол бусад нь ажил хайгаад ч олохгүй цөхөрсөн хүн байдаг аж. Должин гуай шиг 45 нас шүргэж яваа хүний хувьд одоо



цагт ажил олдох нь хэцүү. Тэрбээр өнгөрсөн намар зээгээ цэцэрлэгт өгчихөөд ажил хайж хөлөө цуцтал явсан гэнэ. Аливаа байгууллагын үүдний хүлээн авахад хүртэл өндөр, туранхай, царайлаг, англи хэлтэй бүсгүйчүүдийг суулгахыг чухалчилдаг болсон цаг хойно.

Энэ жилээс эхлэн улсын хэмжээнд 60 мянгаас багагүй тооны ажлын байр бий болгох бодлогыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам боловсруулаад буй. Цаасан дээр бичигдээд, амьдрал дээр хэрэгжилгүй үлдчихгүй бол ч аятайхан л дуулдана.

Манай орон зах зээлийн эдийн засагт шилжих үед л хүн амын 30 гаруй хувь нь ядуу байлаа. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд эдийн засаг өслөө, буурлаа, сэргэлээ. Уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж эхэллээ, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдлээ. Ялгаагүй, гурван монгол хүний нэг нь “ядуу” гэсэн ангилалд багтсан хэвээр. Өнгөрсөн хугацаанд Засгийн газраас Үйлдвэрлэлийг дэмжих жил, Бизнесийн шинэтгэлийн жил гээд зарласан. Үр дүн юу байсан бэ? Тэгсэн ингэсэн гээд хэлчих дорвитой зүйл үнэхээр байхгүй нь харамсалтай. Өөрөөр хэлбэл, Должин гуайн аж амьдрал сайжирсангүй. Харин 2011 он бол “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил”. Энэ сайхан уриан дор өөрийгөө биш юм аа гэхэд Сараа охиноо ажилд оруулчихвал ч болоод явчихна даа гэж Должин гуай санааширна.

Ингэхэд Засгийн газар хөдөлмөр эрхлэлтийг яаж дэмжих гээд байна вэ? Логикоор бол ажлын байрыг хамгийн ихээр нэмэгдүүлдэг салбараа л эхлээд өөд нь татах ёстой. Энэ нь мэдээж жижиг үйлдвэрлэл. Яагаад гэдгийг хэдэн тоогоор өгүүлье.

2009 онд улсын төсвөөс анх удаа жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зориулалттайгаар 30 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл гаргасан билээ. Сарын нэг хувийн


хүүтэй, гурван жилийн хугацаатай зээлийг 2009 онд 1528 аж ахуйн нэгж, иргэнд олгосноор 469 үйлдвэр шинээр ашиглалтад орж, 950 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа өргөтгөж, нийт 6000 орчим ажлын байр бий болсон гэх тооцоо гарчээ. Эдүгээ дээрх зээлийн эргэн төлөлт 98.9 хувьтай явж байна гэхээр ямаршуу үр өгөөжтэй болсон нь харагдах биз.

Тэгвэл энэ онд Хүний хөгжил сангийн зарлага 805.2 тэрбум төгрөг байхаас иргэдэд бэлнээр тараах 21 мянган төгрөгт 702.5 тэрбум төгрөг зарцуулахаар байна. Бодоод үз дээ. 30 тэрбум төгрөгөөр 6000 ажлын байр бий болсон бол 702.5 тэрбумаар хэдэн хүн ажилтай болж, цалинтай золгох бол? 140 гаруй мянга гэвэл Та итгэх үү? Иргэдэд аманд ч үгүй, хамарт ч үгүй 21 мянган төгрөг тарааснаас бичил бизнесийг дэмжих нь хамаагүй дээр гэдгийг дээрх хэдэн тоо харуулах буюу.

Гэхдээ энд нэг анхаарах зүйл бий. 2010 онд Жижиг, дунд үйлдвэрийн газраас мөн л 30 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1233 аж ахуйн нэгж авснаар 2830 гаруй ажлын байр шинээр бий болжээ. Өмнөх жил нь 6000 ажлын байр гарч ирсэн хэрнээ 2010 онд яагаад 3000 ч хүрсэнгүй вэ гэж та гайхаж магадгүй. Манай улсад үйл ажиллагаа явуулж буй 40.9 мянган аж ахуйн нэгжийн 85 гаруй хувийг 1-9 ажилтантай жижиг компаниуд эзэлж буй аж. Өөрөөр хэлбэл, жижиг аж ахуйн нэгжүүд л ажлын байрыг хамгийн ихээр бий болгодог гэсэн үг. Хөл дээрээ тогтсон томоохон компаниуд мэдээж орчин үеийн үнэтэй тоног төхөөрөмж оруулж ирээд, түүндээ тохирсон цөөн тооны чадварлаг ажиллах хүчинтэй байна шүү дээ. Гэтэл Жижиг, дунд үйлдвэрийн газраас 2010 онд олгосон 10 сая хүртэлх зээлийн хэмжээ өмнөх жилийнхээсээ 2.5 дахин буурсан байгааг хүснэгтээс харна уу. Тодруулбал, жижиг аж ахуйн нэгжүүдэд олгосон санхүүжилт 2010 онд буурснаас шинээр бий болсон ажлын байрны тоо ч мөн хумигджээ.

Тиймээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд юуны түрүүнд бичил бизнесийг дэмжих хэрэгтэй болж байна. Энэ нь ажлын байр олноор бий болгохоос гадна ядуурлыг

2009, 2010 онд олгосон нийт зээл (сая/төг)



бууруулахад ч нэмэртэй болов уу. Нэгэн сонирхолтой баримт дуулгая. Бангладешийн эрдэмтэн Мохаммад Юнус 1976 онд “Grameen bank”-ийг үүсгэн байгуулж, бичил зээлээр дагнажээ. Нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст барьцаагүй зээл олгож эхлэхэд банкирууд түүнийг “галзуурсан эрдэмтэн” гэж дүгнэж байсан аж. Ингээд тус банк дөрвөн сая гаруй хүнд нийт таван тэрбум долларын зээл олгосон

байна. Гэтэл зээл авсан ядуусын 98.9 хувь нь мөнгөө эргэж төлсөн нь жинхэнэ шуугиан дэгдээсэн билээ. Мохаммад Юнус энэхүү ололтоороо 2006 онд Нобелийн шагнал хүртсэн юм. Нийгмийн эмзэг бүлгийнхэн хүртэл авсан мөнгөө эргүүлж төлөх чадвартай бөгөөд ядуурлыг бууруулах шилдэг арга нь бэлэн мөнгө тараах биш, хөнгөлөлттэй зээл өгөх гэдэг ганц үнэнийг энэ хүн баталж чаджээ. Эдүгээ “Grameen bank” дэлхийн 30 орчим оронд салбараа нээн ажиллаж байна.

Должин гуайд ийм зээл авах боломж байсан сан бол оёдлын цех байгуулаад, амьжиргаагаа дээшлүүлэх нь мэдээж. Тэгээд бизнес нь урагшилбал 2-3 хүн нэмж ажиллуулаад, багахан хэмжээний үйлдвэр болгосон ч болно шүү дээ. Яагаад монголчууд дотуур өмдөө хүртэл Хятадаас авах ёстой гэж? Яагаад монгол хүн ядуу ч гэсэн бизнес эрхэлж, хөл дээрээ босч болохгүй гэж?


Одоо сар бүр таны гарт очиж буй 21 мянган төгрөг үр өгөөжтэй байж чадаж байна уу? Бэлэн мөнгө тараах тусам ядуурал нэмэгдээд байгааг мэдсэн ч мэдээгүй юм шиг суух уу? 2007 онд алт, зэсийн үнэ тэнгэрт хадаж, энэ хэрээр төсвийн ашиг нэмэгдэж, эрх баригчид мөнгө тарааж эхэлснийг бид мэднэ. Үр дүнд нь инфляц 34 хувьд хүрч, иргэдийн

худалдан авах чадвар эрс суларсан. Дараахан нь зэсийн үнэ шалдаа буухад улсын төсөв алдагдалтай гарч, эдийн засаг уналтад орж, гадаад валютын нөөц огцом буурч, төгрөгийн ханш эрс суларсан. Тэгээд Монгол Улс эдийн засгийн хямралд хамгийн ихээр өртсөн орны ангилалд багтаад авсан.

Мөнгө тараалаа гээд сайн юм ер болдоггүйг өнгөрсөн хямрал харуулсан боловч төр, засгийн эрх баригчид хал үзэж, хашир суусангүй. УИХ-ын 76 гишүүний хувьд иргэдийнхээ халаасанд хэдэн төгрөг шургуулж, дараагийн сонгуулиар дахиад суудалдаа залрах нь л чухал ажээ. “Нүглийн нүдийг гурилаар хуурна” гэдэг л юм даа.

2009, 2010 онд Жижиг, дунд үйлдвэрийн газраас хөнгөлөлттэй зээл олгож эхэлснээр нийт 11.970 аж ахуйн нэгж, иргэн 913.8 тэрбум төгрөгийн зээл авах хүсэлт гаргажээ. Одоо олгож буй зээл нь дээрх эрэлтийн 5-6 хувийг л хангаж байна гэсэн үг. Гэтэл 2011 онд жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлд 24 тэрбум төгрөг төсөвлөжээ. Мөн өмнө нь олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс 28 тэрбум төгрөг нэмж гаргах тооцоо байгааг Жижиг, дунд үйлдвэрийн газрын мэргэжилтнүүд ярьж байна. Энэ нь дээр дурдсан 913.8 тэрбум төгрөгийн эрэлтийн дэргэд хэтэрхий “жулдах” тоо бус уу? Эрх баригчид сонгуулийн амлалтаа биелүүлэхдээ 805.2 тэрбум

2010 онд 40,9 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулжээ



төгрөг төсөвлөчихдөг хэрнээ ядуурал, ажилгүйдлийг бууруулахад энэ хэмжээний мөнгө зарцуулж чадахгүй байгаа нь харамсалтай. Сайн яривал иргэдийн гарыг цайлгаж буй 21 мянган төгрөг Эрээнд хөрөнгө оруулалт болоод л дуусна. Харин монголчуудад хүсээд буй хөнгөлөлттэй зээлийг нь өгчихвөл эргээд тэр мөнгө нь хүүгийн хамт ирнэ шүү дээ. Үр дүнд нь хүмүүсийн амьдрал, амьжиргаа сайжирна. Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа өргөжсөнөөр улсын төсөвт шингэх татварын орлого ч нэмэгдэх бус уу?

“Хүмүүсийн жинхэнэ баялаг бол хөдөлмөрлөх чадвар” гэсэн Эзопын үг санаанд буух аж. “Гар хөдөлбөл ам тосдоно” хэмээн монголчууд сургаж ирсэн. Бид яадгаа алдсан залхуу, мунхагууд биш шүү дээ. Монгол хүн бүрт ажиллах, амьдралаа дээшлүүлэх сонирхол байна. Монголчуудад 21

Мөнгө



Нэг бодлого, дөрвөн байр суурь

Жилийн 20 хувийн хүүтэй зээл аваад үйл ажиллагаа явуулна гэдэг үнэндээ бэрх. Монголын мөнгө ийм үнэтэй учир ажлын байрыг хамгийн ихээр бий болгодог жижиг, дунд үйлдвэрүүдэд өсөж томрох боломж алга гэвэл буруудахгүй болов уу. Томоохон компаниуд нь ч яах вэ, гадаадаас зээл авч, олон улсын

хөрөнгийн зах зээлээс мөнгө босгох боломжтой болсон цаг шүү дээ.

“Зээлийн хүү өндөр байна” хэмээн амтай болгон л ярих. Гэхдээ үүнийг яаж бууруулах вэ гэхээр ёстой л “Бодоод бодоод бодын шийр дөрөв” гэдэгчлэн болох. Бизнес эрхлэгчдийн хувьд зээлийн хүү буурах, эсэх

нь хамгийн чухал зүйл. Харин Монголбанкны хувьд төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах нь чухал бол Засгийн газар бэлэн мөнгө тарааж, улс төрийн амлалт биелүүлэхийг илүүд үзэх жишээтэй. Товчхондоо, хүүг бууруулах хэрэгтэй гэдгийг хүн бүр мэдэж байгаа ч энэхүү зорилгодоо хүрэхийн тулд хамтарч ажиллах тал дээр жаахан тиймхэн байх шиг...

Зээлийн хүү буурахгүй байгаагийн цаана эдийн засгийн хэд хэдэн шалтгаан байгааг мэргэжилтнүүд тайлбарлаж байна. Юуны түүрүүнд энэ нь хадгаламжийн хүү өндөр байгаатай холбоотой. Мэдээж хадгаламжийн хүү инфляцийн түвшнээс хэт доогуур байвал хэн ч мөнгөө банкинд хадгалуулахгүй. Өөрөөр хэлбэл, зээлийн эх үүсвэр бүрдэхгүй. Ингээд өндөр үнэтэй хадгаламжаар хөрөнгөө төвлөрүүлсэн арилжааны банкууд үйл ажиллагааны зардал, эрсдэлийн тооцоолол болоод ашгаа нэмээд бүр ч өндөр хүүтэй зээл олгох нь гарцаагүй. Өнгөрсөн онд инфляци улсын хэмжээнд 13 хувьтай, Улаанбаатарт 14.3 хувьтай гарсан байна. Товчхондоо, зээлийн хүү өндөр байгаа нь инфляцитай шууд хамаатай ажээ.

Тэгвэл инфляци яагаад өндөр байна вэ гэдэг асуулт гарч ирнэ. Монголчууд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг, тэр дундаа түлш шатахуунаа бараг зуун хувь гадаадаас авдаг нь үнийн тогтвортой байдлыг хангахад томоохон саад учруулж буй. Нөгөө талаас Засгийн газар бэлэн мөнгө тарааж,

цалин нэмж, олон түмэнд сайрхаж байгаа нь инфляци гаарах нөхцөлийг бий болгож байгаа билээ. Энэ бол онолоор ч, амьдралаар ч батлагдсан туршлага юм. Алт зэсийн үнэ тэнгэрт хадаж, төр, засаг бэлэн мөнгө тарааж эхэлснээр 2008 оны зун инфляци 34 хувьд хүрч, рекорд тогтоож байсныг санацгаая. Харин эдийн засаг сэргэсэн энэ оноос Засгийн газар 805.2 тэрбум төгрөгийг бэлнээр тарааж буй өнөө үед юу болох бол? Инфляци 20 хувиас ч давж магадгүй хэмээн олон улсын байгууллагууд сануулж байна. Ийм байхад Монголбанк мянга мэрийлээ ч бодлогын хүүг бууруулна гэдэг амаргүй бололтой.

Гэхдээ Төвбанк инфляцийг нэг оронтой тоонд барих зорилгодоо хүрэхийн тулд Мөнгөний бодлогоо сулруулахгүй, улам чангаруулсан тохиолдолд юу болох вэ? Бидний хүлээж буй “үсрэнгүй хөгжил” мөрөөдөл болон замрах вий. Зээлийн хүү тэнгэрт хадсан Монгол оронд дотоодын үйлдвэрлэл үйл ажиллагаагаа өргөжүүлнэ гэдэг юу л бол. За тэгээд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” ч мөн талаар болох аюултай.

Тиймээс Засгийн газар, Монголбанк болоод УИХ зээлийн хүү өндөр байгаагийн бурууг бие биедээ тохож байхын оронд дээрх асуудлуудыг цогцоор нь шийдэх шаардлагатай болжээ. Нэг үгээр хэлбэл, хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх цаг иржээ. Монголбанкнаас 2011 онд хэрэгжүүлэх Мөнгөний бодлогын тухай холбогдох албаныхан болон хувийн хэвшлийн төлөөлөл юу гэж үзэж байна вэ гэдгийг сонирхлоо.

Б.Лхагважав

/Монголбанкны Олон нийттэй харилцах хэлтсийн дарга/:



-Анх 2011 оны Төсвийн төсөл ДНБ-ий таван хувьтай дүйцэх хэмжээний алдагдалтай байхад бодлогын хүүг бууруулж болно гэж Төвбанк үзэж байлаа. Гэтэл эрх баригчид төсөв хэлэлцээд, бараг 10 хувийн алдагдалтай байхаар баталчихсан шүү дээ. Ийм байхад Мөнгөний бодлогыг сулруулах боломжгүй, харин ч чангаруулах тухай авч хэлэлцэх хэрэгтэй болж байна. Уг нь бодлогын хүүг бууруулах хэрэгцээ байна уу гэвэл байна. Гадаад валютын ханш суларч, валютын зах дээр тэнцвэргүй байдал үүсэх хандлага бий боллоо.

Хүү өндөр байгаатай хүн бүр санал нийлдэг. Төвбанк зах зээлийн жамын дагуу хүүг бууруулах саналтай байгаа. Бид арилжааны банкуудаас мэдээлэл тогтмол авч, судалгаа хийдэг. Өнөөдөр арилжааны банкуудын хадгаламжийн хүү 6-14 хувьтай байна. Гэтэл инфляци 2010 онд 14.3 хувьтай гарлаа. Инфляци өсч, мөнгөний ханш унасаар байтал хүмүүс түүнээс бага хүүгээр банкинд мөнгөө хадгалахыг хүсэхгүй нь ойлгомжтой. Зээлийн хүү бол мэдээж хадгалмжийнхаас өндөр байх ёстой. 2011 онд Төвбанк инфляцийг нэг оронтой тоонд барина гэж байгаа нь 805.2 тэрбум төгрөг тарааж буй үед үнэндээ хэцүү зорилт юм.

С.Дэмбэрэл

/МУХАУТ-ын дарга/:



-Мөнгөний бодлого эдийн засгийн бодит секторыг дэмжихгүй байна. Бизнес эрхлэгчид мөнгөний бодлого өөрсдийнх нь үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг ярьдаг. Энэ бүхнийг МУХАУТ судалж, боловсруулж, таван зүйл бүхий санал гаргасан байгаа. Мөнгөний бодлогыг хүн бүр ярьж, шүүмжилж байна. Монгол ардын намын дарга Төвбанк хоёр чиг үүрэгтэй байх хэрэгтэйг онцолж байсан. Төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангахаас гадна хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиг үүргийг нэмж тусгах талаар судалж үзэж байна. Намууд хүртэл энэ тал дээр анхаарч эхэлснийг л хэлэх гээд байна л даа.

Манай эрдэс баялгийн салбар хөгжиж байна. Тиймээс бид Голланд өвчнөөс сэргийлэх хэрэгтэй боллоо. Зөвхөн уул уурхай биш, эдийн засгийн бусад салбараа хөгжүүлэх ёстой. Бүх төрлийн бизнесийг дэмжихийн тулд Мөнгөний бодлогыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай. Үнэндээ Монголбанк 2006 оноос л инфляцийг онилж эхэлсэн. Энэ нь бүтэл муутай гэдэг нь батлагдчихаад байна шүү дээ.

Одоо Төвбанк “Засгийн газар”

“бэлэн мөнгө тарааж байна” гэсэн нэг сайхан тайлбартай болоод авлаа. Үнэн, гэхдээ 21 мянган төгрөг тарааснаар хувийн хэвшлийг золиослоод байгаа юм алга. Харин ч 210 мянган төгрөгийг шууд өгөх хэрэгтэй юм. Ингэж байж гэр бүл, найз нөхөд, хамт олноороо бизнес хийхийг урамшуулах ёстой. Тэглээ гээд инфляци өсөхгүй. Харин халамжийг хавтгайруулсныг болих ёстой гэдэгтэй санал нийлдэг.

Стивен Барнетт

/ОУВС-гийн Ажлын хэсгийн ахлагч/:



-Төвбанк мөнгөний бодлогоо чангаруулах шаардлагатай гэсэн зөвлөмжийг бид өгч байгаа. Энэ нь төсвийн зарлага хэт хурдтай тэлж байгаатай холбоотой юм. Инфляци энэ онд 20 хувьд хүрч магадгүй гэсэн тооцоог гаргасан. Энэ нь мэдээж ядуу хүмүүст илүү хүндээр тусна. Түүнчлэн мөнгөний ханш суларснаар

Монголын дотоодод үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүн, ажиллах хүчний өртөг нэмэгдэнэ. Ийм үед импортын бараа хямд болж, улмаар дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварт муугаар нөлөөлдөг. Тиймээс бодлогын хүүг өсгөхөөс өөр сонголт байхгүй. Мэдээж энэ нь сайн зүйл биш л дээ. Мөнгөний бодлогыг үе шаттайгаар чангаруулах хэрэгтэй. Ер нь бэлэн мөнгө тараах нь инфляци өсгөхөөс биш урт хугацаанд үр өгөөжтэй байж чаддаггүй. Түүний оронд дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулах нь эсрэгээрээ, урт хугацаанд үр шимээ өгдөг юм.

2011 онд Монголын ДНБ 10 хувиар өсөх таамаглал бий. Уг нь бол эдийн засгийн огцом өсөлтөөсөө илүү урт хугацааны тогтвортой өсөлт чухал шүү дээ.

Н.Энхбаяр

/Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөх/:



-Бусад орны Төвбанк үнийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ ажил эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх зэрэг давхар бодлого баримталдаг. АНУ-ын Холбооны нөөцийн систем л гэхэд үнийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахын сацуу ажил эрхлэлтийн түвшинг аль болох өндөр байлгах чиг үүрэгтэй байх жишээтэй. Манай орны хувьд төгрөгийн ханшийн тогтвортой байдал нэг асуудал мөн, гэхдээ гол асуудал биш. Монголбанкны гүйцэтгэх чиг үүргийг өргөжүүлж байж гэмээнэ манай эдийн засаг үсрэнгүй хөгжилд хүрч чадах юм. Энэ тухай Ерөнхий сайд С.Батболд ч мөн тэмдэглэсэн байгаа. Засгийн газар болон Монголбанкны зорилго нэг, түүндээ хүрэх арга зам нь л өөр байх учиртай.

Давосын чуулга уулзалтад оролцогчид дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөж байгааг онцолж байсан. Азийн улс орнуудын хөгжил дэлхийн анхаарлын төвд орж байна. Энэ бүхнээс үүдэн эдийн засгийн уламжлалт загвар өөрчлөгдөн шинэчлэгдэх болж байгааг хүмүүс тэмдэглэж байна. Бид ч мөн цаг үетэйгээ нийцүүлэн аливааг шинээр харах болжээ.

Одоо Монгол Улс хөгжлийн өөр түвшинд хүрлээ. Тиймээс бид илүү өргөн хүрээнд ажиллах цаг ирсэн. ■

Банк

Бүтээн байгуулалтыг түргэвчлэх Хөгжлийн банк

Б.Санжааханд

Монголын эдийн засгийн өсөлт сүүлийн таван жилд дунджаар долоон хувийн өсөлттэй байсныг мэргэжлийн байгууллаагынхан тэмдэглэдэг. Тэгвэл ирэх таван жилд дээрх өсөлт хоёр дахин нэмэгдэнэ гэсэн таамаглал ч байгаа юм. Өөрөөр хэлбэл, манай эдийн засагт хурдтай хөгжлийн жилүүд айсуу. Эдийн засгийн үсрэнгүй хөгжил дэд бүтэц голлосон их бүтээн байгуулалт, боловсруулах үйлдвэрийг

даллаж буй. Эдгээр ашигт ажиллагааны түвшин доогуур, урт хугацааны хөрөнгө шаардсан бүтээн байгуулалтыг дэмжин ажиллах Хөгжлийн банк байгуулахаар манай улс зориод байна. Сүүлийн 2-3 жилийн гаруй хугацаанд Хөгжлийн банкны тухай шийдвэр гаргах түвшинд маш идэвхтэй ярьсны эцэст бар жилийн төгсгөлөөр асуудал ажил хэрэг болох тал руугаа орсон. Ашгийн төлөө бус, хөгжлийн төлөө ажиллана гэсэн том зорилготой

Хөгжлийн банкнийг удирдах менежментийн багаар KDB /Солонгосын хөгжлийн банк/ тодорсон.

Мөн Хөгжлийн банкны тухай хуулийн хэлэлцүүлгийг ч УИХ-ын Төсвийн байнгын хороогоор өнгөрсөн сарын сүүлчээр хийсэн байгаа. KDB шинэ тутам байгуулах Хөгжлийн банкны менежментийн багаар тодорсноор Хөгжлийн банк байгуулахтай холбоотой олон эргэлзээтэй асуудлын нэгнийх нь ч болтугай оньс тайлагдаж байна гэж ойлгож болох ч Төсвийн байнгын хорооны Хөгжлийн банкны тухай хуулийн эхний хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүд Сангийн сайдыг асуултаар булсан нь асуудал нэлээд түүхий байгааг харуулж байна уу гэлтэй. Хөгжлийн банк нь арилжааны банкны хүрч чадахгүй орон зайд хөрөнгө оруулах бөгөөд арилжааны банк шиг хадгаламж татахгүй гэнэ. Санхүүжилтийн тодорхой хэсгийг улсын төсвөөс бүрдүүлж, үлдсэнийг нь олон улсын зээл, хөтөлбөр, тусламж гэх мэт арга замаар төвлөрүүлэх аж. Мөн үр ашигтай гэсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Засгийн газраас баталгаа гаргахаар хуульд тусгасан нь гишүүдийн санааг зовоосон юм. Түүнчлэн Монгол Улсыг хөгжүүлэх сан нь уул уурхайн орлогыг нийгмийн халамж, дэд бүтцийн төслүүдэд зарцуулах үүрэг хүлээдэг бол Хөгжлийн банк халамжийг бус, бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх аж.

Эцсийн эцэст Хөгжлийн банк байгуулж буйн гол шалтгаан нь урт хугацаатай, бага хүүтэй зээл олгох явдал. Хөгжлийн банкны тухай хуулийг нухацтай хэлэлцэхгүй бол алдаа гаргавал хариуцлага нь улсын төсөв дээр буухаар байна. Тиймээс тус банкныг тогтвортой, ашигтай, хараат бус байлгах нөхцөлийг олгосон хууль боловсруулах ёстойг УИХ-ын гишүүд анхааруулж байв. Мөн хуулийг нь батлаагүй байхад банкны ТУЗ байгуулж, менежментийн багийг шалгаруулсан нь УИХ-ын гишүүдэд яаравчилсан ямар нэг далдын сонирхол нуугдаж байх вий гэсэн болгоомжлолыг төрүүлээд амжив. Түүнчлэн тендер зарлаад, гаднын төрийн өмчийн банкинд менежментээ даатгах гэж байгааг ч буруутгах УИХ-ын гишүүн ч байв. Харин Сангийн сайд С.Баярцогт “Хөгжлийн банк 100 хувь улсынх байна. Хөгжил бүтээн байгуулалтаа түргэвчлэхийн тулд л уг банкиг байгуулах учир дүрмийг нь Засгийн газраас батлаад үйл ажиллагааг нь явуулж байгаа. Хуулиа баталсаныхаа дараа тендерийн асуудлыг эргэж авч үзнэ” гэв.

Төсвийн байнгын хорооныхон олон шүүмжлэлтэй асуулт дундаас шийдэл олж чадсан. Тухайлбал, Хөгжлийн банкны хараат бус байдлыг хангахын тулд ямар зээлд уг банк хөрөнгө оруулахыг Засгийн газрын гишүүний саналаар биш ТУЗ нь шийддэг байх, баталгаа гаргасан төслийг бусад банк санхүүжүүлэх эрхтэй байхаар тохиролцсон. Мөн хөгжлийн банкны ТУЗ-ын гишүүний гуравны нэгээс доошгүйд хараат бус, мэргэжлийн хүн сонгохоор болов. Хөгжлийн банкны ТУЗ-ын дарга, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун “Тендерийн урьдчилсан дун гарч, нарийн хэлэлцээрийн ажил эхлээгүй байна. Солонгосын KDB, Японы Хөгжлийн санхүүжилтийн байгууллага гэж хоёр баг эцсийн шатанд оролцсон. Солонгосын хөгжлийн банк буюу KDB өөрийн туршлага, хөрөнгийн хэмжээгээрээ шалгарсан. Тэдэнд дайны дараах нэг хүнд ногдох нэн ядуу Солонгос улсыг одоогийн өндөр



хөгжилтэй, технологи, үйлдвэрлэл хөгжсөн орон болгосон давуу тал байгаа. Гэхдээ албан ёсоор ямар нэгэн гэрээ байгуулагдаагүй байна. Хөгжлийн банкны тухай хууль батлагдахаар одоогийн өгсөн саналуудыг боловсронгуй болгох ёстой. Агуулгыг эргэн харах шаардлага бий.

Урьд нь манайд төрийн өмчийн компаниудад олон улсын менежментийн баг ажиллуулж байсан туршлага байгаа. Хууль батлагдахаар гэрээ байгуулах процедурын асуудал болон бусад зүйл тодорхой болох юм. Оролцсон талуудын менежментийн баг бүрдүүлэх, үйл ажиллагаагаа явуулах төслүүдийг нарийвчлан судалж байгаа. Мөн үүнээс гадна дэлхийд хөгжлийн санхүүжилтээр ажиллаж байгаа туршлагатай, олон улсын нэр хүндтэй бусад байгууллага, дэлхийн томоохон корпорациатай зөвлөгөө авах чиглэлээр хамтран ажиллаж байна. Тухайлбал, Японы хөгжлийн банк, Германы КВФ, Ситибанк зэрэг байгууллагатай уулзаж, зөвлөгөө авч байгаа. Нээлттэй олон хувилбар байна гэж ойлгож болно” хэмээн ярьсан юм. Хөгжлийн банкыг амжилтад хүргэх гол түлхүүр бол менежментийн сайн баг юм.

Манай улс санхүүгийн хөгжлийн туршлага дулимаг тул гадаад, дотоодын дадлага туршлагатай, чадвартай мэргэжилтнүүдээс багаа бүрдүүлэх нь оновчтой гэдэг үүднээс ийнхүү шийдвэрлэсэн нь мэдээж. Хууль батлагдахын цагт Хөгжлийн банктай холбоотой олон асуудал тодорхой болох биз ээ. Ямартаа ч бүтээн байгуулалтад хэрэгцээтэй хөрөнгө оруулалтыг санхүүжүүлж чадвал Хөгжлийн банкнаас хүлээх үр дүн нь тэр юм. Эцэст нь олон арван жилийн хугацаа шаардагдах аж үйлдвэр болон өндөр технологийн салбарыг эрчимтэй хөгжүүлэхэд л Хөгжлийн банк байгуулсны гол үүрэг гарах юм. ■

Д.Лхагвасүрэн:

Малаа салхи сөрүүлж бэлчээрлүүлэх дуртай

Д.Хулан

Монгол малчдын тэсвэр тэвчээр, хөдөлмөрийг шалгасан он жилүүд тохиох боллоо. Цас зуд, ган гачиг, уур амьсгалын өөрчлөлт гээд л хувиран өөрчлөгдөх байгалийн үзэгдлүүдэд дасан зохицох, даван гарах арга зам хайх шаардлагатай болж байна. Сүүлийн хэдэн жилд тохиогоогүй хүйтэнд манай улс малаа хэдэн мянгаар нь алдаж, хоолноосоо салсан малчдын тоо ч нэмэгдсэн дүр зураг үргэлжлэх болсон. Тэгвэл байгалийн энэхүү ширүүн дүр зургийг хөдөлмөр, зүтгэлээрээ эрсдэлгүй даван туулж буй малчид ч олон байгаа. Засгийн газраас Сар шинийн баяраар Улсын сайн малчдыг тодруулж урамшуулан шагнадаг уламжлалтай. 2010 оны Улсын сайн малчныг ган гачиг, цас зудыг хэрхэн давж гарсан гэсэн гол үзүүлэлтээр шалгаруулсан хэмээн Засгийн газрын сайдууд онцлон хэлж байсан юм. Өнгөрсөн оны Улсын сайн малчин өргөмжлөлийн эзэн Төв аймгийн Баянцагаан сумын IV багийн малчин Д.Лхагвасүрэнгийн дараахан Сар шинийн баярын дараахан зочилж, ийн хөөрөлдсөн юм.

-Сар шинэдээ сайхан шинэлэв үү?
-Сайхан шинэллээ.

-Тарган тавтай өвөлжиж байна уу?
-Сайн өвөлжиж байна.

-Туулай жилийн өнгө хэр байна даа Лхагвасүрэн гуай?

-Сайхан жил болох төлөвтэй байна. Сар шинээр дулахан байлаа. Өнгөрсөн жил цастай, хүйтэн их хэцүү байсан шүү дээ. Манайх отор нүүдэл нэлээд хийсний хүчээр зудыг эрсдэл багатай туулсан. Ер нь сүүлийн дөрвөн жил нутгаасаа гарч, өөр сумдын нутгаар отор хийж явна даа.

-Цас зудыг хэрхэн давах тухайд туршлагаасаа хуваалцахгүй юу?

-Зунаас л ихэд сайн бэлтгэл хангах хэрэгтэй дээ. Малаа сайн тарга тэвээрэг авахуулж, өвс тэжээлээ базааж, отор нүүдэл хийх нь хамгийн чухал. Мөн дулаан хувцас, хүнсний зүйлсээ ч хангалттай нөөцлөх ёстой. Манайх сүүлийн жилүүдэд өвөлдөө хоёр ч нүүж байна. Бог малын тоо толгой нэг хотонд 500 хүрээд ирэхээр өвс тачир болж, бэлчээрийн даац мууддаг талтай. Ер нь би малаа бөөцийлөөд дулаанд дасгах гээд

байдаггүй, аль болох салхи сөрүүлж бэлчээрлүүлэх дуртай.

-Танайд ажлын байраар хангасан тул... гэсэн өргөмжлөл байна. Ажлын байраар хэрхэн яаж хангаж байгаа талаараа ярина уу?

-Улирлын чанартайгаар түр зуурын ажлууд малчин бидэнд гарч ирдэг. Ямаа самнах, хонь хяргах гэх мэтчилэн их ажил эхэлсэн үед хүмүүсийг түр ажиллуулдаг. Ажилгүй, малгүй болсон 2-3 өрхийг дэргэдээ авч ажиллуулах замаар тэднийг тодорхой тооны малтай болгож, амьжиргааг нь дээшлүүлэх саналыг сумынхаа Засаг даргадаа хэлсэн. Гэхдээ залуу малчдыг дэргэдээ 2-3 жил дагалдуулахгүй бол бас л хэцүүднэ шүү дээ. Одооны залуус нэлээд залуу талдаа болжээ. Малаа цас зуднаар алдчихаад сумын төв рүү орж, хийх ажилгүй, төрд найдаад л суух юм. Бэлэнчлэх сэтгэлгээнд л их суралцаад байх шиг. Бас төрөөс өгсөн малыг үржүүлэн өсгөөд амьдралаа авч яваа хөдөлмөрч залуучууд ч байна аа. Манайх малжуулах бодлогын хүрээнд сумынхаа цэцэрлэг, сургуульд 500 гаруй мал өгчээ.

-Хөдөө амьдрал ямар байна, төр,

засгаас ямархуу арга хэмжээ авмаар байх юм?

-Малчдын амьдрал дээшилж байгаа. Нэг үеэ бодвол гэрэл цахилгаан, гар утастай болж, зурагт үзэж байна. Гэрийнхээ гадна унаа тэрэггүй малчин ер нь л ховор доо. Харин төрөөс иргэдээ бэлэнчлэх сэтгэлгээнд л сургах бодлого явуулаад байна уу гэж бодогдох юм. Бэлнээр мөнгө тараагаад байгаа нь хэр зөв юм бол доо. Уг нь хөдөлмөрлөж хоолоо олж идэх арга зам, боломжийг нь олговол зүгээр сэн. 20 000 төгрөг өгсний оронд аймаг суманд жижиг, дунд үйлдвэрүүд байгуулж, ажилгүй иргэдээ ажлын байраар хангавал хорин мянган төгрөгөөс хамаагүй илүү хөрөнгө оруулалт болно шүү дээ. Дээр нь малчин, мах хоёрын хооронд зуучлах ченжүүдийг зохицуулмаар байна. Ченжүүд биднээс махыг маш хямдаар аваад хотод очоод өндөр үнээр зарж борлуулаад хүнсний үнийг өсгөөд байна. Мал махаар баян оронд махны үнэ нь тэнгэрт хадна гэдэг байж боломгүй зүйл. Сүүлийн үед Хятад руу мах гаргаад байна гэж дуудах юм. Буруу л зүйл хийгээд байх шиг санагдах. Мөн бэлчээрийн талаар төрөөс ямар нэг бодлого явуулах ёстой байх. Бэлчээр нийтийн эзэмшлийнх байхаар хүндрэлтэй асуудалтай их тулгардаг. Өвөлжөө, намаржааныхаа ойр орчмын бэлчээрийг хаших эрхийг малчдад олгох, отрын нутгийг тодорхой болгох ёстой. Хэдийгээр фермерийн аж ахуй, хоршоог хөгжүүлэх бодлого барьж байгаа ч нүүдлийн мал аж ахуй байсаар л байх болно шүү дээ.

-Нийгмээ дагаад малчдын сэтгэлгээ өөрчлөгдөх ёстой гэсэн үзэл бодол зарим хүмүүст явдаг. Та ямар бодолтой байдаг бол?

-Малчдын сэтгэлгээ өөрчлөгдөх ёстой. Малчдын бүлэг байх шаардлагатай. Байгалийн янз бүрийн эрсдэлтэй хамтын хүчээр тэмцэж даван туулах нь чухал. Би бүлэгт бүртгүүлсэн байгаа. Бүлгийн гол зорилго нь хашаа хороог засах, худаг гаргах, өвс тэжээлээ хамтран бэлтгэхэд чиглэдэг. Мөн дундаасаа тодорхой хэмжээний мөнгөн хуримтлал үүсгэх асуудал ч байгаа. Байгалийн ширүүн үзэгдлүүдтэй олны хүчээр хамтран тэмцэх нь үр дүнтэй.

-Та аль намын гишүүн бэ?

-Нам бус хүн. Миний бодлоор томчуудын хооронд улстөржих явдал их байна уу даа. Бас намын хагарал байх шиг байгаа юм. Огцорсон хүмүүс нь шинүүдээ татаж унагаах гээд л байдаг юм шиг ойлгогдох юм. Уг нь улстөржих явдлаа багасгаж, бүтээн байгуулалт, улс орныхоо хөгжилд бодитой зүйл хийж ажиллаасай.

-Та морь уралдуулдаг уу?

-Уралдуулна аа. Аймаг сум, бүсийн наадамд айраг түрүүтэй л явдаг. Одоо морь уях ажлаа хүүдээ даггасан. Ер нь бидний үеийнх шиг морь уядаг цаг биш болжээ. Нийгэм цаг үеэ дагаад өвс тэжээл нь ч өөр болж дээ. Бэл бэнчинтэй хүмүүс нь хурдан морьдыг мөнгөөр зодож аваад л үнэтэй тэжээл өвс өгч байна. Янз бүрийн эрлийз хурлийз морьд ч олшроод, дийлдэхгүй болж байна.

-Та удмын малчин хүн үү?

-Тиймээ. Багаасаа л мал маллаж өссөн хүн дээ. Би өвөөгөөрөө овоглож явдаг. Өвөө маань 1944 онд Улсын сайн малчны зөвлөлгөөнд оролцож явсан хүн бий. Миний хувьд хүүхэд байхаасаа л малын дэргэд тоглож өсч өдий зэрэгтэй яваа учраас мал сүргээ сайхан өсгөж, сайн сайхан амьдрах л чухал юм даа. Манайх дөрвөн хүүхэдтэй. Том хүүгээ удам залгах малчин болгоод дэргэдээ авч явна. Бусад хүүхэд маань эрдмийн мөр хөөсөн.

Хариуцлагатай уул уурхай Монголд



Хариуцлагатай уул уурхайн найман зарчим

1. Олон талын оролцоог хангах
2. Ил, тод нээлттэй байх
3. Хуулийг сахин дээдлэх
4. Байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх
5. Ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах
6. Үр өгөөжтэй байх
7. Хүмүүнлэг ёс зүйтэй байх
8. Дэвшилтэт технологид суурилсан байх

Өнгө өнгийн цэцэг алагласан, удам хөндий тал газар алсаас дурайх. Холын холд Монголын хөх уулс шиг уулан толгодууд харагдана. Тэрхүү ногоон талд ан амьтан тайван амьдрах нь байгаль дэлхийг улам чимжээ. Энэ зураглал бол АНУ-ын Денвер мужийн Wyoming хотын Powder голын хөндий. Харин тэр тал хөндийн хэвлий дэх байгалийн баялгийг хэдийнэ ухаад авчирсан гэсэн Reobody компанийн мэргэжилтнийн үгийг сонсоод бидний хэдэн сэтгүүлч дуу алдаж билээ. Газрын дор нуугдах баялгийг ухааж аваад нөхөн сэргээлтийг үнэхээр ийн хийдэг бол янз бүрийн санал гомдол юунд гарч, бас харуусал төрөх билээ гэж тэрхэн үед бодогдож байлаа. Монголчууд өнгөрсөн он жилүүдэд өвөг дээдсээс үлдээсэн баялгаа ашиглаж байна гээд газраа ухааж, сүйтгээд үзэсгэлэнт сайхан нутаг усаа бөмбөг дэлбэлсэн мэт болгож хаясан болохоор тэр. “Бид нөхөн сэргээлт хийхдээ тухайн газар нутгийг 100 хувь биш ч 90 гаруй хувийн хэмжээнд эргэн хэвэнд нь оруулж чаддаг гэж Reobody компанийн мэргэжилтэн тайлбарласан юм. Тэгвэл манайд 98 бүү хэл 50 хувьд хүрэхүйц нөхөн сэргээлт хийж чадаж байгаа бил үү.

Сүүлийн үед Монгол Улсад уул уурхай хурдацтай хөгжиж байгаатай уялдан хариуцлагатай уул уурхайн талаар ихэд ярих боллоо. Энэ бол дэвшил. Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уурхайн санаачлага ТББ ч байгуулагдаад үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Талуудын эрх ашгийг тэгш хангах зорилготой Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уурхайн санаачлага ТББ-аас хариуцлагатай уул уурхайн найман зарчмын хүрээнд шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, дөрвөн компани дээр туршиж эхлээд байгаа бөгөөд давуу болон сул талыг гаргаж ирсний дараа төрд тодорхой санал боловсруулж хүргэх аж. Олон улсад бол тогтвортой хөгжил, ил тод санаачлага гэсэн нэрээр байгууллагууд байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг юм байна.

Тиймээс гурван талын эрх ашгийг хамгаалсан төлөөлөл бүхий эднийх шиг байгууллага бусад оронд байдаггүй тул гадныхан ихээхэн сонирхож, үр дүн хэр байхаас шалтгаалан туршлага хуваалцах талаар ярьж байгаа аж. Мөн тус байгууллага орон нутаг болон нутгийн иргэдтэй харилцах анхдугаар чуулга уулзалтыг хийж, Австралийн Квийсландын их сургуультай хамтран хоёр ч сургалт зохион байгуулсан нь компаниудын хувьд ач холбогдолтой хариуцлага хэрхэн дээшлүүлэхэд мэдлэг өгсөн арга хэмжээ болжээ.

Хариуцлагатай уул уурхай гэхээр зөвхөн байгаль орчны асуудал биш аж. Бүх оролцогч талуудын, ялангуяа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэсэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, олон улсын шилдэг туршлагад тулгуурлаж, хууль сахиу ёсыг дээдэлсэн, Монгол Улсад байнгын ашиг орлого оруулж байх эрдэс баялгийн салбар дахь ил тод, цогц үйл ажиллагааг хариуцлагатай уул уурхай гэнэ хэмээн тодорхойлжээ. Яг энэ тодорхойлолт өнгөрсөн хугацааны манай уул уурхайн салбарын үйл ажиллагаатай төдийлөн нийцэхгүй гэж хэлэхэд хилсдэхгүй болов уу. Уул уурхайн зохисгүй үйл ажиллагаанаас олон аймгийн газар нутаг сүйтгэгдэж, ард иргэд хохирч үлдсэн нь нууц биш. Нэгэн үе орон нутгийнхан уул уурхайн компаниудыг үйл ажиллагаа явуулахад нь ихээхэн хүндрэл учруулж, дарамталдаг, мөнгө төгрөг нэхдэг, орон нутгийн захиргаанаас нь зөвшөөрөл олгодоггүй зэрэг асуудал байнга гаргадаг байлаа. Энэ тухай тус салбарын бизнес эрхлэгчид төрийн түшээдэд хандан гомдоллох нь цөөнгүй байв. Нөгөө талаар компаниудын зүгээс байгаль орчны менежмент хэрэгжүүлдэггүй, тайлан тэнцлээ үнэн зөвөөр гаргадаггүй, хүлээх хариуцлага сул, байгаль хамгаалах чиглэлд ямар ч ажил хийлгүй байгаль орчны байцаагчдыг нүд хуурсан бичиг цаасаар аргалж өнгөрөөх байдал газар авсан байсан. Харин төрийн хувьд хууль

дүрмээ боловсронгуй болгож, чанд мөрдүүлэх, мөн аж ахуйн нэгжийн хариуцлагыг өндөрсгөх талаас туйлын хангалтгүй ажиллаж ирсэн. Өнөөдөр 50-250 мянган төгрөгийн торгууль уул уурхайн компаниудад дэндүү инээдэмтэй биш гэж үү. Гэтэл тэд дээрхээс хэд дахин илүүгээр байгаль дэлхийг хохироосоор байдаг шүү дээ.

Уг нь хариуцлагатай уул уурхайн зарчмаар бол олон талын оролцоог хангаж, эхнээсээ л биенээ ойлгож, дэмжиж ажиллавал илүү амжилтад хүрдэг гэдгийг Австралийн Квийнсландын их сургуулийн Тогтвортой уул уурхайн хүрээлэнгийн Уул уурхайн нийгмийн хариуцлагын төвийн захирал Дэвид Бреретон ярьж байна.

Өөрөөр хэлбэл, уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулж эхлэхээсээ өмнө тухайн бүс нутагт байгаль орчны үнэлгээг нарийн сайн хийлгэж, мөн төртэй хамтарч ажиллахын зэрэгцээ орон нутгийн иргэдтэй хэл амаа ололцож ажиллавал дараа нь ямар нэг бэрхшээл гараад байхгүй аж. Төрийн зүгээс нутгийн иргэдийн оролцоо ямар байх, тухайлбал, уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих, нөхөн сэргээлтэд хэрхэн оролцох чиглэлээр хуульчилж өгвөл асуудал илүү тодорхой болно гэж байгаль орчны мэргэжилтнүүд үздэг. Уул уурхай өндөр

хөгжсөн орнуудын иргэдийн уул уурхайн талаарх мэдлэг боловсрол өндөр учраас хэл ам гараад байдаггүй, нөгөө талаар компаниуд нь үйл ажиллагаагаа эхнээс нь хуулийн хүрээнд олон нийтэд ил тод мэдээлэл өгч ажилладаг байна. Мөн бусад оронд жижиг, том гэлтгүй уул уурхайн чиглэлийн бүх компани байгаль орчин хариуцсан газар, хэлтэс, мэргэжилтэнтэй байдаг аж. Тэр мэргэжилтэн нь байгаль орчны тодорхой төлөвлөгөө боловсруулж, шаардлагатай хөрөнгө мөнгийг байгууллагаасаа гаргуулж ажилладаг туршлага дэлхийд түгээмэл гэнэ.

Харин сүүлийн жилүүдэд манай томоохон аж ахуйн нэгжүүд байгаль орчны мэргэжилтэнтэй болж, томоохон компаниуд нь олон хүний бүрэлдэхүүнтэй газар, хэлтэс байгуулж ажиллаж байгаа нь сайшаалтай.

Уул уурхайн салбарын эрчимтэй хөгжлөөс орж ирэх мөнгийг улс орны хөгжил болон ард иргэдийн амьдралыг хэрхэн дээшлүүлэхэд зарцуулах талаар ярихаас гадна байгаль орчны ирээдүйн нөлөөллийг одооноос харж, зөв зохистой бодлого явуулж ажиллахад хариуцлагатай уул уурхайн талуудын оролцоо хамгаас чухал юм гэдгийг эцэст нь тэмдэглэе. ■

Coal Mongolia 2011

Нүүрсний Монгол дэлхийн тавцанд...

Монголыг “Нүүрсний Саудын Араб болно” гэсэн Роберт Фрийдландын үг бодит амьдрал дээр биеллээ олж эхэллээ. Манай нүүрсний олборлолт, экспортын хэмжээ гэрлийн хурдаар нэмэгдэж буйн зэрэгцээ нөөцөөрөө дэлхийд толгой цохих Тавантолгойн орд өнөө маргаашгүй эдийн засгийн эргэлтэд орох гэж байна. Энд олборлолт хийхийн тулд уул уурхайн “акулууд” өрсөлдөж, “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг хаана гаргахыг хэлэлцэхийн тулд дэлхийн тэргүүлэх банкирууд Улаанбаатарт ирж, олон улсын томоохон хэвлэлүүдийн эхний нүүрийг “Монгол нүүрс” гэх үг чимэглэн харагдах болжээ...

Өнөөдөр манай эдийн засгийн зүтгүүр зэс биш, нүүрс болсныг гэрчлэх тоо баримт мундахгүй. 2010 онд монголчуудын экспортолсон зэсийн баяжмал 770.6 сая доллар болсон бол нүүрсний экспортын орлого түүнээс 100 гаруй сая доллараар давж, 877.6 сая долларт хүрчихээд байна. 2008 онд манай улс 4.2 сая тонн нүүрс экспортолж

байсан бол хоёрхон жилийн дотор энэ үзүүлэлт дөрөв дахин нэмэгдэж, 16.6 сая тоннд хүрчээ. Үүний хажуугаар Монголын аж үйлдвэрлэл 2010 онд өмнөх жилийнхээсээ 10 хувиар өсөхөд нүүрсний олборлолт 91.8 хувиар нэмэгдсэн нь чухал түлхэц болсон тухай мэргэжилтнүүд тэмдэглэж байгаа юм.


Хоёрхон жилийн дотор манай нүүрсний салбар танигдахын аргагүй томорчээ. Монгол нүүрс моодонд орж, Монголын компаниуд олон улсын хөрөнгийн зах зээлд хөл тавилаа. “Энержи ресурс” буюу “Mongolian mining corporation” Хонконгийн хөрөнгийн биржид хувьцаагаа гаргасан бол нүүрсний хайгуулын “Хүннү коал” компани Австралид IPO хийснийг сануулах юун. Дээрээс нь дэлхийн нүүрсний зах зээлд “Монгол нүүрс” гэх шошготой Монголын төрийн өмчит “акул” шинэ тоглогч болон мэндэллээ.

Энэ бол мэдээж “Эрдэнэс МГЛ”-ын харьяа “Эрдэнэс Тавантолгой” компани юм. “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг олон улсын

хөрөнгийн биржид гаргахын тулд “HSBC”, “Deutsche”, “Credit Suisse”, “Citi”, “Macquarie”, “Morgan Stanley” зэрэг дэлхийд тэргүүлэх 20 гаруй хөрөнгө оруулалтын банк төлөөлөгчөө Монгол руу илгээгээд байна.

Тавантолгойн хамгийн сайн судлагдсан Цанхийн зүүн хэсэгт “Эрдэнэс МГЛ” өөрөө хөрөнгө оруулаад, ашиглах билээ. Эхний

Хятадын коксжих нүүрсний импорт
2010 онд (нийт 34,4 сая тн)



ээлжинд эндээс жилдээ 15 сая орчим тонн нүүрс олборлоно гэсэн тооцоо байгааг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт онцолж байв. “Хөрс хуулалт эхэлчихсэн бөгөөд нүүрс олборлох ажилд бэлэн болсон” хэмээн тэрбээр тэмдэглэсэн юм. Олборлолтыг явуулах гэрээт гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад БНЭУ-ын “MESCO Steel”, Австралийн “Macmahon”, ХБНГУ-ын “BVM Operta” гурав өрсөлдөж буй ажээ. Харин Цанхийн зүүн хэсэгт олборлолт явуулах стратегийн хөрөнгө оруулагчийн сонгон шалгаруулалтад гадаад, дотоодын 15 компани, консорциум хүчээ сорьж байна. Энэхүү хоёр талбайн аль аль нь энэ ондоо багтан ашиглалтад орох хандлагатай байгаа юм. Юу хэлэх гээд байна вэ гэхээр 2011 онд нүүрс олборлолт, экспортын хэмжээ өмнө нь төсөөлж байгаагүйгээр нэмэгдэх нь тодорхой болжээ. Харин энэ талд төрийн бодлого байна уу гэдэг нь сонирхол татна.

Олон жилийн турш “Эрдэнэт” үйлдвэр Монгол орны төсвийг авч явсан. Одоо харин энэ байдал эрс өөрчлөгдөхөөр байгааг өсөн томорч буй нүүрсний салбар харуулж байгаа юм. Гэвч Монгол Улсын 2011 оны төсөвт нүүрсний салбараас ямаршуухан орлого төвлөрүүлэхийг тоймтой тусгаагүй байгаа нь хачирхалтай. Эдүгээ 68 хувийн татвар цуцлагдсан болохоор “Эрдэнэт”-ээс төсвийн хувин руу саах мөнгө огцом багасах нь дамжиггүй. Харин нүүрсний экспортын хэмжээ зэсийн баяжмалынхаас давчихаад байгаа учир 2011 онд төсөвт нэлээд хэмжээний мөнгө төвлөрүүлэх нь ойлгомжтой бус уу. Уг нь нүүрсний компаниудаас хэдий хэмжээний татвар авахаа тооцоолж, эргүүлээд энэ салбарыг төрөөс яаж дэмжихээ бодох цаг болжээ.

“Монгол нүүрс” дэлхийн брэнд болох гэж буйтай зэрэгцэн Монголын нүүрсний салбарт цэгцлэх, цэвэрлэх ажил даанч их байгааг мэргэжилтнүүд анхааруулж байгаа юм. Нүүрсийг чанарынх нь дагуу маш олон ангилдаг учраас нэгдсэн үнэ байдаггүй нь нэг асуудал болдог. Цахилгаан станцуудад нийлүүлэх нүүрсний үнийг төр хянадаг учир төвийн эрчим хүчний

системийг түүхий эдээр хангадаг хэдэн уурхай элгээрээ хэвтэх гээд байна хэмээн гомдоллодог шүү дээ. За тэгээд гадагш нь гаргаж байгаа нүүрсний үнэ ч ярвигтай. Хүрэн нүүрс, чулуун нүүрс, коксжих нүүрс гээд л үнэ нь өөр өөр. Дээрээс нь компаниуд худалдан авагч нартайгаа хийсэн гэрээнээс хамаараад ханш нь мөн л ялгаатай байна.


Харин төр, засаг нөөц ашигласны төлбөрөө авахдаа Хятадын <http://www.coalworld.net> гэдэг цахим хуудаснаас үнийг нь авч, жишиг үнэ тогтоодог байна. Энэ нь компаниудын гэрээлэн зарж буй бодит үнэтэй ижил байна уу, үгүй юү гэдэг нь хэнд ч падлийгүй. Учир нь, үнэ тогтоох зөвлөлд салбарын аж ахуйн нэгжүүдээс ямар ч төлөөлөгч байдаггүй ажээ.

Өнөөдөр “Монгол нүүрс” Хятад хэмээх ганцхан худалдан авагчтай байгаа нь дараагийн томоохон асуудал юм. БНХАУ-ын нүүрсний гол нийлүүлэгч Австрали байсан бол эдүгээ энэ байр сууриа монголчуудад алдаж эхэлсэн тухай “Саусгоби ресорсез” компанийн ерөнхийлөгч Александр Моленокс тэмдэглэсэн. 2009 онд БНХАУ нийт 34.5 сая тонн коксжих нүүрс импортолсны 66 хувийг Австрали, 11 хувийг Монгол Улс нийлүүлсэн. Тэгвэл өнгөрсөн онд монголчууд 30 гаруй хувийг нь дангаараа хангасан байх жишээтэй. “Ёроолгүй ходоод” хэмээх БНХАУ-ын нүүрсний импорт энэ онд 63 хувиар нэмэгдэж, 200 сая тоннд хүрэх таамаглал байгаа нь “хар алт”-аар хэт баян бидний хувьд мэдээж сайн мэдээ. Гэвч монголчууд нүүрсийг өндөр үнээр авдаг Япон, БНСУ зэрэг оронд нийлүүлэлт хийж, олон худалдан авагчтай болох хэрэгтэйг мэргэжилтнүүд зөвлөсөөр. Өнгөрсөн оны сүүлчээр манайх нүүрсээ Владивостокоор дамжуулж дэлхийн зах зээлд гаргах туршилт хийсэн нь сайн хэрэг л дээ. Одоо энэ туршилтаа бодит амьдрал дээр ажил хэрэг болгох л үлдлээ.

Гэхдээ бид мөнхөд нүүрсээ түүхийгээр нь гаргасаар байх уу гэдэг нь бас нэг том асуудал юм. Хувийн компаниуд санаачилгатай байж, бүтээгдэхүүнээ боловсруулахад анхаарч эхэлснийг сайшаалтай. Ухаа худагт үйл ажиллагаа явуулдаг

“Энержи ресурс” энэ онд долоон сая тонн нүүрс олборлож, баяжуулахаар төлөвлөжээ. Эдний баяжуулах үйлдвэр юу юугүй ашиглалтад орохоор байна. MCS групп нүүрснээс хийн түлш гаргах үйлдвэр байгуулж, энэ оны сүүлч гэхэд ашиглалтад оруулах зорилготой ажиллаж байна. Гэхдээ нүүрсээ боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тал дээр төрийн бодлого үгүйлэгдэж байгааг олон хүн хэлж буйг дуулгая. Нүүрснээс шингэн түлш гаргах үйлдвэр байгуулж, түлш шатахууны хэрэглээгээ гадаадаас 100 хувь импортлохоо болих боломж байсаар байтал эрх баригчид анхаарч, ажил хэрэг болголтгүй өдий хүрсэн шүү дээ.

Монголын нүүрсний экспорт (мян.тн)



Нөгөө талаар монголчууд бидний хувьд юу юунаас илүү чухал нэг асуудал бий. Энэ бол яах аргагүй байгаль орчны хамгаалал буюу нөхөн сэргээлт. Хэчнээн сайхан техник, технологи байлаа гээд уул ус, өвс мод маань оронгоороо эргэж байхыг хараад ямар ч монгол хүний зүрх шимшрэхгүй байна гэж үгүй биз ээ. Төр, засаг одооноос л байгаль орчны нөхөн сэргээлтийн тал дээр өндөр шаардлага тавьж эхлэх хэрэгтэй байна.

Мэдээж нөхөн сэргээлтийг яаж ч хийсэн унаган байгаль сэргэнэ гэж үгүй. Гэхдээ уурхай байсан газрыг өмнө нь байснаас ч үзэмж төгөлдөр болгож, амралт зугаалга, аялал жуулчлалын бааз болгосон байх нь ХБНГУ, АНУ, Австрали гээд олон оронд түгээмэл. Байгаль орчны нөхөн сэргээлтийг хамгийн сайн, сүүлийн үеийн технологийн дагуу хийж чадаж байж л Монгол Улс жинхнээсээ “Нүүрсний Саудын Араб” болох буюу. ■

Чуулга уулзалт

“Coal Mongolia 2011” чуулга уулзалт Монголын нүүрсийг үнэд хүргэхэд тусална



Монголчууд бид азтай, баян ард түмэн. Учир нь манай улсад асар их нүүрсний нөөц бий. Өнөөгийн байдлаар 162 тэрбум тонн нүүрсний нөөцтэй гэж байгаа ч судалгаагаар энэ тоо цаашид өсөх боломжтой. Ийм ч учраас уг салбарт дэлхийд тэргүүлэгч Австрали хүртэл манай улсын нүүрсний нөөц баялагаас эмээж байна. Тэгвэл энэ их баялагийг хэрхэн зөв зүйтэй ашиглах асуудал дээр долоо хэмжиж нэг огтлох зарчим баримтлах учиртай хэмээн салбарынхан үзэж байна. Иймээс Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Ашигт малтмалын газар, Монголын уул уурхайн мэдээллийн нэгдсэн сан хамтран олон улсын хөрөнгө оруулагчдын “Coal Mongolia-2011” чуулга уулзалт, үзэсгэлэнг энэ сарын 24, 25-нд “Чингис хаан” зочид буудалд зохион байгуулах гэж байна. Чуулга уулзалтын гол уриа “Монгол-дэлхийн эрчим хүчний шинэ тоглогч” агаад үндсэн болон салбар хуралдаан гэсэн хоёр хэсгээс бүрдэх юм.

Үндсэн хуралдаанаар Монгол Улсын нүүрсний салбарын бодлого, төлөвлөлтийн талаар ярилцана. Тухайлбал, “Монгол Улсын нүүрсний салбарын бодлого, төлөвлөлт”, “Нүүрсний зах зээл ба гадаад худалдаа”, “Нүүрсний техник технологи ба ханган нийлүүлэлт”, “Нүүрсний хөрөнгө оруулалтын төслүүд ба үйлдвэрлэл”, “Нүүрсний тээвэрлэлт ба дэд бүтэц” зэрэг сэдвүүдээр хоёр өдөр хуралдах болно. Харин салбар хуралдаанаар нүүрсний хайгууль олборлолтын техник технологи, ТЭЗҮ, зураг төсөл, нөхөн сэргээлт зэрэг сэдвээр илтгэлүүд тавигдах юм.

Товчхондоо, нүүрсний салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Монголын нүүрсийг дэлхийн зах зээлд хүргэх гарц, замуудыг нээх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд “Coal Mongolia 2011” чуулга уулзалт, үзэсгэлэнгийн зорилго оршиж буй хэмээн дүгнэж болно.

Чуулга уулзалтад салбарын бүхий

л төлөөлөл оролцож байна. Тухайлбал, хурлыг нээж ЭБЭХ-ний сайд Д.Зоригт “Монголын нүүрсний салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага”, АМГ-ын дарга Д.Батхуяг “Монгол Улсын нөөц баялаг ба үйлдвэрлэлийн хэтийн хандлага” сэдвээр илтгэл тавих юм. Үүнээс гадна уг салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын удирдлагууд, олон улсын байгууллагын болон хөрөнгийн биржийн төлөөлүүд илтгэл тавих болно. Энэ үеэр нүүрсний хэрэглээгээр дэлхийд тэргүүлэгч Хятад улсын энэ салбар дахь бодлого, чиг хандлага, Тяньжины далайн боомт, Олон улсын хөрөнгийн зах зээлд уул уурхайн төсөлд санхүүжилт босгох, Тавантолгойн орд ашиглалтын стратеги төлөвлөлт, Макро эдийн засагт нүүрсний салбараас үзүүлэх нөлөө, Уул уурхайн дэд бүтэц- тулгарч буй бэрхшээл болон шийдвэрлэх боломжууд зэрэг сонирхолтой сэдэв бүхий илтгэлүүд ч тавигдах юм.

Хурлыг дагасан үзэсгэлэнгийн танхим ерөнхий болон ивээн тэтгэгчийн гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Одоогийн байдлаар нүүрсний салбарт үйл ажиллагаа явуулж буй 37 компани үзэсгэлэнгээ гаргахаар бүртгүүлээд байна. Ер нь чуулга уулзалтад 403 байгууллагын 450 гаруй зочин төлөөлөгч оролцох агаад нийт оролцогчдын 35 орчим хувь нь Хятад, Австрали, Канад, Герман, Өмнөд Солонгос, ОХУ зэрэг 12 орноо ирсэн төлөөлөгчид байх юм.

Чуулга уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, нүүрсний салбарт онцгой ач холбогдол өгөн сэтгэл зүтгэлээ зориулж буй үйлдвэрлэгч, аж ахуй нэгжид талархалаа илэрхийлж байна. Бидний үйл ажиллагааг салбартаа нэр хүнд бүхий, тэргүүлэгч аж ахуй нэгж болох “HUNNU COAL”, “GEM-COM SOFTWARE INTERNATIONAL INC”, “EN-ERGY RESOURCES”, “PROPHECY RESOURCES INC”, “MOEN-CO LLC”, “Худалдаа хөгжлийн банк”, “WORLEY PARSONS”, “MONNIS INTERNATIONAL” зэрэг олон арван байгууллага ивээн тэтгэж буй юм.

Дашрамд дурьдахад, Монголын уул уурхайн мэдээллийн нэгдсэн сан Mining.mn-ээс Ашигт малтмалын газартай хамтарч зэс, төмрийн хүдэр, газрын ховор элемент зэрэг сэдвээр тусгайлан хурлууд зохион байгуулахаар төлөвлөсөн агаад эхнийх нь нүүрсний салбар болж байна. ■

PLATINUM SPONSORS			GOLD SPONSORS			BANK OF THE EVENT		
SUPPORTING ORGANIZATIONS								
SPONSORS								
OFFICIAL MEDIA OF THE EVENT								
2011.02.24-25 ЧИНГИС ХААН ЗОЧИД БУУДАЛ УЛААНБААТАР ХОТ			2011.02.24-25 CHINGGIS KHAAN HOTEL УЛААНБААТАР					

Их бүтээн байгуулалтын өмнөх бужигнаан

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Улаан нуурын хөндийд их бүтээн байгуулалтын өмнөх бужигнаан өрнөж байна. Ухаа худагт үйл ажиллагаа явуулж буй “Энержи ресурс” компани нүүрс боловсруулах үйлдвэрээ юу юугүй ашиглалтад оруулахаар шамдаж байх зуур орон нутгийн “Тавантолгой” компани олборлосон нүүрсээ урд хөрш рүү зөөсөөр. Үүний хажуугаар төрийн өмчит “Эрдэнэс МГЛ” “Эрдэнэс Тавантолгой” хэмээн “охин” төрүүлж, таван тивийн уул уурхай, банк санхүүгийн “акул”-уудыг даллан, Монголын төдийгүй олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн анхаарлын төвд ороод буй. Таван сарын турш тасралтгүй хөрс хуулаар эдүгээ Цанхийн зүүн хэсгийн уурхайн амыг нээсэн тухай “Эрдэнэс МГЛ” компанийн гүйцэтгэх захирал Б.Энэбиш учирлав. Зөвхөн энэ хэсгээс л гэхэд 2011 онд 1-2 сая тонн нүүрс олборлон экспортолж, 4-5 жилийн дараа уг үзүүлэлтийг 15 сая тоннд хүргэх төлөвлөгөө бий. “Эрдэнэс Тавантолгой” компани “бор зүрхээрээ” хариуцаж, борлуулалтаа өөрөө хийх Тавантолгойн Цанхийн зүүн хэсэгт гэрээгээр олборлолт хийж өгөх компанийн сонгон шалгаруулалтад БНЭУ-ын “Mesco Steel”, ХБНГУ-ын “BVM Orgeta”, Австралийн “Masrahon” өрсөлдөж байна.

Харин Тавантолгойн Цанхийн баруун хэсэгт үйл ажиллагаа явуулах стратегийн хөрөнгө оруулагчдын сонгон шалгаруулалтад дотоод, гадаадын 15 компани, консорциум саналаа ирүүлээд байгааг дор танилцуулав. Удахгүй эдгээр компанийг шигшиж, хураангуй жагсаалт гаргаад, Засгийн газраас томилсон Ажлын хэсэг хэлэлцээрийн ширээний ард суух билээ. Ингэхдээ мэдээж мөнөөх угтуулан тавих нөхцөл, урьдчилгаа төлбөр энэ тэрээгээ ярилцах нь ойлгомжтой. Дээрх 15 компани, консорциумуудын танилцуулгыг хүргэж байна.


1. БНХАУ-ын “Shenhua Energy” болон Японы “Mitsui & Co” компанийн консорциум

1995 онд байгуулагдсан Хятадын төрийн өмчит “Shenhua Energy” компани нүүрс олборлолт, тээвэрлэлт болон технологийн үйлчилгээгээр улсдаа “№1”. БНХАУ түлшний хэрэгцээнийхээ 70 гаруй хувийг нүүрсээр хангадаг учир “Shenhua group” корпорацийн охин компани “Shenhua Energy” өсөн нэмэгдэж буй “хар алт”-ны хэрэгцээгээ хангахад голлон анхаарч буй. Харин 1947 онд байгуулагдсан Японы “Mitsui & Co” компани нь ган, төмрийн үйлдвэрлэл, хими, дэд бүтэц, автомашин, эрчим хүч, хүнс, харилцаа холбоо, худалдааны салбарт аль хэдийнэ байр сууриа эзэлжээ. Тус компани өнөөдөр дэлхийн 65 улсад үйл ажиллагаа явуулж байна.

2. Монголын “Монголын Алт” групп

1993 онд байгуулагдсан МАК групп уул уурхай, барилга, аялал жуулчлалын салбарт амжилттай ажиллаж буй. 1994 онд Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Их Галтын алтны шороон ордод үйл ажиллагаа явуулснаар эрдэс баялгийн салбарт эргэлт буцалтгүй оржээ. Харин 1998 онд Дорноговь аймгийн Алагтогоогийн ордыг илрүүлснээр нүүрсний

Тавантолгой орд нь Цанхи, Ухаа худаг, Зүүн болон Бортолгой гэсэн хэсгээс бүрддэг. “Эрдэнэс МГЛ”-нд 68.000 га газар эзэмидэг бол “Энержи ресурс” Ухаа худагийг буюу 4000 га газрын тусгай зөвшөөрлийг авсан байгаа. Харин орон нутгийн “Тавантолгой” компани нийт 270 га газар эзэмидэг аж.



салбарт хөл тавьсан байна. 2002 онд Өмнөговь аймгийн Нарийн сухайт нүүрсний төсөлд ажиллах Монгол-Хятадын “Чин Хуа-МАК-Нарийн сухайт” компанийг үүсгэн байгуулсан бол эдүгээ үүнээс гадна Элдэвийн нүүрсний уурхай, Адуунчулууны нүүрс боловсруулах төслийг хэрэгжүүлж байгаа юм. Нүүрсний олборлолт, экспортоороо МАК нь Монголдоо толгой цохих компани билээ.

3. Люксембургийн “ArcelorMittal”

Гангийн үйлдвэрлэлээр дэлхийд дээгүүрт орох “ArcelorMittal” компани нь 1989 онд байгуулагдсан бөгөөд өөрийн бүтээгдэхүүнээ автомашин, барилга, гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрүүдэд нийлүүлдэг. 2010 онд тус компани 78 тэрбум ам.долларынашигтай ажиллаж, 90.6 сая тонн боловсруулаагүй ган үйлдвэрлэсэн нь дэлхийн нийт нийлүүлэлтийн найман хувийг эзэлж байгаа юм. Алжир, Босниа, Канад, Казахстан, Мексик, Украин, АНУ-д уул уурхайн ажил эрхэлдэг “ArcelorMittal” компани гангийн үйлдвэрлэлийнхээ түүхий эдийг бие даан гаргаж авах зорилготой. Одоогоор тус компани үйлдвэрийнхээ хэрэгцээний төмрийн хүдрийн 46, нүүрсний 13 хувийг өөрсдийн уурхайгаас хангадаг байна.

4. БНХАУ-ын Өвөрмонголын “Yitai” групп

Өвөрмонголын “Yitai coal” компани 1997 онд үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд нүүрсний худалдаа, тээвэрлэлт, үйлдвэрлэлээр дагнадаг байна. Үүний хажуугаар тус компани зочид буудал, рестораны үйлчилгээ эрхэлж, мөн уламжлалт анагаах ухаанд хэрэглэгдэх эмийн ургамлуудыг тариалдаг аж. 2009 оны байдлаар “Yitai coal” компани 27.7 сая тонн нүүрс борлуулжээ.

5. АНУ-ын “Peabody Energy”

125 жилийн түүхтэй “Peabody energy”-г дэлхийн нүүрсний хамгийн том хувийн компани хэмээн нэрлэдэг.

2010 онд тус компани 246 сая тонн нүүрс борлуулж, долоон тэрбум ам.долларын орлоготой ажиллажээ. Тэд АНУ-ын эрчим хүчний 10 хувийг дангаараа бий болгодог бөгөөд дэлхийн 23 оронд бүтээгдэхүүнээ нийлүүлдэг аж. АНУ, Хятад, Австралид төвлөрч олборлолт хийдэг “Peabody energy”-гийн уурхайнууд нийт есөн тэрбум тонн нүүрсний нөөцтэй аж.

6. ОХУ-ын “En +”

Оросын олигарх Олег Дерипаскагийн “En +” групп 2002 онд байгуулагдсан бөгөөд дэлхийн хөнгөн цагааны “акул” болох “Русал” компанийн 47.41 хувийг эзэмшдэг. Үүний зэрэгцээ эрчим хүч, ураны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Харин 2008 онд Эрхүүгийн “ВостСибУголь” гэх жилдээ 12 сая тонн эрчим хүчний нүүрс олборлодог томоохон компанийг худалдаж авснаар нүүрсний салбарт хүчээ сорьж эхлэв. Эдүгээ “En +” групп Эрхүүгээс гадна Якутад ч нүүрсний уурхай ажиллуулж байна.

7. Австралийн “Fortescue Metals”

Төмрийн хүдрийн “Fortescue Metals” компани баруун Австралийн баялаг Пилбарад томоохон уурхай эзэмшдэг аж. 2003 онд байгуулагдсан залуу компани хэдий ч 2008 оноос далайн тээврээр БНХАУ-ын гангийн томоохон үйлдвэрүүдэд түүхий эд нийлүүлж байна.

8. Бразилийн “Vale”

1942 онд үүсэн байгуулагдсан Бразилийн төрийн өмчит “Companhia Vale do Rio Doce” компани ердөө долоон жилийн дараагаас тус улсын төмрийн хүдрийн экспортын 80 хувийг бүрдүүлж эхэлсэн байна. 1974 онд “Vale” төмрийн хүдрийн экспортоороо дэлхийд тэргүүлсэн бөгөөд энэ байр сууриа өнөөг хүртэл алдсангүй. 1997 онд хувьчлагдсанаасаа хойш уул уурхайн үйлдвэрлэлээ эрчимжүүлж, никель, зэс, хөнгөн цагаанаараа дэлхийд томоохонд орох болсноос гадна таван тивийн 38 оронд салбараа нээж амжжээ. Сүүлийн үед нүүрсний салбарт хүч үзэхээр эзхэж буй “Vale”-гийн овоо хараанд Монголын Тавантолгойгоос гадна Африк, Мозамбикийн аварга ордууд өртсөн юм. Эдүгээ тус компани Мозамбик улсад жилдээ 14 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай 70 жил наслах уурхай эзэмшдэг бол Австралийн Квинслэнд мужид 2.7 тэрбум тонн нүүрсний нөөцтэй төсөл хэрэгжүүлж байна.

9. Оросын төмөр зам, Японы консорциум болон БНСУ-ын консорциумуудын нэгдэл

Манай “Улаанбаатар төмөр зам”-ын 50 хувийг эзэмшдэг ОХУ-ын төрийн өмчит “Оросын төмөр зам” компани Тавантолгойн нүүрсийг дэлхийн зах зээлд гаргах шинэ төмөр замын мөн л 50 хувийг эзэмшихээр болсон билээ. Эдүгээ тус компани Японы “Itochu”, “Sumitomo”, “Sojitz”, “Magubeni” зэрэг аварга корпоративтай нэгдэн Тавантолгойд хүчээ сорьж байна. Мөн, БНСУ-ын төрийн өмчит КОРЕС-ийг ч эгнээндээ нэгтгэж дөнгөв. 1967 онд байгуулагдсан, Австрали, Индонезид нүүрсний төсөл хэрэгжүүлж буй КОРЕС-ийн ард “Posco”, “Samsung”, “LGI” зэрэг дэлхийд толгой цохих нутаг нэгтнүүд нь зогсож байна. Тавантолгойн нүүрсийг “Оросын төмөр зам”-ын барих 1100 км шинэ төмөр замаар хойд хөршийн Восточный, Ванино боомтод хүргэж, тэндээсээ Япон, БНСУ-д нийлүүлэх нь манай засгийн зорилго. Тэгэхээр энэхүү нэгдэл нэгийг өгүүлж байх шиг...

10. БНЭУ-ын “Mesco Steel”

Энэтхэгийн “Mesco Steel” компани 1992 онд байгуулагдсан бөгөөд төмрийн хүдрийн томоохон ордуудад үйл ажиллагаа явуулдаг байна. Олборлосон төмрийн хүдрээ хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд технологийн тал дээр БНХАУ-ын “Sino Steel” корпоративтай хамтран ажилладаг аж. “Mesco” групп нь мөн Агаарын тээврийн “Mesco Airlines” компанийг өөртөө нэгтгэдэг байна.

11. БНЭУ-ын “International coal venture”

“International Coal Venture” корпораци нь 2009 онд байгуулагдсан шинэхэн “тоглогч”. Нүүрс олборлох, ган хайлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Энэтхэгийн томоохон компаниудын хувьцааг худалдаж авчээ.

12. Монголын “Монголын авто замын компаниудын нэгдэл” консорциум

2010 онд УИХ-ын баталсан “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн дагуу 5572 км хатуу хучилттай автозам, 997 км хурдны зам, 1100 км төмөр замын далангийн барилга байгууламжийн ажилд хамтран зүтгэхээр авто замын тусгай зөвшөөрөл бүхий үндэсний компаниуд одоо л нэгдэж эхэлж байна. Энэхүү шинэхэн консорциум багаа дөнгөж бүрдүүлж байгаа ч Тавантолгойн сонгон шалгаруулалтад хүч үзэхээр сэтгэл шулууджээ.

13. Австралийн “Xstrata coal”

Зэс, никель, цайрын олборлолтоор дэлхийд дээгүүрт орохын зэрэгцээ уул уурхайн технологи нийлүүлэгч “Xstrata” группийн нэг хэсэг “Xstrata Coal” нь эдүгээ Австрали, Өмнөд Африк, Колумб болон Канадын 30 гаруй ордод үйл ажиллагаа явуулж байна. Эрчим хүчний нүүрсний экспортоор “№1” гэгдэх тус компани коксжих нүүрсний дэлхийн тав дахь том үйлдвэрлэгч ажээ. Ази, Европ, Америкт бүтээгдэхүүнээ нийлүүлдэг “Xstrata Coal” 2010 онд 79.9 сая тонн нүүрс олборлосон байна.

14. БНХАУ-ын Өвөрмонголын “Erdos Chenglong Coal investment”

“Erdos Chenglong Coal investment” гэдэг компанийн тухай мэдээлэл тун ховор аж. Гэвч Өвөрмонголд “Erdos CTL” гэх нүүрснээс шингэн түлш гаргах төслийг “Shenhua Group”-ийн охин компани болох “Shenhua Coal Liquefaction” хэрэгжүүлдэг юм байна. 2004 онд барилгын ажил нь эхэлсэн уг төслийн хүрээнд өдөртөө 20 мянган баррель түлш үйлдвэрлэх боломжтой аж.

15. Монгол, БНХАУ-ын “Signum Industrial”

Монголын “Сигнум ресурс” компани Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн Аж үйлдвэрийн цогцолбор байгуулах төсөл боловсруулсан билээ. 2.2 сая тоннын хүчин чадалтай коксын үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, гангийн үйлдвэр, 500 мянган тоннын хүчин чадалтай зэс хайлуулах үйлдвэр, цементийн үйлдвэр, хоёр ч цахилгаан станц, Тавантолгой-Сайншандын 374 км төмөр зам бий болгохоор тусгасан дээрх төслөө хэрэгжүүлэх үүднээс “Signum Industrial” компанийг үүсгэн байгуулсан аж. Тавантолгойд түшиглэн байгуулах Аж үйлдвэрийн цогцолборт 5.1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хэрэгтэйг “Сигнум ресурс” компанийнхан тооцоолж байсан юм. ■



Эх сурвалж: www.eurasiaco.com

газрын ховор элементийн экспортоо 2010 оны сүүлийн хагас жилд 72 хувиар бууруулсан бол энэ онд ч дээрх хэмжээгээ 11.4 хувиар багасгаа мэдэгдэхийн зэрэгцээ газрын ховор металлын экспортын татвараа нэмэх шийдвэр гаргажээ. Одоогийн түвшнээр олборлолтоо 15-20 жилийн дараа Хятадын нөөц шавхран, эргээд гадаадаас импортлоход хүрнэ хэмээн тус улсын эрдэмтэд дүгнэснээс бүх зүйл эхэлснийг “Синьхуа” агентлаг мэдээлж байсан юм.

АНУ-ын Конгрессын дэргэдэх судалгааны газрын хийсэн тооцооноос үзэхэд дэлхий даяар жилд 124 мянган тонн газрын ховор элемент хэрэглэдэг бөгөөд 2012 он гэхэд энэ үзүүлэлт 180 мянган тоннд хүрч, 2014 онд хэрэгцээ бүр 200 мянган тонноос давах нь. Тэгэхээр хятадууд газрын ховор элементийн экспортоо багасгаж буй явдал өндөр технологи үйлдвэрлэгчдийг түгшээж байна. Тийм ч учраас АНУ-ын Конгресс газрын ховор элементийн хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулах компаниуддаа төрийн дэмжлэг үзүүлэх тухай шийдвэр гаргасан.

Харин германчууд Хятадыг аргадаж зөөлрүүлэх нь хамгийн зөв арга хэмээн үзэж буйг “Bloomberg” мэдээллээ. ХБНГУ-ын Таваарын агентлагын тэргүүн Уолкер Штайнбах “Бодит байдлыг хар л даа. Монгол, Африк, Грийнланд зэрэг орны шинэ эх үүсвэрийг хүлээхэд дор хаяж 5-10 жил шаардагдана.

Эдгээр орны дэд бүтцийн асуудлыг л шийдвэрлэхэд нэлээд хэдэн жил зарцуулна” гэж тайлбарлажээ. Үнэндээ ХБНГУ ч АНУ, Японы нэгэн адил газрын ховор элементийн нийлүүлэлтээ төрөлжүүлэхийн тулд Энэтхэг, Вьетнам зэрэг оронтой хамтран ажиллаж эхэлсэн. Өнгөрсөн арваннэгдүгээр сард манай Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг хамтран “Монгол улсад ховор металлд түшиглэсэн аж үйлдвэрийг хөгжүүлэх боломж” сэдэвт бага хурал зохион байгуулах үеэр Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн удирдагч Стефан Ханселман “Монголчууд газрын ховор элементийн хайгуул хийж, олборлолтын ажлыг эхлүүлэхэд манай улс шаардлагатай бүх дэмжлэгийг үзүүлнэ” гэж ярьсан. Үүнээс үзэхэд германчууд Монгол орныг ч мөн “онилж” амжсан бололтой.

Наран улстай түншлэх нь...

Япончуудын хувьд газрын ховор элементийн тал дээр Хятадаас 90 хувь хамааралтай. Японы Засгийн газар АНУ, Канад, Австрали болон Монголд хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж, газрын ховор металлын хангамжаа баталгаажуулахад зориулсан 150 сая ам.долларын сан бүрдүүлсэн.

“Toyota” компани хоёр жилийн

өмнө Вьетнамд газрын ховор элементийн хамтарсан компани байгуулсан. Мөн Энэтхэгт ч ижил төрлийн төсөл хэрэгжүүлж байгаа нь энэ оноос үйлдвэрлэлээ явуулах аж. Түүнчлэн “Sumitomo” болон “Toshiba” компани өнгөрсөн оноос Казахстанд газрын ховор элементийн төсөл хэрэгжүүлж байгаа гэсэн мэдээлэл бий. “Sumitomo” корпораци АНУ-ын “MolyCorp” компанитай байгуулсан гэрээнийхээ дагуу АНУ-аас ихээхэн хэмжээний газрын ховор элементийг Япон руу тээвэрлэхээр болж байна. Тус корпораци “MolyCorp” компанийн үйл ажиллагааг өргөтгөхөд 130 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхийн хажуугаар шинээр гаргасан хувьцааг нь 100 сая ам.доллараар худалдан авч, 30 сая ам.долларын зээл олгохоор төлөвлөжээ.

Харин манай улсын хувьд бол газрын ховор элементийн хайгуулын чиглэлээр Монгол, Японы хамтын ажил хэр урагштай байна вэ гэдэг нь хамгийн сонин. Ерөнхий сайд С.Батболд япон түнштэйгээ энэ тал дээр сайтар тохиролцож чадсанаар Японы судалгааны баг Монголд ирсэн билээ. Мөн ховор металлын болон ураны хүдрийн шинэ орд газар хайх ажиллагааг түргэтгэхэд туслах зорилгоор Япон улс ажиглалтын хиймэл дагуулыг Монгол Улсад худалдахаар шийдсэн тухай мэдээлэл ч цацагдаж байсан. ▶

Таван томоохон орд, 246 илэрц бий

АНУ-ын Геологийн судалгааны газрын мэргэжилтнүүдийн тооцоолсноор манайд 31 сая тонн газрын ховор элемент буюу дэлхийн нийт нөөцийн 16.77 хувь нь байх магадлалтай ажээ. Монгол Улсад газрын ховор элементийн томоохон таван орд, 246 орчим илэрц байх магадлалтайг шинжээчид тэмдэглэсэн. Гэвч манай оронд нарийвчилсан судалгаа хийсэн газар байхгүйтэй адил, багтай тогтоосон нөөц ч алга байгааг дотоодын геологчид ярьдаг. Тэгвэл Лондоны металлын бирж дэх зэсийн үнэ тодорхой байдаг шиг газрын ховор элементийг яв цав үнэлэх боломжгүй учраас 10 тэрбум доллар гэдэг Дэлхийн банкнаас гаргасан тойм тооцоо ч багагүй хэлбэлзэх биз ээ.

1990 оноос өмнө ЗХУ-ын эрдэмтэд шинжлэх ухааны зорилгоор Монголд газрын ховор элементийн судалгаа явуулж байсан аж. Тэр үед Ховд, Увс, Хэнтий, Сүхбаатар, Хөвсгөл аймгийн зарим хэсэгт газрын ховор элемент бий гэдгийг тогтоосон. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухаан болоод геологийн ерөнхий судалгаагаар газрын ховор элементийн нийт тархац Монгол Улсад нэлээд арвин гэдэг нь тодорхой болсон байна.


“Рео” ХХК 2005-2009 онд Лугийн гол ордод 3.6 сая доллар зарцуулсан тухай “Eurasia capital” компанийн шинжээчид судалгааны тайландаа дурджээ. Лугийн гол, Мушгиа худаг, Хотгор болон Халзанбүргэдэй ордод өмнө нь хайгуул хийж байсан бөгөөд нийт 6.6 орчим сая тонн газрын ховор элемент байх магадлалтай аж. Өмнөговь аймгийн Мандалговь суманд орших Мушгиа худаг ордыг 1974 онд Орос, Монголын геологичид судалж байжээ. Тухайн үед Мушгиа худаг ордыг 400 мянган тоннын нөөцтэй хэмээн үзэж байсан бол АНУ-ын Геологийн судалгааны газар энэ үзүүлэлтийг 5.9 сая тонн байх магадлалтай хэмээн онцолсон юм. 2005 оноос “Монгол газар” компани энэ орд газарт нарийвчилсан хайгуул хийж буй аж.

Шинжлэх ухааны үүднээс манай Химийн хүрээлэн, Геологийн төв лабораторид газрын ховор элементийг судалж үзээд, энэ төрлийн

ашигт малтмалыг задлах боломжтой, эхний ээлжинд цэвэр металл биш юм аа гэхэд хүчилтөрөгчтэй исэл маягаар ялгаж болох юм байна гэсэн дүгнэлт ч хийсэн аж.

“Өндөр технологийн аминдэм” гэх эдгээр 17 металл зөвхөн манай орны хэвлийд их хэмжээгээр агуулагдаж байна гэвэл өрөөсгөл ойлголт болно. “Technology Metals Research” компанийн судалгаанаас үзэхэд дэлхий даяар Хятадаас өөр 24 оронд газрын ховор металлын 251 орчим төсөл хэрэгжихэд бэлэн байгаа аж. Газрын ховор элемент нь ийнхүү дэлхий даяар тархсан атлаа эдийн засгийн эргэлтэд орсон нь тун цөөхөн гэнэ. Учир нь эдгээр элементийг эрж хайх, олборлоход нарийн, үнэтэй технологи ашигладаг учир зардал их шаарддаг байна. Тиймдээ ч Монголд тодорхой хэмжээгээр судалгаа хийсэн боловч дорвитой ажил бололгүй өдий хүрчээ. Японы “Sumitomo” корпорацийнхан ч өмнө нь сонирхож байсан боловч хаяад буцсан гэх. Хятадууд мөн судалгаа хийх зорилготой манайд ирж, дээж аваад явсан тухай мэргэжилтнүүд ярьдаг. Түүнчлэн Монголд газрын ховор элементийн хайгуул, ашиглалт, борлуулалт зэрэгтэй холбоотой эрх зүйн орчин бүрдээгүй учраас эдийн засгийн эргэлтэд ороогүй өнөөг хүрсэн гэж мэргэжилтнүүд тайлбарлаж байна.

“CPS International” компанийн захирал Б.Мөнхдөл энэ онд литийн



хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг монгол компани Австралийн хөрөнгийн биржид IPO хийх гэж байгааг дуулгахад баярласнаа нуух юун. Монголын компани маш таатай үеийг алдалгүй Австралийн хөрөнгийн зах зээлээс мөнгө босгоно гэдэг яах аргагүй сайн мэдээ.

Сүүлийн 20 жилийн турш 5-15 ам.долларын хооронд хэлбэлзсэн нэг кг газрын ховор металлын үнэ эдүгээ 60 ам.доллараас давлаа. Гэхдээ дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ өсдөг шигээ буурдаг гэдгийг бид сайн мэднэ. Япон, германчууд манайхыг ихэд сонирхож буй энэ үеэр тэдний “ноу хау”-г ашиглан газрын ховор элемент Монгол орны хаана, ямаршуу хэмжээтэй байгааг сайтар судлаад авах хэрэгтэйг мэргэжилтнүүд зөвлөж байна. Мөн дэлхий даяар энэ төрлийн ашигт малтмалын эрэлт хэрэгцээ нэмэгдэж, нийлүүлэлт хумигдаж, үнэ өсөж буй завшааныг алдалгүй газрын ховор металлуудаа эдийн засгийн эргэлтэд оруулах нь асар чухал гэдгийг ч тэмдэглэж байна. ■

News

Монголчууд газрын ховор элементээ АНУ, Япон, БНСУ-д нийлүүлнэ

Монгол Улсын газрын ховор элемент экспортлогчид АНУ-ын Калифорни мужийн “Green Technology Solutions” компанигай гэрээ хийж, хамтарсан компани байгуулах болсныг “Синьхуа” агентлаг хоёрдугаар сарын 10-нд мэдээлэв. Байгаль орчинд сөрөг нөлөө багатай цэвэр технологи нэвтрүүлэхийн зэрэгцээ АНУ, Япон, БНСУ зэрэг газрын ховор металлын эрэлтээрээ тэргүүлэх орныг нийлүүлэлтийн хомсолд оруулахгүй байх тухай дээрх гэрээнд тусгажээ. “Газрын ховор элементийн нийлүүлэлт тогтвортой байх нь эдгээр орны эдийн засагт амин чухал” хэмээн “Green Technology Solutions” компанийн

захирал Жон Шеарер онцолсон байна.

Монголын газрын ховор элементийг төмөр замаар ОХУ-ын Владивосток далайн боомтод хүргэж, тэндээсээ АНУ, Япон, БНСУ-ын зах зээлд нэвтрүүлэх тухай гэрээнд заасан аж. АНУ-ын Геологийн судалгааны газрын 2009 оны таамаглалаас үзэхэд Монгол Улс 31 сая тонн газрын ховор металлын нөөцтэй байх магадлалтай. Энэ нь дэлхийн нийт нөөцийн 16.77 хувийг бүрдүүлж байгаагийн зэрэгцээ Монголыг Хятадын дараа буюу дэлхийд хоёрдугаарт эрэмбэлэгдэх газрын ховор металлын эзэмшигч болгож байна гэж “Синьхуа” агентлаг онцолжээ. ■


Төмөр замын шинэ бодлого

Дэлхийн төмөр замын хөгжил хурд руу явж байна. Байгаль орчинд ээлтэй ногоон төмөр зам болохын төлөө үйл ажиллагаа, бодлогоо чиглүүлж байна. Бензин шатахуунаар ажилладаг машин тэрэгний утаа униар, түгжрэл нь нийгэмд сөрөг нөлөө үзүүлж, байгаль орчныг бохирдуулах гол үндэс болж байгаа учраас бусад улс орон төмөр замын сүлжээг хот хооронд бус хот дотроо, өөрөөр хэлбэл хот, дүүргийн хооронд байгуулж эхэллээ. Нэг замтай, бага оврын дээгүүр, доогуур, дүүжин төрлийн төмөр замыг барьж байна. Мөн дэлхийн төмөр замын бодлого үр ашигтай ажиллах талд анхаарч, үүний тулд төмөр замыг цахилгаанжуулах, даацын хэмжээг нэмэгдүүлэх чиглэлд ажиллаад хэдийнэ эхэлжээ.

Манай төмөр замын салбарын шинэ бодлого юу байна вэ?

Төмөр замын суурь бүтэц, байгууламжийг төр өөрийн мэдэлдээ үлдээж, зам дээгүүр явах вагон, ачаа тээш, тээврийн үйл ажиллагааг хувийн хэвшлийнхнээр гүйцэтгүүлэх зарчмыг баримтлах бодлого тодорхой болсон. Монголын төмөр замын салбарын ойрын ирээдүйг Төмөр замын газрын дэд дарга Л.Пүрэвбаатар нэгдүгээрт, уул уурхай дагаж, хоёрдугаарт, сүлжээний зарчмаар, гуравдугаарт, төрийн зохицуулалтаар хөгжинө гэж тодорхойлсон юм.

Бусад улс орон төмөр замаа хот суурин газраар дайруулж тавьдаг бол манай орны онцлогоос шалтгаалан хаана уул уурхай, орд газар байна тэнд зам тавих бодлоготой. Уул уурхайн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нь хүргэхийн тулд эзгүй хээр, элсэн цөл, хүнгүй газраар ч явуулна гэсэн үг. Тиймээс энэ салбарынхан газар доорх баялгаараа гадна, дотныхны сонирхлыг татаад байгаа Өмнийн говь руу хараагаа чиглүүлж, шинэ төмөр замын трассаа Тавантолгой-



Сайншанд-Чойбалсан" чиглэлд барихаар баталлаа. Ер нь төрөөс нийтдээ 5800 км урт төмөр зам барих бөгөөд эхний ээлжинд 1100 км-ыг нь ойрын 2-3 жилд барьж ашиглалтад өгөхөөр төлөвлөжээ. Тус замын царигийн өргөнийг 1520 мм гэсэн Оросын төмөр замын царигтай адил хэмжээгээр барих ч төмөр зам өндөр хөгжсөн улс орны хөгжил дэвшил, туршлагыг нэвтрүүлж, монгол ажилтнууд гүйцэтгэлийг хийх юм. Концессын хуульд зааснаар шинээр баригдах төмөр замыг "Монголын төмөр зам компани"-д гүйцэтгэх эрхийг өгсөн бөгөөд шаардлагатай санхүүжилтыг Монголын Хөгжлийн банкаар дамжуулан олгохоор шийдсэн ч энэ банкны үйл ажиллагаа одоохондоо эхлээгүй байгаа юм. Нэг км төмөр зам 2,5 сая ам.доллараар босдог гэвэл 1100 км-ыг барихад 2-3 тэрбум ам.долларын санхүүжилт шаардагдах нь. Шинэ төмөр замыг 2011 оны хоёрдугаар хагасаас барьж эхлэх бөгөөд хөрөнгө оруулалт болон техник технологийн үндэслэлээс хамаарч, хоёр жилд барьж дуусгана гэсэн зорилттой байна. Одоогоор шинэ төмөр замын ажилд оролцох "Монголын төмөр зам" ТӨХК-иас өөр компанийн нэр дуулдаагүй. Гэхдээ Тавантолгойн тендерт ялах компани л төмөр зам барих ажилд оролцох магадлал өндөр байгаа талаар мэргэжилтнүүд ярьж

байна. Харин ялсан компани нь шаардлагатай хөрөнгийг өөрсдөөсөө гаргаж, төмөр зам барих шаардлагыг хангасан байх ёстой аж.

Цөлжилтөд эрчимтэй өртөөд буй говийн бүс нутгаар олон зуун км төмөр зам барьснаар байгаль орчинд хэр нөлөө үзүүлэх талаар Л.Пүрэвбаатар даргаас сонирхоход "Хэвтээ тэнхлэгийн замыг говийн бүсэд барьж, зам дагуу ногоон хэрэм болгох алсын санаа бий" гэв. Төмөр замын давуу тал нь замаа нэг л бариад авбал тогтвортой хөгжлийг бий болгодог учраас зам дагуу мод ургамал тарих, ногоон байгууламж байгуулах боломжтой байдаг. Энэ утгаар бусад улс оронд төмөр замыг байгаль орчинд ээлтэй гэж үздэг юм байна.

Төмөр замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх нь чухал асуудал. Манай хөрш орнуудын төмөр зам нь нэлээд хурдацтай хөгжиж байгаа. Харин их гүрнүүдийн төмөр замын сүлжээгээр хоорондоо холбогдох тэр нөхцөлийг нь манайх бүрдүүлэхгүй байгаа талаар гомдоллодог бололтой. Орос, Хятадын төмөр зам манай улсын урд, хойд хил хүртэл тулаад ирсэн ч Монголын хөгжил дорой байдал ихээхэн тээг болж байгаа тухай хөршүүдээс санал шүүмжлэл багагүй сонсдог. Тиймээс энэ хоёр гүрэн дамжин өнгөрөх тээврийг ихэд сонирхдоггүй гэж мэргэжлийн хүмүүс ярилаа. Гэхдээ сүүлийн үед Орос ах нар Монголын төмөр замын хөгжлийг нэлээд сонирхож хандах болсныг уул уурхайн баялагтай холбож тайлбарлаж болох. Том гүрнүүдийн геополитикийн бодлогоор хойд хөрш 1520 мм-ийн царигаар Монгол Улстай төмөр замын хамтын ажиллагааг хөгжүүлэх бодолтой байдаг бол урд хөрш 1435 мм-ийн царигаар холбогдох сонирхлоор гэрээ хэлэлцээрээ явуулдаг. Хадны дунд хавчуулагдсан хадны мангаа хөөрхий гэдэг шиг манай улс хоёр өөр цариг, хоёр сүлжээтэй байх боломжгүй тул

одоогийн буй сүлжээ буюу нэг сүлжээ нэг цариг гэсэн чиг баримтлахаар болсон билээ.

УБТЗ-ын шинэ бодлого

Монгол-Оросын 50 хувийн хөрөнгө оруулалттай УБТЗ шинэхэн удирдлагатай болсон байгаа. Шинэ дарга нь шинэчлэх төлөвлөгөө боловсруулжээ. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газраас ч УБТЗ-ыг шинэчлэхэд анхаарч ажиллах нь. Социализмын үеийн Монгол-Оросын хэлэлцээрээр явж ирсэн тус байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын одоогийн хууль дүрмэнд нийцүүлэн ажиллуулах, татвар төлдөг болгох, 50-иас дээш хувийн оролцоотой компани аливаа техник хэрэгслийг худалдаж авахдаа тендер зарладаг дүрмийг ч мөрдүүлэхэд хяналт тавьж ажиллах нь. Аюулгүй ажиллагаагаар дарамталж айлгадаг байдлыг зогсоож, хууль дүрмэнд нийцүүлэн төмөр замын үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, дотоодод үйлчилдэг дүрэм журмыг гадна талд дагаж мөрдөхийг шахдаг байдлаас татгалзах зэргээр томоохон шинэчлэл хийхээр судалгаа хийж байгаа аж. Өөрөөр хэлбэл, иргэд төмөр замынхнаас гуйж гувшиж үйлчлүүлэх биш, УБТЗ-ынхан иргэдээс үйлчлүүлэхийг гуйх юм байна. Өнөөдөртөө сонин

сонсогдож магад ч нь ойрын 10 жилд хийж, хэрэгжүүлж, хэвшүүлэх зорилт. Мөн галт тэрэгний тасалбарыг вокзал дээр заавал очиж дугаарлаж, уурлан бухимдаж авахгүйгээр интернэтээр, эсвэл гэрийнхээ ойролцоох төмөр замын тасалбарын цэгүүдээр үйлчлүүлэх хугацаа тун удахгүй ирэх нь.

Түүнчлэн хагас цэргийн байдалтай гэсэн нэрээс татгалзаж, энэ нэрийг зөвхөн сахилга бат талдаа ашиглах. “Дайны” байдлаас үйлчилгээний, хагас цэргийн байдлаас иргэний байгууллага болгох зорилтыг амьдралд буулгахад холбогдох байгууллагуудаас хяналт тавьж ажиллана. Монголын төмөр замынхны хувьд өнгөрсөн 10 жилд зах зээлийн хатуу ширүүнтэй дасах зохицох, “амьд үлдэх” он жилүүд байсан бол ирэх 10 жилд үйлчилгээгээ сайжруулах шинэчлэлийн жилүүд байна гэдэгтээ итгэлтэй байна.

“Төмөр замын тээврийн байгууллагууд байгаль орчны бодлого явуулдаггүй гэсэн шүүмжлэлийг хүлээн авч, дуу шуугианаа багасгах, цэвэр цэмцгэр байх, чанартай материал түүхий эд худалдан авах, био 00 хэрэглэх, замын өртөө, зурвасын өнгө үзэмжийг сайжруулах, ногоон төгөл болгоход анхаарч, мод ургамал тарьж ажиллах цаг болсон” гэж Л.Пүрэвбаатар дарга төмөр

Дэлхийн нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх нийт хэмжээ 19%, үүнээс (хувиар)



ирээдүйн эрчим хүчний чуулга уулзалтаар ирээдүй хойч үедээ эх дэлхийгээ хадгалж үлдээхийн тулд одооноос юу хийх ёстой, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийг хэрхэн багасгах талд ямар арга хэмжээ авч ажиллах тухайд ярилцаж, нийтээрээ хамтран тэмцэх уриалга гаргасан байгаа. Мөн тус уулзалтаас байгаль орчны доройтол болон хоол хүнсний дутагдал үүссэнээс санхүүгийн хямрал нүүрлэсэн. Энэхүү хямралыг даван туулахад сэргээгдэх эрчим хүч чухал үүрэгтэй гэж тэмдэглэсэн нь бий. Олон улсын эрдэмтэн судлаачдын хувьд карбоны татвар буюу нүүрсхүчлийн хийн ялгаралтад ногдуулах татвар хүчин төгөлдөр болсноор сэргээгдэх эрчим хүчний нөөц баялаг ихтэй орнууд стратегийн давуу талтай болно. Нөгөө талаар ногоон эдийн засгийн эрин үе нь хөгжиж байгаа орнуудын хувьд сэргэн мандах том боломж гэж үзэж байгаа юм. Тиймээс улс орнууд ногоон эрчим хүч буюу сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж ажиллаж байна.

Сэргээгдэх эрчим хүч гэдэг нь нар, салхи, бороо, далайн давалгаа, газрын гүний дулаан зэргээс гарган авдаг, байгалиас тасралтгүй сэргээгддэг энергийг хэлэх ба Олон улсын эрчим хүчний агентлаг "Сэргээгдэх эрчим хүч нь байгалийн процессоор үүсэх ба тасралтгүй нөхөгдөнө. Эдгээр нь нарнаас шууд эсвэл дэлхийн гүнээс үүсэж болно. Энэ тодорхойлолтод нар, салхи, далай, ус, биомасс, газрын гүний дулаан, биотүлш, сэргээгдэх эх үүсвэрээс үүдэлтэй устөрөгч зэргээс гарган авсан цахилгаан, болон дулааныг хамааруулан ойлгоно"

Ногоон эрчим хүч

Дэлхий ногоон эрчим хүч рүү



Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, дулаарал нь эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, хүмүүсийн өдөр

тутмын амьдралд нөлөөлж эхэллээ. Цаг агаарын онц аюултай үзэгдлүүд сүүлийн жилүүдэд дэлхий дахинаа төдийгүй манай улсад олон тохиох боллоо. Энэхүү цаг уурын өөрчлөлт дэлхийн улс орны өнцөг булан бүрт ажиглагдаж, эрдэмтдийн таамаглаж байснаас илүү хурдацтай түрэн орж ирж, хүн төрөлхтөний өмнө тулгарсан хамгийн бодит аюул болсныг улс орнууд тэмдэглэхийн зэрэгцээ хамтын хүчээр тэмцэхийг уриалсаар байна.

Арабын Нэгдсэн Эмират улсын Абу Даби хотноо хуралдсан Дэлхийн

хэмээн тодорхойлжээ. 2008 оны мэдээллээр дэлхийн нийт эрчим хүчний 19 хувийг сэргээгдэх эрчим хүчнээс гарган авсан бөгөөд үүний 13 хувийг уламжлалт түлш болох модноос, 3.2 хувийг уснаас, үлдэх 2.7 хувийг шинэ эх үүсвэрүүд болох нар, салхи, био, газрын гүнийн дулааны эрчим хүч зэргийг ашиглан гарган авчээ.

2009 оны байдлаар дэлхий хэмжээнд сэргээгдэх эрчим хүчний нийт суурилагдсан хүчин чадал нь 158 ГВт (GW)-д хүрч, салхины эрчим хүчний ашиглалт жилд дундажаар 30 хувиар нэмэгдэж байгааг судлаачид онцолсон. Салхины эрчим хүчийг Европ, Азийн орнууд болон АНУ-д өргөнөөр ашигладаг байна. Харин дэлхийн нарны эрчим хүчний үйлдвэрлэл мөн оны байдлаар 21 ГВт-аас давж гарч. Ийм эх үүсвэрийг Герман, Испанид түгээмэл ашигладаг бөгөөд хамгийн том нарны дулааны станц АНУ-ын Калифорнийн Можави цөлд бий. Уг станцын суурилагдсан хүчин чадал нь 354 МВт. Тэгвэл дэлхийн хамгийн том газрын гүний дулааны станц 750 МВт хүчин чадалтай АНУ-ын Калифорни дахь Гейзер станц юм. Бразил улсын хувьд чихрийн нишингээс гарган авсан этанолийг хамгийн ихээр хэрэглэж байгаа оронд тооцогддог. Тус орны автобензины 18 хувийг этанол түлш хангадаг байна. АНУ-д уг түлшийг мөн өргөнөөр хэрэглэдэг аж.

Их чадлын сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрүүдээс гадна алслагдсан жижиг суурингуудыг эрчим хүчээр хангахад бага чадлын сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр ашиглах нь маш тохиромжтой юм. Дэлхий дахинд гурван сая айл өрх гэрийн нарны цахилгаан үүсгүүр ашигладаг тооцоо бий. Үүнээс гадны 30 сая айл өрх ахуйн зориулалтаар (гэрэлтүүлэг, хоол хийх) биохий, 160 сая айл өрх биомасс түлдэг зуухыг ашиглаж байна. Мөн жижиг хот болон суурингуудын цахилгааны хэрэглээнд зориулан бага оврын усан цахилгаан станцыг олноор байгуулсаар байгаа.

Цаг уурын өөрчлөлт, газрын тосны үнийн өсөлт зэрэг нь сүүлийн үед сэргээгдэх эрчим хүчний талаар далайцтай судалгаа явуулах, судалгаанд ихээхэн хөрөнгө оруулах,

үйлдвэрлэх, хэрэглэх үндсэн шалтгаан болж байна.

Сэргээгдэх эрчим хүч Монголд

Манай улсын хувьд ногоон эрчим хүчийг хөгжүүлж, ашиглах талаар сүүлийн жилүүдэд эрчимтэй анхаарч эхэлсэн. Төрөөс Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, 100 000 нарны гэр хөтөлбөрийг багалж, хэрэгжүүлж байгаа. Одоогоор ногоон эрчим хүчийг ашиглан гаргаж авсан цахилгааны хэмжээ 37,4 МВт буюу нийт эрчим хүчний суурилсан чадлын 4,52 хувийг эзэлж байна. Энэ нь бусад оронтой харьцуулахад маш бага үзүүлэлт. Гэхдээ Монгол орны цаг уурын өөрчлөлт, дулаарал, ган гачиг, зуд турхан гэсэн байгалийн өөрчлөлтүүд нүдэнд илхэн харагдаж, мэдрэгдэж байгаа учраас байгаль орчинд ээлтэй арга хэмжээг авахаас өөр аргагүйд хүргэж байна. Ялангуяа дулаарлын явц манай улсад харьцангуй хурдацтай явж байгаа гэсэн судлаачдын тооцоо цөлжилтийг сааруулсан, дулаарлыг багасгахад чиглэсэн бодитой арга хэмжээг авч, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай болж байна. Мөн төрөөс ногоон эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулах байгууллага, компанийг бодлогоор дэмжиж, урамшуулдаг механизмыг бүрдүүлэх нь чухал юм.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөрт нийт 81 сумыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, дизель хослуулсан цахилгаан станц байгуулах, үүнээс 40 суманд нар

диель, долоон суманд ус-диель, 25 суманд салхи-нар-дизель хосолсон цахилгаан станц барьж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байна. Ойрын таван жилд Завхан, Говь-Алтай, Говийн аймгийн нутаг дэвсгэр дээр салхин станц барих, тэдгээрийг төвийн эрчим хүчний систем, Даланзадгадын дулааны цахилгаан станцтай холбох боломжийг судлах, Төвийн бүсэд салхин станцын парк барьж, төвийн эрчим хүчний системд холбох ажээ.

Дунд шатны хугацаа буюу 15 жилд Баянхонгор аймагт салхин станц болон Төвийн бүсэд усан цэнэгт цахилгаан станц барих судалгаа хийж, нэгдсэн системд холбох асуудлыг шийдвэрлэх юм байна. Говийн аймгуудад нарны эрчим хүчийг ашиглан том хүчин чадалын станц барих боломжийг судалж, төвлөрсөн цахилгаан хангамжид холбогдох боломжгүй алслагдсан сумдыг дизель-ус дизель-нар гэх мэт эрчим хүчний хосолсон эх үүсвэрээр хангах бодлогыг баримтлах аж.

Одоогоор малчин өрхийг цахилгаанжуулах төслийн хүрээнд 100 гаруй мянган малчин өрх гэртээ телевиз үзэж сууна. Олон жил сайн муугаар яригдсан Тайшир, Дөргөний усан цахилгаан станц ажиллаж эхэлснээр дээрх аймгуудын иргэд байнгын гэрэл цахилгаантай залгалаа. Салхины эрчим хүчээр алслагдсан сумд хангагдаж эхэллээ. Ийнхүү манай улс нар, салхины баялаг нөөцөө ашиглан ногоон эрчим хүчийг хөгжүүлж, байгаль орчинд ээлтэй бодлого явуулснаар даян дэлхийн цаг уурын дулааралтай тэмцэх, цөлжилтийг сааруулах уриалгыг дэмжин ажиллах үйлсэд том





Усны жилд

Ус амьдрал

Д.Бэхээ

Манай улсын хувьд гол мөрөн, булаг шандаа хайрлан хамгаалж, усыг ариг гамтай хэрэглэх нь хамгийн тулгамдсан асуудал болоод байна. Бид усгүйгээр хэчнээн сайхан ирээдүй, эдийн засгийн бодлого, бизнес яриад яах вэ дээ. Дээрх сөрөг хувьсал нь хүн төрөлхтөнийг эдийн засаг-байгаль орчин, нөгөө талдаа байгаль орчин-эдийн засаг хэмээн ярихад хүргэж байна.

Тиймээс “Mongolian Economy” сэтгүүл нь монголчуудын хувь заяаг тодорхойлох байгаль орчин тэр дундаа усны асуудлыг байнга хөндөн, тогтмол булан явуулж, ирээдүй хойч үедээ эх нутгаа энгүй сайхнаар нь өвлүүлэн үлдээх буянт үйлсэд хувь нэмрээ оруулж ажиллах болно.

Ус бол амьдрал юм. Усгүйгээр бид хэчнээн удаан амьд явах вэ. Манай цэнхэр дэлхийн ихэнх хувийг ус эзэлдэг ч цэвэр ундны усны хомсдолын тухай өнөөдөр улс орнууд онцгойлон авч үзэж ярьсаар байна. Энэ нь цэвэр усны нөөц дэлхийд маш бага хувь эзэлдэгтэй холбоотой.

Дэлхийн цаг уурын өөрчлөлттэй холбогдон цэвэр усны нөөц улам л багасаж байгаа нь олон улс орнуудын санааг зовоосор. Тиймээс хөгжилтэй орнуудын төр, засгийн тэргүүнүүд энэ чиглэлээр нэгэн дэвэр, уриан дор хуралдаж, энэхүү тулгамдсан асуудлаар санал бодлоо солилцож, цаашид авах арга замаа тодорхойлж байна. Тухайлбал, "Ус-тогтвортой хөгжлийн түлхүүр" нэртэй уриан дор олон улсын бага хурлыг ХБНГУ-ын Бонн хотноо хийснээс хойш олон арга хэмжээ бусад оронд болж, усны нөөцөө хэрхэн хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй хэрхэн нэгдэн тэмцэх талаар чуулсаар ирсэн билээ. Манай улсын хувьд ч ялгаагүй ийм хүндрэл бэрхшээлтэй тулгарч байгаа. Ялангуяа Төв Азийн өндөрлөг хэсэгт орших эрс тэрс уур амьсгалтай, хур тунадас бага

ордог, ууршилт ихтэй, усны нөөцөөр хязгаарлагдмал манай оронд цаг уурын өөрчлөлт эрчимтэй явагдаж, олон гол, булаг шанд ширгээд буй статистик мэдээлэл бий. Дээр нь хүний хүчин зүйлийн нөлөөллөөр байгаль орчиндоо сүүлийн жилүүдэд ихэд хайр гамгүй хандаж байгааг бид бүхэн мэднэ.

Ер нь ус бол байгалийн үнэт баялгийн хувьд энэхүү баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах нь улс орны оршин тогтнох, хөгжихийн эх үндэс болдог. Монголчууд бидэнд бурхнаас олон төрлийн газрын баялгийг илгээжээ. Харин энэхүү баялгаа хүртэхийн төлөө хэтэрхий эмх замбараагүй хандсанаас эдүгээ ихэнхдээ сөрөг үр дүнг нь үзсээр сууна. Тухайлбал, олон аймгийн газар нутаг бараг л дайнд нэрвэгдсэн мэт сүйтгэгдэж, улмаар уул уурхайн энэхүү зүй бус үйл ажиллагаанаас үүдэн олон гол горхи, булаг шанд бохирдож, ширгэж байна. 2003 оны байдлаар найман аймгийн 28 гол, горхи алт олборлолтын нөлөөгөөр бохирдсон гэсэн тоо баримт бий.

Сэлэнгийн ай савд манай орны томоохон хотууд байрладаг бөгөөд энэ сав газарт үйлдвэрлэл үйлчилгээ их хөгжсөн нь голын усны чанарт тодорхой хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлсээр. Бидний сайн мэдэх Орхон, Туул, Хараа, Ерөө голууд алтны үйлдвэрлэлийн нөлөөнд ямар нэг хэмжээгээр өртөж, булингартан бохирдсоныг мэргэжлийн хүмүүс толгой сэгсрэн ярих. Зарим гол горхи, цэвэр цэнгэг усанд амьдрагч загас жараахай амьдрах чадваргүй болж, өвчин үүсгэгч шимэгч хорхойгоор өвчилсөнийг хүртэл холбогдох байгууллагынхан илрүүлсэн.

Миний багадаа эрхлэн нааданхан өссөн Завхан гол ч зарим хэсгээрээ тасарч, элсэн манхан үүссэн тухай сонсох бүртгээ зүрх шимшрэх. Завхан нутгийн байгалийн чимэг болсон энэ томоохон голыг ширгэж тасрах аюул нөмрөнө чинээн бодож явсангүй. Яагаад гэвэл дуунд мөнхөрсөн Завхан гол тасрах нь байтугай, эргээсээ халин үерлэдэг байсан болохоор тэр. Харин өнгөрсөн зун бурхан ивээж, Завхан гол олон жилийн өмнөх шигээ цэнхэртэн урссаар эргээ халин ирснийг дуулаад ямар их баярласан гээч.

Өөр нэг жишээ бол нийслэлчүүд бидний нүдэн дээр байна. Эртний эгэлгүй их түүхтэй, нийслэл хотын өнгө үзэмж болсон Туул гол өдрөөс өдөрт "нүдээ анисаар" буйг бид харсаар. Улаанбаатарчуудэнэлголоос ундаалж, угжиж өссөн шүү дээ. Бас л эргээсээ халин цэнхэртэн урсдаг байгалийн их баялаг өнөөдөр ямар байдалтай байна вэ. Хог новшоор дүүрч, гудамжны гэгддэг хүмүүсийн үүр оромж л болж дууслаа. Мөн төв хэсгээр нь эргийг нь тулгаад хашаа хатгасан харагдах. Амь зогоох мэт урсах зарим хэсэг нь бохирдож, загас жараахайнууд нь цэвэр цэнгэг ус хайн эргээ сэлэн амаа ангайн үхэх. Баримт дурдъя. Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжаас гарсан бохир усанд аммоны ионы агууламж ихэнх тохиолдолд голд нийлүүлж болох зөвшөөрөх дээд хэмжээнээс 1.5-2.0 дахин их, ууссан хүчилтөрөгчийн хэмжээ маш бага буюу 0,35-0,80 мг/л хооронд байгаа нь Туул гол гадаргын усны цэврийн зэргийн ангиллын нормтой харьцуулахад "маш их бохирдолттой" гэсэн ангилалд орж байна. Харамсмаар тоон үзүүлэлт биш гэж үү.

Мөн түүнчлэн Улаанбаатар хот болон томоохон төв суурин газрын ойролцоох булгуудад хамгаалалтын бүсийн дэглэм мөрдөөгүйгээс хог хаягдлаар бохирдсон гэсэн мэргэжилтнүүдийн дүгнэлт байна. Дэлхийн банкнаас Туул голын эхийн өнөөгийн явцад судалгаа хийж, өнөөдрийн байдал цааш үргэлжилбэл ирэх 10 жилд улаанбаатарчуудын ундны усны хэрэглээ хүнд байдалд орох тухай сэтгэл эмзэглүүлсэн дэлгэрэнгүй тайлан гаргасан.

Монгол орны гадаргын усны


нөөцийн 70 хувь Алтай, Хангай, Хэнтий нуруу, Хөвсгөлийн уулс, Их Хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсэг буюу Монгол орны нутаг дэвсгэрийн 30 хувьд бүрэлддэг аж. Нэгж талбайд ногдох усны нөөцөөр Монгол Улс бусад оронтой харьцуулахад нэн бага, ам. метр талбайд ойролцоогоор 22 орчим мянган шоо метр ус ногддог, гэхдээ хүн ам цөөн, сийрэг оршдогтой холбоотойгоор нэг хүнд ногдох усны нөөцөөр харьцангуй дээгүүрт ордог. Мөн гэр хороолол болон хөдөө орон нутагт амьдарч буй нэг хүнд ногдох төдийгүй хөдөө аж ахуй, аж үйлдвэрт хэрэглэж буй усны хэмжээгээр манай улс дэлхийн дунджаас нэлээд доогуурт ордог. 2004 оны байдлаар Монгол орны нийт хүн амын 30,8 хувь нь төвлөрсөн ус түгээгүүрийн сүлжээнээс, үлдсэн 69.2 хувь нь төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс буюу зөөврийн ус тээврийн үйлчилгээнээс, 24.8 хувь нь ус түгээх байр, 35.7 хувь нь худгаас, 9.1 хувь нь булаг шанд, гол горхины уснаас ус авч унд ахуйдаа хэрэглэдэг гэсэн тоон мэдээ бий.

Усны хэрэглээний талаар явуулсан зарим судалгааны дүнгээс үзэхэд хот суурин газарт орон сууцанд оршин суугчдын хоногийн дундаж усны хэрэглээ 230-350 литр бол гэр хороололд оршин суугчид болон малчдынх дунджаар 5-10 литр бөгөөд хамгийн их ус хэрэглэдэг хотуудаар Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан орж байна. Эндээс харвал, орон сууцанд амьдардаг иргэд усанд хэр үрэлгэн хайр гамгүй ханддаг судалгааг үзэж болохоор. Ямар сайндаа мэргэжилтнүүдийн зүгээс шүдээ угаахдаа тусгай жижигхэн сав

бэлтгээд түүндээ усаа хийж угаах зөвлөмж өгч байхав.

Ер нь төр, засгийн бодлого шийдвэрээс гадна иргэд бид өөрсдөө байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах чин сэтгэлтэй баймаар байна. Эцэг өвгөдийн үеэс уламжлан ирсэн байгальтайгаа зүй зохистой харилцах харилцаагаа эргэн сэргээмээр байна. Уул уурхайн үйлдвэрлэл явуулсан ч хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бодолцон, байгалийг эргэн унаган төрхөнд нь оруулж сэргээх олон улсын туршлагаас нэвтрүүлж, түүнийг даган мөрдөж ажиллая. Эрс гэрэ уур амьсгалтай, Төв Азийн өндөрлөг буюу хуурайшилттай бүсэд оршдог монголчууд цөөхөн гол мөрөн, булаг шандаа ширгээчихээд ямар орчинд хэрхэн амьдрах талаар та нэг төсөөлөөд үзээрэй. Цэвэр тунгалаг Туул голын хамгийн чухал хэсэг эхийг нь бохирдуулан сүйтгэж хаяснаар хаанаас, ямар эх үүсвэрээс ундны усны хэрэглээгээ хангах тухайд нийслэлчүүд нэг бодолцож үзээсэй. Энд иргэдийн байгаль эхээ хайрлан хамгаалах чин сэтгэлээс гадна төрийн төмөр нударга зайлшгүй хэрэгтэй гэдэг нь бас ойлгомжтой юм.

Усны хэрэглээ





Д.Энхбатын БУЛАН

Асуудал

Усгүй хөгжил ?

Ду future in booming China гэсэн нэгэн мэдээг интернэтээс уншлаа. Иймэрхүү мэдээ дэлхийн мэдээллийн сувгуудаар байнга л гарч байдаг болсныг хэн хүнгүй мэддэг болсон цаг. Харин дэлхийн олон улс орон энэ талаар үндэсний бодлогоо гаргаж, их хуурайшил, цөлжилт, цэвэр усны хомсдолыг зогсоож чаддаггүй юм аа гэхэд ирж байгаа их өөрчлөлтийн шинэ нөхцөл байдалд иргэдийнхээ амьдрал, хөдөө аж ахуй, хотуудаа хэрхэн дасан зохицуулах вэ гэдэг дээр маш шургуу ажиллаж эхэлснийг бид анзаарч амжаагүй л явна.

ХХААЯ, УИХ- дахь Байгаль орчны Байнгын хороо "Монгол мал" хөтөлбөрийн явцыг авч хэлэлцэх үеэр би холбогдох яамныхнаас Монгол орон цөлжилтийн шинэ нөхцөлд мал аж ахуйгаа хэрхэн хамгаалан авч үлдэх стратеги бодлогын талаар асууж лавлахад тэдэнд энэ шинэ нөхцөл байдлын өнцгөөс бодитойгоор бодож төлөвлөж буй ямар нэгэн бодлого байхгүй нь харагдаж байлаа. Бид байгаль дэлхийн өөрчлөлтөөс төдийгүй өнөө цагийн дэлхий нийтийн хэмнэлээс ч их хоцорсоор байна.

АНУ-ын Сансар судлалын NASA агентлагаас дэлхийн цөлжилтийн ойрын 20 жилийн явцын талаар прогноз хийж тайлан гаргажээ. Тэр судалгаанаас үзэхэд 2030-аад он гэхэд Монгол нутгийн 90 хувь цөлжиж, зөвхөн Хөвсгөл нуурыг тойрсон хэсэгхэн нутаг, Сэлэнгэ мөрний дагуу, хил орчмын багахан газар л өнөөгийн байдлаа хадгалж үлдэх бололтой. Тэгэхээр Монгол орон бүхэлдээ цөлийн бүсэд орох нь ээ гэсэн үг. Харин энд нэг санааг нэмж хэлэхэд, нэг сая хүн амтай том хотын усны дутагдал нь зөвхөн байгаль орчны асуудал биш юм. Бид удахгүй усаа зөөж уудаг ч болох магадлал бий. Тэр цагт Улаанбаатар хотод амьдрах үнэ өртөг хэр өндөр болох бол, ямар нэгэн бизнес эрхлэх боломж үлдэх үү ... гэх мэт асуултууд урган гарч ирж, улмаар байгаль орчны энэ бүх проблем аажмаар эдийн засаг, нийгмийн том асуудал болон хувирах болно. Асуудал бүр цаашлан даамжирвал хэн нь ус ууж, хэн нь уухгүй вэ гэсэн улс төрийн зөрчилдөөн ч болон хувирах аюултай гэдгийг бусад улс оронд болж буй үйл явдлууд, хямралын жишээнээс харж болно. Удахгүй бид үргэлж сонсож, байнга ярьж байдаг ч огт ойлгож ухамсарлаагүй л яваа "ус үнэтэй юу, алт үнэтэй юу" гэдэг гүн утгатай асуултынхаа хариуг байгаль эхээсээ мэдэж авах түүхэн боломжтой тулгарах төлөвтэй. Харин биднийг ухаан орох тэр цагт асуудал битгий л их оройтчихсон байгаасай. ■



дулаарал Гималайн мөсөн голыг хайлуулж буйгай адил Монголын мөнх цэвдгийг ч идэж эхэлжээ. Африкийн тал хээрийн бүс төдийгүй сэрүүн бүсэд ч цөлжилт явагдаж байна. Энэхүү судалгаанд Япон улсын Байгаль орчны хүрээлэн, Кэй-Огийн их сургууль, Байгаль орчны яам оролцжээ. Мөнх цэвдэг гэдэг нь зундаа газрын хэвлий хасах хэмтэй орчинд байж, газар дорх ус цэвдэг хэлбэрээр хадгалагдахыг хэлнэ. Монголын газар нутгийн гуравны хоёр нь ийм цэвдэгтэй байдаг. Улаанбаатар хот орчмын гурван газарт судалгаа хийж үзэхэд мөнх цэвдгийн зузаан нь 2-4 метр байна. Гэтэл найман жилийн өмнө 4-6 метр байсан бөгөөд 1-2 метрээр багасчээ. Хотын орчимд дундаж температур өнгөрсөн 60 жилийн хугацаанд ойролцоогоор 2.3С хэмээр, ялангуяа өвлийн улирлын температур 3.4С хэмээр дулаарчээ. Энэхүү дулаарлаас үүдэн мөнх цэвдэг багассан гэж үзэж байгаа юм байна.

Монголд мөнх цэвдэг нь тал хээрийг усаар хангах чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөнх цэвдэг уствал хөрс эвдрэн цөлждөг. Японы Байгаль орчны яамны зүгээс Монголын Засгийн газартай хамтран ажиллаж, мөнх цэвдэгтэй газрын хайлж буй учир шалтгааныг тодруулах болон хөрсийг эвдрэлээс хамгаалах арга хэмжээ авахаар төлөвлөж байна хэмээн Японы Никкэй сонинд өгүүлжээ. ■

Тандалт

Улаанбаатар хотын орчим цөлжинө

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот орчмын мөнх цэвдэг 20 жилийн дараа устаж тэр хавийн нутаг бүрэн цөлжинө хэмээн Япон улсын Байгаль орчны хүрээлэнгийн (Цукуба хот) судалгаанд дурджээ. Өнгөрсөн найман жилийн хугацаанд мөнх цэвдгийн дээд тал нь хоёр метр доошилсон байна. Дэлхийн

“Тамирчин” малын мах үнэд орох цагаар

И.Отгонжаргал

Монголчууд 50.0 сая малын маань мах хаачихаа гэж гайхаж сууна. Туулай жилийг угтсан шинэ жилийн баярын ширээ өмнө нь байгаагүй өндөр төсөв шаардсан. Учир нь зул сарын баярын бууз хийхэд нэг килограмм хонины махыг 3800, үхрийн махыг 4200 төгрөгөөр худалдаж авав. Дараахан нь Цагаан сарын үеэр нэг ууцны үнэ гэхэд л 120.000-200.000 төгрөгийн хооронд хэлбэлзсэн нь мөн л өмнө нь байгаагүй өндөр ханш байлаа. Бараг 50.0 сая толгой малтай хэрнээ Улаанбаатарт хаврын махны үнийн хөөрөгдөл дүн өвөл айлчилсан нь анхных учраас хачирхалтай. Энэхүү махны үнийн гэнэтийн өсөлт монголчуудыг бид бараг 50.0 сая толгой малтай байж яагаад тэнгэрт гарсан үнэтэй мах идээд суух болов гэж гайхахад хүргэсэн хэрэг. Монголын мал сүргийн тоо толгой сүүлийн жилүүдэд он дараалан өсч 2009 оны эцэст 44 саяд хүрсэн. Тиймээс монголчуудад малын тоо өсөхийн хэрээр дотоодод махны нийлүүлэлт сайжирч, бүтээгдэхүүний үнэ харьцангуй тогтвортой байна байх гэсэн бодол төрнө үү гэхээс махны нийлүүлэлт, малын тоо толгойн өсөлт хоорондоо урвуу хамааралтай байна гэж хэн ч төсөөлөөгүй биз. Үнэ буурахгүй, нийлүүлэлт сайнгүй байгаа учраас жил бүрийн гуравдугаар сарын дундуур зах зээлд нийлүүлдэг Нийслэлийн нөөцийн махыг энэ удаа бүтэн хоёр сарын өмнө буюу өнгөрсөн нэгдүгээр сард гаргалаа. Хаврын тарчиг цаг ирэхээр нөөцийн мах байх л байгаа даа.

Дотоодын махны үнийн асуудал Ерөнхий сайдын санааг ч зовоох болжээ. Тиймээс тэрбээр арванхоёрдугаар сард Монголын мах үйлдвэрлэгчдийн холбоо, хил гаалийнхантай уулзаж махны зах зээлийн нийлүүлэлт, экспортын талаар мэдээлэл сонссон. Ямааны мах Эрээний лангууг дүүргэсэн байна гэж яриад байгаа нь үнэн үү? Манай махны экспортын байдал ямар байгаа юм бэ гэсэн Ерөнхий сайдын асуултад Гаалийн ерөнхий газрын дарга Д.Цэвээнжав ”Энэ онд Монгол Улс 26.0 мянган тонн мах экспортолсон. Үүний 16.0 мянган тонн нь ОХУ болон Иран, Казахстан зэрэгт гарсан. 10.0 мянган



тонн БНХАУ руу гарсан. Үүний 1000 тонн нь Хятадад албан ёсны хаягтай гарсан. Харин 9000 тонн нь Вьетнам улсад хүрэх хаягтайгаар хилээр гарсан” гэж мэдээллэв. Энэхүү мэдээллийг сонсоноор Монгол олон сая толгой малтай ч дотоодын зах зээлд яагаад махны үнийн өсөлт явагдаад байгаа шалтгаан тодорхой болов. Эндээс үзэхэд монгол малын мах урд хөрш рүү их хэмжээгээр гарсан нь экспортын хэмжээг нэмэгдүүлсэн сайн талтай ч 10000 тонн махны нэгхэн мянган тонн нь БНХАУ-д албан ёсны бүртгэлтэй гарч, үлдсэн 9000 тонн нь Вьетнам хүрэх хаягтай гарсан нь таагүй.


НЗДТГ-аас махны үнэ буурахгүй байгаа шалтгаан нөхцөлийг судалж, шалгахыг Нийслэлийн прокурорын газар, Нийслэлийн цагдаагийн газар, НМХГ-г өгсөний дагуу холбогдох шалгалт хийжээ. Шалгалтынхны олж тогтоосноор Замын -Үүд боомтоор 30 гаруй вагон мах хилээр гаргахаар зэхээд байгаа ч урд хөршид хүлээн авах хаяггүй, харин Вьетнам улс руу хүргэх адууны мах нэрээр гаалийн бүрдүүлэлт хийсэн талаар ярьсан байна. Ингэхдээ манайхаас хуурамч бүрдүүлэлт хийлгэж, уг ачааг Эрээнд хүлээж авдаг нэг бус хятад хүн байдаг тухай мэдээлэл манай өдөр тутмын зарим сонинд гарсан. Урд хөршийн улсдаа адууны мах бэлтгэх зөвшөөрөлтэй хүмүүс монгол ямааны махыг адууны мах болгон “хувиргадаг” талаар холбогдох албаны хүн ч ярьжээ. Ямааны махыг адууны мах болгон өөрчлөөд Монголоос урд зүгийг зорьсон махны нэг вагон тутмаас монгол төгрөгөөр 60-70 сая төгрөг халаасалдаг байна. Тиймээс 2010 оны өвөл буюу идэш уушны цагаар үнэ нь навс унадаг махны үнэ буурахгүй, харин ч өсөөд байсан нь үүнтэй холбоотой аж.

Монгол малаар баян. Бид мал, махаа экспортод гаргах эрмэлзэлтэй. Урд хөрш мах авах сонирхолтой. Нэг цэг дээр огтлолцож буй энэ эрх ашиг ажил болж хэрэгжих бүрэн боломжтой нь дээрх баримт мэдээллээс бэлээнээ


Махны экспортын хэмжээ (мян/тн)



Мал сүргийн тоо толгой (сая/толгой)



Ямаан сүргийн тоо толгой (сая/толгой)



харагдаж буй. Хятад Монгол хоёр улс махны экспортын талаар А ч үгүй улс биш. Мал, мах өгөлцөж авалцахад нэн тэргүүнд шаардлагатай байдаг Мал эмнэлэг, хорио цээрийн хэлэлцээр хийгдсэн удаатай. Гэхдээ энэ нь зөвхөн адууны махны тухайд юм. Харин өдгөө дээрх хэлэлцээрээ улам өргөжүүлж бог малын махыг хамруулах шаардлага байна. Хятад руу ямааны мах хууль бусаар их хэмжээгээр гарч буйг албаны хүнээс сонирхоход, “Хятадын тал нуувар хаавраар мах авах биш, экспортын хууль дүрэм журмаа тодорхой болгож хуулийн дагуу импорт хийхийг манай улс хүсч байгаа. Харилцан бие биенээ хүндэтгэсэн худалдаа явуулах ёстой” хэмээн хэлж байна. Одоо бол ямар ч дүрэм журамгүй тоглоом явагдаж байгаа гэсэн үг. Хятадын тал мах авах сонирхолтой, манайд мах нийлүүлэх сонирхол бас бий. Хоёр талын хүсэл сонирхлыг албан ёсны болгох нь хаа хаанаа хэрэгтэй болов уу. Урд хөршийг чиглэсэн богийн махны экспорт албан ёсны болсноор хоёр тал асуудалд улам хариуцлагатай хандана.

Өнөөдөр хятадуудын манайхаас хууль бусаар гаргаж байгаа махнаас ямар нэгэн өвчин илэрлээ гэхэд хэн хариуцлага хүлээх билээ. Хувь хүн хооронд үгсэн хуйвалдсан дээрх хууль бус бизнест буух эзэн буцах хаяг гэж байгаа бил үү. Уул нь бол дээрх үйл ажиллагааг албан ёсны болгох аваас махны экспортын журмын дагуу Хятадын талд манайх зөвхөн экспортын зориулалттай атестатчлагдсан үйлдвэрүүдээс мах нийлүүлэх эрхтэй болно. Түүнчлэн урд хөршийн зүгээс ч манай мах бэлтгэлийн үйлдвэрт мэргэжилтнээ явуулж байнгын хяналт тавьж ажиллах ёстой.

17.0 мянган тонноос 26.0 мянган тонн болтлоо огцом өссөн манай махны экспортын шинэ хандлага зөвхөн Хятадын сонирхлоор зогсохгүй. Энэ талаар Монголын мах үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал М.Лачинбал “Монгол малын мах эрэлт ихтэй болох нь ээ. Богийн махны зах зээл Ази талдаа хүчтэй нээгдэх нь.

Манай Ерөнхий сайд саяхан Булангийн орнуудад айлчлах үеэр Монгол Улс, Кувейтийн Засгийн газар хооронд “Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээр хийсэн. Кувейттэй адил Эмират ч мах сонирхож байна. Иран улс манайхаас хонины мах авч эхэлсэн. Өнгөрсөн жилийн экспортод гарсан 26.0 мянган тонн махны 1600 тонн нь тус улс руу гарсан. Японд адууны махны экспортын зөвшөөрөл байгаа. Вьетнамын тал бас манайд мах авах хүсэлтээ илэрхийлээд байгаа юм билээ. Хятад улсын хувьд манайхаас зөвхөн адууны мах авах зөвшөөрөл бий” гэлээ.

Монгол Улс мах экспортлох тухай 20 жил ярьсан. Энэ хооронд мал өсч хорогдож, малчин баяжиж, ядуурч ч үзсэн. Өнгөрсөн хугацаанд манайх махаа ОХУ-д экспортолдог нэртэй боловч энүүхэн Улаан-Үүд, Эрхүү хавиар борлогдсоор ирсэн. Уралын нурууг давж чадахгүй олон оныг үдсэн. Экологийн цэвэр бүтээгдэхүүн гэгддэг монгол малын махаа хойд хөршид экспортлохдоо зөвхөн үйлдвэрлэлийн түүхий эдийн зориулалтаар өгч байсан гээд бод доо.

Өдгөө монгол малын махны экспортод шинэ зах зээл нээгдэж байна. Түүнчлэн монгол малын амттай махыг эрт дээр үеэс амталж ирсэн оросуудад нэг бус өрсөлдөгч гарч ирлээ. Өөрөөр хэлбэл, Монголд махны экспортын уламжлалт харилцаатай Оросоос өөр оронтой наймаа хийх гарц нээгдэж буй. Ингэхдээ манайх махаа хойд хөршид өгдөг шигээ үйлдвэрлэлийн зориулалтаар гэж үнэ хямдтай нийлүүлэх биш, хэрэглээний зориулалтаар гаргаж эхлэв. Нөгөө талаас монголчуудад их үүрэг хариуцлага ногдож байна. Мах хэрэглээний зориулалттай гарна гэдэг нь эрүүл ахуй, ариун цэврийн хувьд тухайн хэрэглэгчээс тодорхой үнэлгээ авах ёстой. Хэрэглэгчийн тухайн бүтээгдэхүүнд өгдөг үнэлгээ нь өнгө, амт, үнэр, шүүслэг байдлаас эхэлнэ. Мах шингээлт ихтэй, гадаргуу нь нойтон байдаг учраас хог шороо өөртөө шингээж, нааж авах нь их.

Тиймээс эрүүл ахуй ариун цэврийн асуудал нэн чухлаар тавигддаг. Тийм болохоор бид махаа өнгөрсөн хугацаанд Уралын нурууг давуулж, Оросын өргөн уудам нутагт хүргэж чадаагүй шигээ гараа хумихаад суух биш, Монголоос мах авах сонирхолтой олон олон орны эрүүл, ахуй ариун цэврийн өндөр босгыг ажрахгүй давах хэрэгтэй. Ингэхийн тулд дотооддоо малчнаасаа эхлээд махны үйлдвэр, холбогдох төрийн яам тамга, хууль хяналтын байгууллагынхан хүртлээ хаа хаанаа анхаарч ажиллах цаг ирсэнийг хэлэхэд илүүдэх юун. Мэргэжилтнүүдийн ярьж буйгаар хэрэглээний чанарыг хангахын тулд анхан шатны боловсруулалтын технолги маш зөв байх ёстой аж. Гэтэл өнөөдөр манайд махны анхан шатны боловсруулалт ямар түвшинд байгааг хэн хүнгүй мэднэ. Өндөр хүчин чадалтай махны үйлдвэр цөөнгүй бий ч өнөөдөр бид нийт махныхаа дөнгөж 10 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулдаг. Экспортын шинэ хандлагатай зэрэгцэн үүнд хувьсгал хийх цаг болжээ.

“Тамирчин” гэх тодотголтой бэлчээрийн монгол малын мах үнэд хүрэх цаг айсуй. ■

PPP Түншлэл

PPP хөгжлийг хурдасгах түлхүүр

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх Концессын тухай хууль батлагдаад нэг жил болж байна. 2001 оноос ярьсаар ирсэн энэ асуудал өнгөрсөн жил биелэлээ олж, хуульчлагдан 2010 оны гуравдугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн юм. Хуульд заасны дагуу Концессын тухай хуулийг хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн хороо хариуцаж, тусгай газрыг бий болгон ажиллаж байна. Ерөнхийдөө нэг жилийн хугацаанд хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажилласан гэж үзэж болно. Хууль хэрэгжүүлэх хүрээнд асуудлыг зохицуулах олон дүрэм, журам боловсруулахыг шаардлага бий, заримыг нь өнгөрсөн жилд боловруулан гаргаж батлуулсан байгаа.

Мөн Концессын гэрээгээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг гаргаж, Засгийн газраар батлуулсан бол одоо уг жагсаалтыг тэргүүлэх ач холбогдлоор нь ангилах ажлыг Олон улсын санхүүгийн корпорацийн санхүүжилтээр Английн эрдэмтэн судлаачидтай хамтран хийж байна. Мөн хөгжлийн түншүүд АХБ, Дэлхийн банк, Германы техник туслалцааны байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, БНСУ-ын Санхүү, стратегийн яам, Төр, хувийн хэвшлийн газрууд туслалцаа дэмжлэг үзүүлж зөвөлгөө өгч ажиллаж байна.

Харин хувийн хэвшлийнхний хувьд дотоодын томоохон компаниуд түншлэлийн дагуу төрөөс хэрэгжүүлэх ажил үйлчилгээг гүйцэтгэх, тендерүүдэд оролцох бэлтгэлээ базааж байгаа. Гэхдээ олонх компани, үйлдвэрийн газар учраа сайн мэдэхгүй, мэдлэг мэдээлэл дутуу, нөгөө талаар идэвх санаачилгагүй хандаж байгаа нь анзаарагдаж байна. Хуульд хувийн хэвшлийн зүгээс тодорхой төслийн санал гаргаж, холбогдох байгууллагад хандаж болохоор тусгасан. Уг нь үндэсний компаниуд хууль дүрмээ

сайтар судлаад, түншлэлийн зарчмаар төсөл хэрэгжүүлж, ашиг орлогоо нэмэгдүүлэх, техник технологио шинэчлэх, боловсон хүчнээ бэхжүүлэх том боломжтой гэж мэргэжилтнүүд үзэж байна.

Ер нь манай улсын хувьд яг төр, хувийн хэвшлийн түншлэл гэж нэрлээгүй боловч дээрх түншлэлийн олон аргыг амьдралд хэрэглэж иржээ. Гэхдээ туршлага, мэдлэг дулимаг байсан учраас алдаж оносон зүйлүүд олон бий. Одоо тэдгээртээ дүгнэлт хийж, цаашдын төслүүдэд олон улсын нийтлэг жишгийг авч хэрэгжүүлэх бодлого барьж байна. Өөрөөр хэлбэл, алдсан зүйлүүддээ дүн шинжилгээ хийгээд үзвэл төрөөс хувийн хэвшилтэй гэрээ хэлцэл хийх чадавхи маш муу, туршлагагүй байсан нь сөргөөр нөлөөлөхөд хүрсэн. Тиймээс гэрээ хэлцэл хийх, тендер зарлах, хамтран төсөл хэрэгжүүлэх чиглэлд ихэд анхаарч, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Концессын тухай хууль болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар Төрөөс баримтлах бодлогын хоёр чухал баримт бичгийг УИХ-аас баталснаар эдийн засгийн шинэ харилцаа бий болсон билээ. Эдгээр баримт бичгийн гол онцлогоос заалтуудаас дурдвал, эдийн засгийн бүтцийг оновчтой болгох, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны цар хүрээг тодорхойлох, үндэсний компаниудын түншлэлд оролцох боломжийг хангах замаар дотоодын компаниудын боловсон хүчин, санхүүг сайжруулах, шинэ техник технологиор хангахад дэмжлэг үзүүлэх зэрэг олон чухал заалт бий. Манай компаниудын хувьд өнөөдөр томоохон хэмжээний төсөл хэрэгжүүлэх хөрөнгө санхүү болон хүний нөөц ямар билээ. Тэгвэл үндэстэн дамнасан корпорациудтай хамтрах эсвэл консорциум байгуулах замаар төсөл хэрэгжүүлэх боломжийг нээж өгч байна. Нийгэм, эдийн засаг,



С.Бэхбат

/ТӨХ-ны Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын газрын зөвлөх/

эрүүл мэнд, боловсрол зэрэг бүх салбарт түншлэлийг хөгжүүлэхээр тусгасан.

Тухайлбал, дэд бүтэц, усан хангамж, эрчим хүч болон суурь үйлчилгээг хувийн хэвшлийн оролцоотойгоор хөгжүүлэхээр төлөвлөж байна. Сургууль, эмнэлгийн барилгыг барихад Концессын төслийг хэрэгжүүлэх боломжтой. Тухайн компани орчин үеийн тоног төхөөрөмж бүхий сургууль бариад 10-20 жилд ажиллуулах эрхтэй болно. Сургуулийн албан хаагчдын хувьд төрийн албанд хэвээр ямар ч саадгүй ажлаа хийгээд л явна. Харин төрөөс тухайн компанид лизингийн хэлбэрээр жил бүр тодорхой хэмжээний мөнгө төлнө. Энэ нь улсаас сургууль эмнэлэг барихад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт нэг удаа хийхгүйгээр жил бүр бага хэмжээтэй хөрөнгө оруулалт хийгээд явах боломжийг нээж өгч байгаа юм. Ийм замаар түншлэлийг хөгжүүлж, төслүүдийг хэрэгжүүлнэ. Нэлээд хугацаа шаардагдах ажил.

Ийнхүү PPP-гийн /Public Private Partnership/ харилцан ойлголцлын түншлэл Монголд хөгжсөнөөр төр нуруун дээрх олон хүнд ачаагаа багасгаж, хувийн хэвшлийнхэн ч хийх ажил, хэрэгжүүлэх төслүүдтэй болж, харилцан ашигтай, гарах болзошгүй эрсдэлээ зөв зохистой хуваарилан улмаар улс орны хөгжлийг хурдасгах нэгэн түлхүүр болох учиртай билээ. Энэхүү хөгжлийн түлхүүрт “Mongolian Economy” сэтгүүл хувь нэмрээ оруулж, “PPP түншлэл” булан нээж ажиллуулж байгаад талархаж байна. ■

Бизнесмэнүүд бол үнэндээ нийгмийн зарц шүү дээ

Тэмдэглэсэн
И.Отгонжаргал, Д.Мөнхчимэг



“Mongolian Economy” сэтгүүл “New Idea & business” гэсэн булан нээлээ. Будаг нь ханхалсан шинэхэн сэтгүүлийнхээ брэнд булангийн анхны зочноор “Өгөөж” компанийн захирал С.Түмэнгэрэл, “Их харанга” компанийн захирал Я.Энхтайван нарыг урилаа. Бизнесээ эхлэх гэж байгаа залууст болон бизнесийн тогоонд чамгүй чанагдаж яваа туршилагатай хүмүүст ч манай “Шинэ санаа ба бизнес”-ийн зочдын ярилцлагаас санаа авах, суралцах зүйл багагүй байна гэдэгт итгэлтэй байна. Энэ агуулгын үүднээс бид ч гэсэн зочдодоо “Бизнес хийхэд зөн совиндоо илүү итгэдэг үү, эсвэл мэргэжилтнүүдийн зөвлөгөөг дагадаг уу? Шинэ санаагаа хэрэгжүүлэх цаг нь мөн үү, эсвэл жаахан хойшоо тавих хэрэгтэй юү гэдгээ хэрхэн мэдэрдэг вэ? гэх мэт шинэлэг асуулт тавьж, ярихаасаа хийхээ урьтал болгодог бизнесмэнүүдийнхээ ярилцлагыг улам сонирхолтой болгосон юм.

-Бизнес хийхэд ер нь авьяас чухал байдаг юм уу эсвэл шантрашгүй хөдөлмөр амжилт авчирдаг уу?

С.Түмэнгэрэл:

–“Их харанга” компанийг би сайн мэднэ. Тантай олон уулзалтад таарч байсан боловч өнөөдрийнх шиг ингэж нүүр нүүрээ хараад, тухлан ярилцах боломж гарч байгаагүй юм байна. “Mongolian Economy” сэтгүүлийн хамт олон анхны дугаарынхаа зочноор урьж, сонирхолтой сэдвээр тантай яриа өрнүүлэх боломж олгож байгаад баяртай байгаагаа хэлье.



Фотог: Б.Бямба-Очир

Шинэ санаа яаж бизнес болдог тухай сэдэв нь өөрөө сайхан санаа байна шүү дээ (инээв).

Миний хувьд бол бизнес эрхлэнэ гэдэг хүн бүрийн чадах ажил биш юм шиг санагддаг. Бурхан хүн бүрт ямар нэгэн авьяас бэлэглэдэг. “Чи дуу дуулж амьдар” гээд зарим хүнд сайхан хоолой заяадаг бол зарим хүн зурж, цөөнгүй хүн зохиол бичээд амьдардаг шүү дээ. Хүн бүрт өөрийн гэсэн хувь тавилан бий. Тэр дотор бизнесийн ухаан ч мөн багтах болов уу.

Нэг жишээ хэлье л дээ. Бид оюутан байхдаа наймаа хийнэ.

1990-ээд онд ганзагын наймаа эхэлж байх үед надаас хамаагүй мундаг сурлагатай, бидний ярьдгаар “толгойтой” оюутнууд байлаа. Тэгээд гурвуулаа яг ижилхэн чанартай, адилхан өнгөтэй өдөн куртка бариад зах дээр зогсож байхад нэгнээс нь л илүү аваад байдаг. Байршил, барааны чанар яг ижилхэн байхад шүү дээ. Товчхондоо, хүн бүр өөрийн гэсэн авьяас чадвартай. Бизнесмэн болно гэдэг ч хувь заяаны л асуудал. Бизнесмэн хүн юм бүрийг харж, ажиглаж чаддаг, тийм ч болохоор байнга шинэ соргог санаагаар баян явдаг байх. Тухайлбал, би Энхтайван

захирлыг ажил хэрэгч, бизнесийн хувь заяатай хүн гэж ойлгодог. Тиймээс ч өнөөдөр “Их харанга” компани гудамж, талбайн рекламны акул болтлоо өргөжиж чадсан байх жишээтэй. Их зөв байрлалд рекламны самбаруудаа тавьчихсан харагддаг.

Мэдээж хүн бүр ямар нэгэн шинэ санаа өвөрлөж, бизнес хийхийг хүсдэг байх. Харин тэрийгээ амьдрал дээр хэрэгжүүлдэг нь хэд вэ гэхээс.

Я.Энхтайван:

-Нээрээ яг ижил бараатай, зэрэгцэж зогсож байгаа хэрнээ нэг нь илүү зардаг тухай Та их оновчтой хэллээ. Тэгэхээр бизнес хийхэд их, дээд сургуульд хэн нь илүү сурлага сайтай байсан нь хамаагүй. Бодоод үз дээ, эдийн засгийн академи төгссөн хүн бизнес хийвэл мөн мундаг явна аа даа? Гэтэл тийм биш байдаг юм аа.

С.Түмэнгэрэл:

-Уг нь бол тийм ш дээ (инээв).

-Тэгэхээр бурхнаас заяасан авьяас илүү чухал гэж ойлгох нь ээ.

Я.Энхтайван:

-Хүсээд олдохгүй, хусаад арилахгүй шинж чанартай байж л хүн бизнес хийдэг. Тамирчдыг аваад үзье л дээ. Үнэхээр байгалиас заяасан авьяас чадвар байвал наадмын талбайд гараад л давах байхгүй юу. Гэтэл авьяасгүй хүн хэчнээн бэлтгэл хийгээд бас хэцүү шүү дээ. Ийм л төрөлхийн авьяасын талаар Түмэнгэрэл захирал дурдаж байх шиг байна.

С.Түмэнгэрэл:

-Гэхдээ бурхнаас заяасан хувь тавиланг хамгийн гол зүйл гэвэл бас буруудчих талтай шүү. “Би бизнесмэн мөн үү, биш үү?” гэдэг нь асуудлын таван хувь байж болох юм. Үлдсэн 95 хувь нь тухайн хүний хөдөлмөр, итгэл үнэмшил, тэсвэр хатуужлаас шалтгаална. Товчхондоо, бизнесмэн байх нэг өөр, цаашид түүнийгээ амьдралд хэрэгжүүлнэ гэдэг бас өөр ойлголт. Хүнтэй харьцаж сурах, хүнийг уншиж сурах, хэнтэй хамтарч ажиллах вэ зэргээс мөн л их зүйл шалтгаална. Үйлдвэрийн гол ажил ганц хүнээс шалтгаалдаггүй. Нэг ширхэг бүтээгдэхүүн ч гэсэн тэр үйлдвэрт ажиллаж байгаа захирал,

үйлчлэгч, мэргэжилтэн гээд бүх хүний хамтын бүтээл байдаг.

-Та хоёр хэн нэгэнд бизнесээ эхэл гэж зөвлөвөл хамгийн түрүүнд юу анхааруулах вэ?

С.Түмэнгэрэл:

-Багаа зөв бүрдүүлнэ гэдэг хамгийн чухал. Манай компанийн хувьд зөв суурь хүмүүжилтэй хүн авч ажиллуулах юмсан гэсэн зарчим баримталдаг. Түүнээс биш, олон дээд сургууль төгссөндөө биш. Зөв суурь хүмүүжилтэй хүн ажилдаа сэтгэлээсээ ханддаг. Тиймээс үнэнч, зөв төлөвшсөн хүмүүсийг л авахыг хичээдэг. Тийм хүмүүсийг ямар ч тохиолдолд сургаад авч болдог.

Я.Энхтайван:

-Миний бодлоор бизнес нь юуны түрүүнд зах зээлийн судалгаанаас эхэлдэг юм. Таны өвөрлөж яваа шинэ санаа зах зээлд гараад ирэхээрээ амьдарч чадах уу гэдэг хамгийн чухал. Амьдрууллаа гэхэд эдийн засгийн үр өгөөж нь ямар байх вэ гэдгийг сайн харуулсан төсөл хийх нь л нэгдүгээр алхам болно. Бизнесээ эхлэхийн тулд өрсөлдөөн ихтэй салбарт орох уу, өрсөлдөөн багатай бизнес хийх үү гээд л судалгаа эхэлнэ шүү дээ. Өрсөлдөөн ихтэй салбарт орвол эдийн засгийн хувьд ахиц гаргалаа ч зугуухан хөгжинө.

-Бизнесмэн хүний хувьд шинэ санаа амьдралаас ургаж байдаг уу?

С.Түмэнгэрэл:

-Амьдрал дунд орох юм бол шинэ санаа их гардаг, мэдээж бас их унших хэрэгтэй. Энэ бүхэн цогцлоод ирэхээр бизнесмэн-удирдагч гарч ирнэ. Энэ чинь өөр ойлголт шүү дээ. Компанийг зөв авч явахын тулд бизнесмэн-удирдагч байх ёстой.

Я.Энхтайван:

-Байгууллага удирдаж байгаа хүний инженер сэтгэхүй маш өндөр байх ёстой. Энэ нь юу вэ гэхээр ямар нэгэн ажил явагдаж байхад хянаж чадах гайхамшигтай шинж чанарыг хэлээд байна л даа. Ер нь эдийн засгийн ухаан гэхээр заавал академи төгссөн байх албагүй. Үнэндээ бүх эдийн засгийн онол тэнгэрээс

унаагүй, газраас ургаж гарч ирээгүй. Хүний амьдралын баялаг түүх, үйл ажиллагаанаас л гарч ирсэн. Сургалт гэдэг үүнийг л зааж буй хэрэг. Харин авьяаслаг хүний хувьд энэ бүхэн заалгасан юм шиг дотроос нь ургаад байдаг юм. Ургаж буй авьяас удирдагч хүнд байхад урагшаа явдаг болов уу. Түүнээс биш, хүн бүр захирал хийх гээд, бизнесмэн болох гээд амжилтад хүрэхгүй. Төрөлхийн чадвар хэрэгтэй, тэр ч бүү хэл, бизнесмэн хүн хошигнох ч авьяастай байх шаардлага байдаг.

-Та хоёрын бизнесээ эхэлж байх үеийг одооныхтой харьцуулахад ямар боломжууд бий болсон байна вэ?

Я.Энхтайван:

-Би бол анх бизнесээ эхлэхдээ их өрсөлдөөнтэй салбарт хөл тавьсан. Солонгос, Хятадын компанийг дампууруулж байлаа (инээв). Миний бизнес чинь гадаадын компаниудад их халгаатай. Дотоодын аж ахуйн нэгжүүдтэйгээ мэдээж өөрөөр харьцдаг. Гудамж, талбайн реклам чимэглэлийн салбараас гадна манайх одоо химийн бодис, тэсэрч дэлбэлэх бараануудын гол худалдаа явуулж байна.

Сүүлд би аккумуляторын үйлдвэр байгуулах гэж нэлээд явлаа. Олон орноор явж, туршлага судлаад, Тайвань, Хятад, Солонгосын туршлага дээр тулгуурлан ийм үйлдвэр ажиллуулах боломж байгаа юм. Эдийн засгийн бүх тооцоо нь гарч байгаа. Гэтэл түүхий эдийн асуудал тулгарсан. Мэдээж би энэ байдлыг урьдчилан харж байсан л даа. Өнөөдөр Монголд 1.5 сая тонн хар тугалганы нөөц бий. Түүхий эдээ үүнээс авч ашиглавал хэзээ ч барахааргүй асар олон үндсэн орд байгаа юм. Гэтэл Ашигт малтмалын газраас тендер гээд нэг даваа байна. За тэгээд оновчтой гэсэн газрууд нь бүгд эзэнтэй болчихсон. Ихэвчлэн хятад эзэдтэй юм билээ. Надад 24 орчим уурхайн санал ирэхэд 18-ынх нь ард ямар нэгэн байдлаар хятад хүн байх шиг байна лээ. Аккумуляторын үйлдвэр ажиллуулахын тулд би уурхайг доод тал нь нэг сая доллараар авах гээд байгаа юм. Тэгээд хар тугалганы баялгийг ялгах

үйлдвэрийн тоног төхөөрөмж гэхэд л 700 мянган долларт босох ёстой. Үндсэндээ зөвхөн уурхай авах ажил дээр л зогсчихож байгаа юм. Энэ бүхэн эдийн засгийн зохисгүй байдлыг харуулж байгаа хэрэг. Өнөөдөр Дорнодод хоёр том орд бий. Нэг нь хар тугалгыг гулдмайлж, нөгөөх нь баяжмалаар гаргаж байгаа.

С.Түмэнгэрэл:

-Миний хувьд нэг юм хийгээд түүнийгээ бат суурьтай болгочихоод л дараагийн ажилдаа орох нь зөв юм болов уу гэж боддог. Ер нь хүмүүс надаас яагаад өөр бизнес рүү ордоггүй юм бэ гэж асуух нь бий. Их мөнгөтэй салбар руу яагаад ордоггүй юм бэ гэж (инээв). Жишээ нь 1990-ээд онд архины үйлдвэрлэл маш ашигтай байлаа. Ямар нэгэн лиценз, энэ тэрээ шаардагдахгүй. Тухайн үед архи хийгээд зарсан бол би эдийн засгийн хувьд магадгүй өнөөдрийнхөөс ч сайн байх байсан гэж болох. Гэхдээ би зөв юм хийчих юм сан л гэж боддог. "Өгөөж" бол 75 жилийн түүхтэй компани. Сайн компани, сайхан хүмүүсийг ажиллуулж байгаадаа өөрийгөө азтай гэж боддог. Цаашид энэ компани агуу болгох юм сан гэж зорьж байна. Агуу гэхээр хүмүүс олон салбар руу ороод л, холдинг болох юм шиг бодож магадгүй. Миний бодлоор агуу компани гэдэг бол тогтвортой өсөлттэй байх ёстой. Тэрний дараа л бусад бизнест орох талаар бодож болох юм.

-Та хоёр баян хүмүүс мөн үү?

С.Түмэнгэрэл:

-Манай зарим хүн бизнесмэнүүдийг ашиг хонжоо хайсан сувдаг шунахай хүмүүс гэж боддог. Уг нь тэр талаасаа бодмооргүй байгаа юм. Хүн шинэ санааг амьдралд хэрэгжүүлээд, өөрт болон бусдад тустай юм хийгээд, түүгээрээ өөрөө хөрөнгөө олж байвал жинхэнэ бизнесмэн мөн. Хэн их мөнгө олсондоо гол нь биш, яаж олж байна вэ гэдэгтээ л байдаг. Мөнгийг бол зөвөөр олох ёстой. Хүн хуурч мэхлэх, хулгай хийх зэрэг муу аргаар биш. Зөв замаар явж байгаа, зөв юм бүтээж байгаа хүмүүсээ дэмжиж байж л бид хөгжилд хүрнэ. Бизнесмэн болно гэж

Багаа зөв бүрдүүлнэ гэдэг хамгийн чухал.

Манай компанийн хувьд зөв суурь хүмүүжилтэй хүн авч ажиллуулах юмсан гэсэн зарчим баримталдаг. Түүнээс биш, олон дээд сургууль төгссөндөө биш. Зөв суурь хүмүүжилтэй хүн ажилдаа сэтгэлээсээ ханддаг. Тиймээс үнэнч, зөв төлөвшсөн хүмүүсийг л авахыг хичээдэг. Тийм хүмүүсийг ямар ч тохиолдолд сургаад авч

итгэж байвал болохгүй юм байхгүй. Сайн явж байгаа хүмүүстэй уулзаад л, хараад л, суралцах хэрэгтэй дээ. Тэр хүн яаж ажлаа амжуулж, зохицуулж амжилтад хүрч байна вэ гэдгийг л харах ёстой.

Я.Энхтайван:

-Бизнесмэнүүд бол их баян, ханаж цадахаа мэдэхгүй улс гэсэн ойлголт нийгэмд үнэхээр байдаг. Та эмзэглэж явдаг юм шиг байна, би ч мөн ялгаагүй. Манай нийгэм ухамсар болоод эдийн засгийн хувьд төлөвшиж чадаагүй учраас л ийм яриа гарч байгаа болов уу. Тамирчан хүн мөнгөн медаль авчихаад л “Би боллоо” гээд спортоо хаяж байвал хамгийн утгагүй хэрэг биз дээ? Тэгвэл бизнесмэн нэг үйлдвэр ажиллуулаад ирэхээр нэг талаас тэнд ажиллаж байгаа хүмүүсийнхээ хувь заяаг давхар хариуцаж байгаа хэрэг. Нөгөө талаас тэр бизнесмэн ард түмний төлөө үйлчилж байна. Тэгвэл тэр үүрэг, хариуцлагыг асар гүнзгий ухамсарлах ёстой. Ажлаа зогсоох ч эрх байдаггүй. Хоёрыг үйлдвэрлэдэг байсан бол дөрвийг үйлдвэрлэдэг болох, хүмүүстээ 200 мянган төгрөгийн цалин өгдөг байсан бол 400 мянга болгохын төлөө ажилладаг. Хийж буй зүйлээ аль болох л шат ахиулах бодлого баримтлахаас өөр арга байхгүй. Бизнес эхэлнэ гэдэг

чинь нэг том хүрд эргэж байна гэсэн үг. Нэгэнт эргэсэн хүрдийг зогсоох эрх захиралд байдаггүй. Түүнээс биш сувдаг, сувдаггүйдээ биш. Мэдээж үйл ажиллагаа явуулж байгаа хүн тодорхой хэмжээний ашиг ололгүй яах вэ. Гэхдээ захирал хүн нийгмийн төлөө асар их хөдөлмөрлөдөг. Үнэндээ нийгмийн зарц л юм шүү дээ.

С.Түмэнгэрэл:

-Хүн эхлээд өөрийн хэргцээг хангах гээд явдаг. Сайхан амьдрах юмсан, үр хүүхэд, гэр бүлээ сайхан аваад явчих юмсан гэж. Тэгээд өөрийн хэргцээг бий болгочихоод нийгмийн хэргцээг бий болгохыг зорьдог. Түүнээс биш, мөнгөний төлөө гээд шунаж байгаа юм биш. Бизнесмэн хүн бүтээн байгуулж байгаа юмнаасаа таашаал авдаг. Хувийн хэргцээний мөнгө бол өчүүхэн шүү дээ. Харин хийж бүтээхэд хэрэгтэй болохоор эдийн засгийн суурийг бий болгохоос өөр аргагүй.

Я.Энхтайван:

-Ер нь баян хүн, бизнесмэн хүнийг ялгаж салгаж ойлгох ёстой. Баян хүн гэхээр асар их хөрөнгө өвлөөд авчихсан, түүнийгээ өсгөж арвижуулахын оронд өөртөө л их мөнгө зарцуулаад явж байгаа хүнийг хэлэх байх (инээв). Тэгвэл бид хоёр хүмүүсээс юугаараа илүү ялгараад байгаа юм бэ? Зөвхөн сэтгэлгээ л баялаг байх. Түүнээсээ баялгийг бүтээж гаргаж байгаа л хүмүүс шүү дээ.

-Иргэдэд тарааж байгаа 21000 төгрөгийг бизнесмэнүүд юу гэж үзэж байгаа бол?

Я.Энхтайван:

-Одоо монголчууд голдуу хямд өртөгтэй хятад бараа хэрэглэж байна. Тиймээс дотоодын үйлдвэрүүдийг хамгаалсан хууль эрх зүйн орчин байх ёстой шүү дээ. Татварын хөнгөлөлт, гаалийн татвар ч байдаг юм уу. Хар л даа, Монгол Улс импортын орон л байна шүү дээ. Импортын орон эдийн засгийн хувьд хамгийн тогтворгүй, хөгжлийн хувьд хэзээд буурай байдаг түүхтэй. Өнөөдөр Монголын 2.8 сая иргэний 30 хувь нь хөдөлмөрийн фронтын хүмүүс гэдэг. Тэдний сарын цалин дунджаар 400 мянган төгрөг

гэж бодье. Тэгэхээр маш том тоо гарч ирнэ ээ дээ. Үүний хажууд 21 мянган төгрөг өчүүхэн шүү дээ. Эрх баригчид 21 мянган төгрөг тараачихаад инфляци үүснэ гэж ярьж сууна. Уг нь энэ бол мөнгөний ханшийг хөдөлгөөд байх хэмжээний тоо биш. Гэтэл 21 мянган төгрөгөөс болж мөнгөний ханш хэлбэлзээд байгаа нь манай нийгэм, эдийн засаг ямар сул дорой байгааг л харуулж байгаа юм.

Нийгмийг хүчирхэгжүүлэх хамгийн гол хөшүүрэг гэвэл үйлдвэрлэлээ хөгжүүлэх. Монголыг аж үйлдвэржсэн орон болгохын тулд л эрх баригчид шамдах ёстой байна. Тэгвэл ажлын байрны тоо нэмэгдэнэ, хүмүүсийн цалин ч өснө. Товчхондоо хөгжлийн алтан үе ирнэ. Та бодоод үз дээ! Сар бүр 400 мянган төгрөгийн цалинтай ажил хийвэл жилдээ 4.8 сая төгрөг болно шүү дээ. Харин сардаа 21 мянган төгрөг юу ч хийхгүйгээр авахад жилийн 252 мянга л болж байна. Аль нь нийгмийг хөдөлгөх гол хүч болох вэ? Тэр 805 тэрбумаа эрх баригчид үйлдвэрүүдэд тараачихвал бид хүмүүсийг ажилд аваад, цалинжуулчихъя л даа. Тэгвэл 21 мянган төгрөг авах гэж хүмүүс банкинд дугаарлан зогсохоо болино.

С.Түмэнгэрэл:

-Миний бодлоор хамгийн түрүүнд монгол хүний сэтгэхүйг өөрчлөх хэрэгтэй. Гендээ ч байдаг юм уу. Монголчууд нүүдлийн сэтгэхүйтэй. Сургаар, эсвэл цээжний тооцоогоор ажил хийдэг. Эсвэл бие биенээ их дуурайдаг. Нөгөө талаас багаар ажиллаж чаддаггүй, уулын мухарт хар гэртээ хаан гээд л. Уулын хормой болгонд нэг хаан байх жишээтэй. Хоорондоо зохицож чаддаггүй, нөгөө талд юу болж байгаа нь хамаагүй. Ардах, урдахаа бодно гэж байхгүй. Өвс байлаа гэж бодоход малдаа өгөөд л дуусгачихдаг. Дараа нь юу болох нь хамаагүй. Өвс нь дууссан, мал нь тухайн үедээ цадсан. Гэтэл япончууд энэ өвсийг яаж хэмнэлттэй хэрэглэх вэ, эсвэл яаж их болгох вэ гэж хамтарч боддог юм байна. Бид суурин амьдралд ороод ирэхээр хуучны сэтгэлгээ маань саад болдог юм болов уу. Үүнийгээ өөрчилж чадсан тохиолдолд их хол явах байх. Сэтгэлгээг өөрчлөх

» тал дээр төр, засаг анхаарах ёстой. Гэтэл төр нь бизнесмэнүүдийнхээ эсрэг хүмүүсийг босгоод байгаа нь харамсалтай. Үнэ нэмэгдлээ гэхэд энэ бизнесмэнүүд ямар муухай улсууд вэ, далимдуулаад ашиг олж байна. Бид уг нь үнэ бууруул гэсэн, тэр нөхөр л бууруулахгүй байна гээд байх жишээтэй. Бизнесмэнүүд жинхэнэ баялгийг бүтээж байгаа гэдгийг ойлгуулж өгдөггүй. Зах зээлийн жамаар үнэ буурлаа гэхэд бид буулгалаа гэдэг. Төрийн хүмүүсийн толгой өөрчлөгдөх цаг болжээ. Дарга хүн сайхан амьдардаг гэсэн социализмын үеийн сэтгэлгээнээс салах хэрэгтэй байна. Монголд бизнес хийж байгаа, баялгийг бүтээж байгаа хүн сайхан амьдардаг гэсэн сэтгэлгээ, орчинг бий болгох ёстой. Өнөөдөр бараг бүх залуучууд аль нэг намыг дагаад, цаашлаад дарга болох хүсэлтэй байна шүү дээ. Тэгж байж амьдрал сайжирна гэх. Гарын үсэг



зураад л зүгээр мөнгө авна гэсэн бодол төлөвшиж байна. Уг нь сайхан санаа оноотой залуус олон байна.

-Та энэ талаар юу гэж бодож байна?

Я.Энхтайван:

-Үнэхээр нийгэм эргэчихсэн харагдаж байгаа шүү дээ. Хувьсгалт нам хуваагдчихлаа. Тэр сайхан залуучууд ажил хийж үзсэн болов уу л гэж бодогдож байгаа юм. Гэтэл тэд хөгшчүүдийн гаргаагүй хорыг гаргаж ирж байна шүү дээ. Нэг залуу эхлээд христийн номлогч байсан, дараа нь "Number 1" гэж гүйгээд, одоо гэтэл "Number 1"-ээ муулчихсан явж байх жишээтэй./инээв/Гэтэл социализмын үед нэг сайд томилогдлоо гэхэд

тухайн хүний түүхийг хөөдөг байсан. Тэр Сангийн аж ахуйн даргаар тэдэн жил, сумын даргаар тэдэн жил, аймгийн хянан шалгах хороонд тэдэн жил, яамны хэлтсийн даргаар тэдэн жил гэж байж сая нэг юм Сайд гарч ирдэг. Амьдралын тогоонд мөн ч их чанагдаж, боловсорсон хүн гарч ирж байжээ дээ. Гэтэл одоо яаж байна аа? Залуучууд улс төр рүү ингэж гүйж байгаад сэтгэл зүрхнээсээ харамсаж байна.

-Та хоёрын хувьд бизнесийн гал тогоонд 20-иод жил буцалсан. Нэг үгээр хэлбэл, хал үзэж, хашир суужээ. Энэ хугацаанд бизнест хэрхэн туршилагжсан бэ, тэр хэрээр алдаа оноогоо олж харж байгаа болов уу?

Я.Энхтайван:

-Миний хувьд илүү сэтгэх хэрэгтэй байдаг юм. Би илүү сэтгэхэд асар их хөтлөгддөг. Илүү сэтгэхүйнээсээ болоод заримдаа хямарчихдаг ч тал бий. Жишээлбэл, байшин барилгын гэрлэн чимэглэлийг Монголд нэвтрүүлэхээр 1999 онд томоохон үзэсгэлэн гаргаад, тэр хэрээрээ эдийн засгийн хохирол амссан.

-Яагаад?

-Түрүүлж сэтгээд уг үзэсгэлэнг гаргасан. Монголын байшин барилга, гудамж, талбайг бүгдийг нь ийм гоё болгоё гэж. Тэр үед үүнийг ойлгож хүлээж авах хүн байсангүй. Үзэсгэлэнг сонирхсон хүмүүс ийм гоё юм байдаг аа гээд байсан болохоос хийлгэе гэсэн хүн нэг ч гараагүй. Хий л шогшроод байсан.

-Танай байгууллагыг гудамж, талбайд ингэж сурталчилж өгье, үр дүнд нь ашиг орлого чинь ингэж нэмэгдэнэ гэж итгүүлэхэд хэцүү л байдаг байх л даа.

-Манай компанийн хувьд их өвөрмөц. Ихэвчлэн аж ахуйн нэгжүүдтэй харилцана. Реклам талаас нь тухайн байгууллагын захирлыг ч байна уу, менежерийг ч байна уу заавал илүү сэтгэхэд хөтөлж байдаг. Рекламыг нь хийгээд өгье гэхээсээ илүү онолынх нь талаас багагүй зүйл ярьж өгнө шүү дээ. Бүр жишээ авч ярина. Хэрвээ ингэвэл нийтийн хүртээл болно. Ингэхгүй



бол зөвхөн үйлдвэрлэсэн газраа тухайн дэлгүүрээр үйлчлүүлдэг хэдхэн хүний хэрэглээ байна гээд олон юм ярина л даа. Ингээд ярихаар эдийн засгийг нийгэмтэй холбохоос аргагүй болдог. Нийгмийн худалдан авалт гэдэг том зүйл бий. Жишээлбэл, Хятад Монгол хоёрыг харьцуулаад харчихъя. Өнөөдөр урд хөршид хуучин машины худалдан авалт бараг байхгүй. Бараг байхгүй байтугай, огт байхгүй. Манайд өнөөдөр шинэ машины худалдан авалт байна уу? Тоотой цөөхөн. Энд төрийн бодлого хэрэгтэй.

-Монголд өнөөдөр гудамж, талбайн гэрэлтүүлэг чимэглэл ид хөгжиж байна.

-Бид Сингапур, Хонконг, Япон, Солоносын түвшинд хүргэх гээд үелздэг гэрлийг оруулж ирсэн. Саяхан электрон дэлгэц гэж гарч ирж байсан бол одоо би үүний үеийг нь өнгөрөөж, хална гэж бодож байгаа. Дараагийн шатны зүйлийг тооцоолчихсон. Лазер эффект өгдөг маш гоё зүйл бий. Тэр бол их тасархай юм гараад ирсэн.

-Үнийн хувьд ямар байх вэ?

-Үнэтэй үнэтэй. Дунджаар л 100 мянган ам. доллар. Манайд сайн чанартай зүйлийг хөрөнгө хүч гаргаад оруулаад ирэхээр түүнийг түрээслээд хэрэглэх хүн нь бас цөөн шүү дээ. Бараа чанартай, дунд, муу байхад мэдсээр байгаад мууг нь авчих нь бий. Түүнтэй адилхан шүү дээ. "Өгөөж" чихэр боов шиг ийм тогтчихсон компаниуд бол дунд юм уу сайныг авна л даа. Гэх мэтчлэн нийгмийн хэрэглээ гарч ирдэг.

Манай нэг давуу тал байгаа.

Оросууд саяхан манайтай гэрээ хийгээд, баталгаажуулалтын төлбөр мөнгөө өгчихөөд буцсан. Электроникийг тэд Хятадаас биш, манайхаас авч байгаа. Сонирхолтой байгаа биз. Монголын нэг бизнесмэн өнөөдөр электроникийн худалдаанд өндөр амжилт гаргалаа. Бид хойд зах зээлд нэвтэрч чадлаа. ОХУ-ын хэд хэдэн компани манайхаас худалдаж авсан гээд бод доо. Тэд мэдээж, Солонгос, Тайванийн компанийн үнийн саналыг сонирхсон байгаа. Энэ дотроос манай үнэ хамгийн боломжийн байж чадаж байгаа байхгүй юу.

Би Хятадад очоод Монгол Улс ирлээ гэж ярьдаг. Манай компани бүх нийтийн үйл ажиллагаа явуулдаг учир та нар улс ирлээ гэж ойлгож болно гэдэг. Энэ утгаараа би монголчуудынхаа төлөө их зүйл хийж сэтгэж байгаа.

С.Түмэнгэрэл:

-Улсын хөгжлийг бизнесмэнүүд авч явдаг гэдэг л энэ байхгүй юу. Тэгэхээр би залуучууддаа та нар бизнесмэн бол оо, ажил хий. Тэрнээс биш, нам юм уу, эсвэл хэсэг бүлгийг дагаж битгий хошуур. Сайхан санаа оноотой залуучууд байна. Би бодохдоо залуучууд илүү ихийг сэтгэж, улс орон өмнөхөөсөө илүү хөгжсөн байх ёстой гэж боддог.

Өнөөдөр IPO хийнэ, хувьцаа гаргана, ингэнэ тэгнэ гээд л сэтгэхүй нь шал өөр түвшинд очсон залуус байна. Энэ цаг үе ирснээрээ тийм боломжийг ч гэсэн тэр хүмүүст олгожээ. Хамгийн гол нь манайхан үр хүүхдэдээ багаас нь зөв хүмүүжил олгох хэрэгтэй юм болов уу. Үүнийг бид орхичихоод байна. Бүр том болоод, төлөвшчихсэн хойно нь түүнийг нь өөрчлөх гээд зовоод зүтгэх. Ясли цэцэрлэг, сургуульд нь төлөвшүүлчих ёстой. Хүн эхлээд зөв бодох ёстой. Зөв бодохоос өмнө тархиндаа зөв программ суулгах ёстой. Зөв үйлдэл хийхэд зөв үр дүн гарах ёстой. Ийм шатлалаар явбал ирээдүйн залуучууд өнөөдрөөс илүү амжилттай өөр сэтгэхүйтэй болж хүмүүжнэ.

-Сүүлийн үед үнэхээр дэлхийн

түвшинд боловсрол эзэмшсэн залуус Монголдоо ихийг хийж бүтээхээр ирсэн байгаа. Та хоёрын хувьд шинэ боломжийг тэр шинэ үеийн залуустай хамт ашиглах талаар юу бодож явдаг вэ?

С.Түмэнгэрэл:

-Миний хувьд бизнесийн боломж ямар ч цаг үед байдаг. Гагцхүү тэрийг олж харах, ажил хэрэг болгоход л асуудал байгаа. Монголд боломж дүүрэн байна. Манай аль ч зах зээл эзлэгдсэн, тогтсон юм байхгүй шүү дээ. Дөнгөж хөгжиж байгаа зах зээл. Харин энэ боломжууд дээр

Залуус Монголдоо
байгаа олон
боломжийг ашиглах
талаар бодож, сэтгэж,
ажиллаасай

залуучууд маань ажиллаасай. Гэтэл олонх залуучууд улс төр рүү орж, дарга болоод хурдан баяжина гэсэн ганцхан боломж хараад байгаа нь харамсалтай.

Я.Энхтайван:

-Түмээ, бас л их сонирхолтой зүйлийг хөндөөдөхлөө. Энэ ер нь олон болохгүй юмыг гаргаж ирдэг хүн байна шүү /инээв/. Хэрвээ манай бизнесмэнүүд их мөнгөтэй бол Монголд дэвшилтэт технологид гарах ганц хоёр шаанс байдаг. Миний хувьд ч гэсэн зорьсон юм бий. Том объект мөнгө залгиад намайг ядрааж л байгаа. Жишээлбэл, биотехнологит монгол орон гараад ирэх боломжтой. Ерөнхийдөө санхүүжилт нь зөв байдаг юм бол үүнийг олон улсын түвшинд гаргаад ирэх боломж харагдаад байгаа.

Мөн манайд сүүлийн жилүүдэд уурхай олноор нээгдэж байна. Түүхий эдийн хавсрага орон биш, 30 хувийн үйлдвэрлэлтэй орон болгочихвол их хэрэгтэй. Тэгэхдээ боловсон хүчний бодлогыг зөв барих нь маш том асуудал. Тэр монголчуудын сэтгэхүйг өөрчлөх тухай Түмээгийн ярьж байгаа асуудал миний харамсаж явдаг юмны нэг. Өнөөдөр улаанбаатарчууд нь гадагшаа

гараад явчихсан. Хөдөөнийхөн Улаанбаатарыг дүүргэчихсэн байна шүү дээ. Ажил хийхийн тулд тэр хүн наад зах нь Хөдөлмөрийн тухай хууль мэддэг байх ёстой. Тухайн ажлынхаа талаар анхан шатны мэдлэгтэй байх ёстой. Тиймгүй хүн их ирнэ шүү дээ. Тэгж тэгж арай гэж жаахан юм сургана. Тэгтэл мөнөөх маань хүнээр заалгаж сурчихаад биеэ тоож байгаа гэж жигтэйхэн. Боловсон хүчний бодлого дээр онцгой анхаарах цаг болсон. Өгүүлбэрийн алдаа нь цэгцрээгүй оюутнууд төгсгөдөг олон дээд сургуулиар яадаг юм. Энэ нь эдийн засгийн хувьд асар их хор хохирол дагуулдаг. Сайхан сайхан залуучууд нийгэмд хөдөлмөрлөвөл зохих цагийг хэнд ч хэрэггүй мэргэжлээр сурч дэмий өнгөрөөж байна. Аав, ээжийнхээ зовж олсон өчнөөн мөнгийг эргүүлж ашиглахгүй мэргэжлийн төлөө салхинд хийсгэдэг. Аливаа юмыг ажил болгоход их сонин шүү дээ. Би зарим сайд, дарга нар ярьдаг л даа. Ингэхэд ойлгоод байгаа бололтой урдаас хараад “тийн тийн” гээд байдаг. Тэгээд хийж өгдөггүй юм. Тийм биз хэ, Түмээ. Тэгэхээр бид яах вэ. Үнэн амьдрал шүү дээ энэ.

С.Түмэнгэрэл:

-Үнэн үнэн. УИХ-ын гишүүд тэнэг биш болоод бид нараас илүү учраас л УИХ-д сонгогдсон байх. Чухам юугаараа илүү юм бүү мэд. Тухайн үедээ л байх. Зальтай юм уу, азтай юм уу. Эсвэл хүнтэй учраа олдог улс юм уу. Миний ойлголтоор тэр хүмүүс мангар тэнэгтээ биш байх. Манай улсын өөрийнх нь суурь их буруу болчихсон юм. Сонгох сонгогдох систем нь. Байшингийн суурийг буруу барьчихаар дээр нь хэчнээн гоё юм хийгээд алтаар бүрээд ч тэр байшин нураад унадаг. Үүн шиг сонгуулийн систем буруу учраас бидний гайгүй гээд сонгосон улсыг системдээ оруулаад машиндаад байна гэж би ойлгодог. Тэр системийг эрс өөрчлөх хэрэгтэй.

Таны хэлдэг үнэн л дээ. Сайн дарга амжилтын 50 хувь гэдэг. Зуун хувь бол биш шүү дээ. Сайн хамт олон сайн боловсон хүчин байж гэмээнэ зуун хувь болно. Одоо хүртэл социализмын үед яригдаад байдаг уриа хэвээрээ гэж би ойлгодог. “Боловсон хүчин бол бүгдийг

» шийднэ”. Үүн дээр юу нэмэгдсэн гэхээр хэрэгтэй сэтгэлтэй боловсон хүчин бүгдийг шийднэ гэж ойлгоод байгаа. Хүнд ер нь явж явж хамгийн гол юм цаг байдаг юм байна лээ. Юм хийж бүтээх гэж байгаа хүнд бол нэг минут ч их үнэтэй. Хийх юмаа олж ядаж байгаа хүмүүст нэг минут ч удаан. Монголыг зөв сэтгэлгээтэй, ажил хэрэгч, зөв бизнесмэн хүмүүс чирч явна. Монголын залуус Монголдоо байгаа олон боломжийг ашиглахаас гадна интернэт гэдэг аугаа зүйл дэлхийг гарт чинь атгуулчихаад байна шүү дээ. Дэлхийг ч эзлэх боломж бололцоо байна. Энэ тал дээр бодооч ээ, сэтгээч ээ, залуус аа.

-Бизнес хийхдээ зөн совинд илүү итгэдэгүү, эсвэл мэргэжилтнүүдийн зөвлөгөөг дагадаг уу?

Я.Энхтайван:

-Зөн совинд найдаад байж болохгүй. Мэргэжилтнүүдээс зөвлөгөө ч аваад байхдаа гол нь биш. Нэгдүгээр хүн зах зээлийг өөрийн гараар нарийн судалж, өөрийн онолоороо явах ёстой. Тэгсэн тохиолдолд алдах нь ч бага. Алтны хайгуулийн компани геологчийнхоо үгээр ороод дампуурах нь байдаг. Алт олохын хувьд олно. Гэхдээ 300 сая төгрөг зараад 100 саяын алт олсон байх жишээтэй. Ийм байдалд хүрэхгүйн тулд нэгдүгээр хүн Та бизнесээ өөрийн онол, өөрийн оюун ухаанаараа хөтөлсөн цагт амжилттай явдаг.

С.Түмэнгэрэл:

-Хүмүүстэйгээ ярилцаж, судалгаа шинжилгээнүүдийг үзэх хэрэгтэй. Мэдээллийг авах гэдэг үүднээс. Эцсийн эцэст хариуцлагыг захирал үүрдэг болохоор эцсийн шийдвэрийг захирал гаргах нь зөв өө. Энд мэдээллийг боловсруулах чадвар, мэдрэхүй, мэдрэмж, за тэр зөн совин ч бас орно. Бүгдийн нийлбэрээс л зөв шийдвэр гаргах учиртай. Захирал хүн алхам тутамдаа шийдвэр гаргаж байдаг. Доороосоо зөв хүмүүжилтэй байж, бүгдийг харьцуулж, дотор хүнтэйгээ сайтар ярилцаж байж гаргасан шийдвэр нухацтай бөгөөд зөв байж магадгүй. Шийдвэр гарсны дараа үйл явдал өөрөө харуулна шүү

дээ.

-Энхтайван захирлын хувьд юмыг урьдчилж харж, илүү сэтгэснээрээ хохирдог талтай гэлээ. Шинэ санааг цаг үедээ тохирч байна уу, үгүй юу гэдгийг яаж мэдэрдэг вэ?

Я.Энхтайван:

-Энэ бол амьдрал дээр шалгуур болоод гараад ирсэн асуудал. Би сүүлийн үед түрүүлж сэтгэхээ тодорхой хэмжээгээр багасгасан. Нэг үгээр хэлбэл, мэдээллийн технологийг хэчнээн түрүүлж шүүрч авч байгаа ч гэсэн тэр болгоныг түрүүлж хэрэгжүүлэхээ больсон. Хоёрдугаарт, цээж өндөр ч гэх юм уу том бодлоосоо заримыг нь авч хаясан. Мөн хүмүүсийн ахуйн хэрэглээгээр хэрэгжиж байдаг бизнес гэж байдаг. Шүдний оо, саван ч байдаг юм уу. Зарим энэ чиглэлээр ажилласан бизнесмэн мань мэтийн технологийн дэвшил рүү орчихсон бизнесмэнээс давчихсан явах нь ч байна. Тиймээс иймэрхүү зүйлийг хавсрах бодолтой байгаа.

С.Түмэнгэрэл:

-Аливаа юм өөрийн цаг хугацаандаа байвал илүү үр дүнд хүрч, үнэ цэнэтэй байдаг. Том сэтгэх ёстой юу гэвэл том сэтгэх ёстой. Алсыг харах ёстой юу гэвэл алсыг харах ёстой. Бага зорилго тавих юм бол хол явахгүй ээ. Хэтийн зорилго асар том байх ёстой. Тэрийг чухам хэзээ хэрэгжүүлэх вэ гэдэг өөрийнх нь цаг хугацааны л асуудал байх.

Я.Энхтайван:

-Энд би ярилцаж байгаа сэдвийнхээ хүрээнд нэг инээдтэй юм ярья гэж бодлоо. Хэн нэгэн ямар нэгэн бизнесийг маш сайн хийсэн байлаа гэж бодъё. Бизнес мөнхөд дээр байна гэсэн онол байхгүй юм аа. Дороос нь бас нэг чадалтай компани гарч ирээд л түлхэж унагачих гээд байдаг. Тэгэхээр бизнесмэн хүний нэг онцлог бол цаг ямагт сэтгэх ёстой. Цаг ямагт өрсөлдөөнийг идэвхжүүлж чангаруулж байх учиртай. Жишээ нь “Өгөөж” дээр бодъё. Түмээ, талх нарийн боовоо байнга л шинэчлэхгүй бол наагуур нь янз янзын амттай боов гарч ирж цохичих гээд л болж

өгөхгүй. Тэгэхээр л яаж мөнгө босгох уу, яаж бараагаа чанаржуулах уу, яаж борлуулалтын сүлжээгээ бий болгох вэ гээд түмэн бодолд автаж явдаг. Нэг юманд би хаан гэж хэлэх арга байдаггүй. За одоо инээдтэй зүйлээ ярья.

Нэг боксын аварга хоолонд оржээ. Тэрбээр малгайгаа өлгүүрт өлгөхдөө “Би дэлхийн боксын аварга, малгай авбал нам цохино” гэж бичээд оржээ. Гараад ирсэн малгай нь байдаггүй. Зөрүүлээд бичиг биччихсэн байна гэнэ. “Би дэлхийн гүйлтийн аварга хөөгөөд гүйцвэл нам цохино” гээд бичээд үлдээсэн байна гэнэ. Бизнесийн өрсөлдөөн гэдэг чинь нэгнээ басаж болохгүй, би том гэж томорч болохгүй яг ийм болчихоод байгаа. Өнөөдөр хэнд ч гүйцэгдэж магадгүй. Гагцхүү баялаг сэтгэхүй, зөв технологи дээр л тулгуурлана.

С.Түмэнгэрэл:

-Мөнхийн юм гэж байхгүй. Юмны оргил гэж бас байхгүй. Тэгэхээр дандаа л сэтгэж байхаас аргагүй.

Я.Энхтайван:

-Бизнесмэнүүдийг судлаад үзсэн байдаг л даа дэлхий дээр. Ингэхэд компанийн 96 хувь нь зөвхөн нэгдүгээр хүн буюу захирлаас болж дампуурсан байдаг. Тэгвэл 96 хувьд оролцож байгаа хоёр хүн энэ ярилцлагаар санаа бодлоо уншигчидтайгаа хуваалцаж байна. (инээв) Тэгэхээр та бүгдэд биднийг сонгож авсанд талархаж байна. Бизнесийг цааш цаашдаа эрүүл, хүртээмжтэй байлгахын тулд танай сэтгүүл чухал хувь нэмэр оруулах байх гэж бодож байна.

С.Түмэнгэрэл:

-Бизнес, эдийн засгийн зөв мэдээллийг, зөв мэдлэгийг, сайхан туршлагыг хүмүүст хүргэсэн хэвлэл манайд үгүйлэгдэж байдаг. Тэр орон зайг танай сэтгүүл нөхөх юм байна гэж ойлгож байна. Ийм сайхан зүйл хийх гэж байгаа та нөхдөд талархаж буйгаа илэрхийлье. Та бүхний энэ ажил амжилттай байгаасай. Монголын ажил хэрэгч хүмүүст, бизнесмэнүүдэд танай гаргаж байгаа сэтгүүл ажил амьдралд нь хэрэг болохоор зөв тоо баримттай,

“Барс” зах жилдээ 1600 вагон хүлээж авдаг

И.Жаргал

“Mongolian Economy” сэтгүүл хүмүүсийн аж амьдрал ямар байгааг хүнсний захаас олж харахыг зорилоо. “Барс” захаас сурвалжлага хийх үед Цагаан сар тун ойртсон байсан учраас жимс, ногоо цуглуулсан хүний хөл хөдөлгөөн их байлаа. Миний бие Улаанбаатар хотын олон захаас сурвалжага хийж байсан боловч өнөөдрийг хүртэл Баянгол дүүргийн III хорооны Тээвэрчдийн гудамжинд байрлах “Барс” захаар орж онцлогийг нь мэдрээгүй явсан юм билээ. Жимс, ногоо мэтийн импортын хүнсний бүтээгдэхүүн шууд буудаг болохоор тус зах бусдаас ялгарах онцлогтой. Тиймээс төрөл бүрийн жимс, ногоо энд харьцангуй хямд. Жимсний тасгийн худалдагч Б.Цэнгэлмаагаас зарим зүйлийг сонирхлоо.



-Наймаа хэр байна. Борлуулалт ч сайн байх шүү дээ. Инфляцийн өсөлт та нарт хэр мэдэгдэж байна вэ?

-Борлуулалт ноднин жилийнхтэй харьцуулахад муу байна. Хүмүүсийн гар дээр очиж байгаа 21000 төгрөг чинь юу болох вэ дээ. Инфляци гэдгийг захын наймаачин бид нар сайн мэдэхгүй. Гэхдээ сүүлийн жилүүдэд халамж хэлбэрээр ард түмэнд тарааж байгаа бэлэн мөнгө амьдралд шалтай юм болохгүй үнийн өсөлт авчирч, төгрөгийн ханшийг унагаж байна шүү дээ. Хар ухаанаар бодоход үүнийг л инфляци гээд байх шиг санагддаг/инээв/.

-Төгрөгийн хани эрс суларч байгаа нь наймаанд хэрхэн нөлөөлж байна вэ?

-Мэдэгдэлгүй яах вэ. Тухайлбал, өнгөрсөн жил 7000 төгрөгөөр авч байсан алимьг одоо 13000 төгрөгөөр авч байна гээд бод доо. Энэ нь гэхдээ нэг хайрцаг буюу 10 кг алимны бөөний үнэ шүү дээ. Америк алимны бөөний үнэ түрүү жил 60 мянган төгрөг байсан бол энэ жил 75000 төгрөг болж нэмэгдсэн байх жишээтэй.

-Та энд хэдэн жил жимс зарж байна вэ. Лангууны түрээс хэр вэ?

-Арваад жил болж байна. Манай лангуу 420 мянган төгрөгийн түрээстэй.

-Өндөр юмаа. Өмнө нь хэд байсан бол?

-Таван жилийн өмнө 80.0 мянга байсан, тэгээд 130.0, 180.0, 210.0 мянган төгрөг болж нэмэгдсэн юм байна. Бид нар чинь бөөний үнэ дээрээ нэг км тутамд 300-500 төгрөг л нэмж зардаг. Ашиг тийм ч сайн биш шүү дээ. Жимс зардаг лангуутай хүн олон ч жимсний вагон оруулж ирдэг нь тун цөөхөн шүү. Тоолбол 10-аадхан л байгаа байх.

-Гэхдээ яваад ажиглаж байхад яг ижил сортын алим лангуу бүрт нэгдсэн нэг үнэтэй биш зарим газар 1000 төгрөгний ч зөрүүтэй байх юм. Яагаад тэгж байна?

-Тийм байгаа байх. Ямар үнээр авснаасаа шалтгаалаад зарим нь 1000 хүртэл төгрөг нэмэх нь ч бий л дээ. Бас их хэмжээгээр аваад, хадгалж байгаа. Манай захын агуулахын түрээс бол өндөр шүү дээ. Хэлэх юм бол том тоо гарна.

Б.Мөнхтуяа:

/Сүү, цагаан идээний тасгийн худалдагч/

-Борлуулалт муу байна. Хөдөөнийхөн малынхаа сүүг боловсруулж, ааруул, эзгий хийх биш, сүү чигээр нь зарах сонирхолтой болчихсон юм шиг байна. Малчид заваар

тааруу байдаг болоод ч тэр үү. Гадаа гудамж талбайд хаа сайгүй сүү зарж байгаа биз дээ. Мөн хөдөөнийхөн сүү, цагаан идээгээ үзэсгэлэн яармагийн үеэр өөрсдөө борлуулах сонирхолтой болсон. Тэр нь илүү ашигтай байгаа байх л даа. Тийм болохоор бүтээгдэхүүний нийлүүлэлт бага, үнэ өндөр байна. Манай лангууны сарын түрээсийн төлбөр 266 мянган төгрөг хэмээн сонирхуулав.

“Барс” захын нэрийг нийслэлчүүдэд мэдэхгүй хүн ховор байх. Харин зорьж үйлчлүүлдэг нь л хэд байдаг вэ гэхээс. Нийслэлийн түм түжигнэж бум бужигнасан газруудын нэг тус захын зарим үйлчлүүлэгчдийн сэтгэгдлийг сонирхлоо.

“Бүх юм нэг дор төвлөрсөн байдаг нь явдал багатай зүгээр санагддаг. Ялангуяа жимс, жимсгэнэ харьцангуй хямд, сонголттой байдаг. Харин ганцхан гэм нь машины зогсоол байхгүй нь жаахан бэрхшээлтэй. Машинаа бүр Вокзалын ард талын байруудын орчимд тавьчихаад ирж юмаа цуглуулдаг” гэж байлаа. Нээрээ л хавь ойрд нь машины зогсоол алга. Нарны зам тавигдсан учраас машины зогсоолын талбай байхгүй юм билээ. Энэ талаар “Барс импэкс” ХХК-ийн орлогч захирал М.Эрдэнэчимэг “Манайх 80-100 машины зогсоолтой. Тээврийн товчооны уулзвар нэвтэрч шууд хашаагаар орохоор манай зогсоол байгаа. Яг захын өмнө бол зогсоолгүй. Нарны зам тавигдсан учраас. Өмнөө зогсоолгүйгээс болоод замын хөдөлгөөнд саад бэрхшээл учирч байгаа юм байхгүй. Манай захын эзэмшлийн талбай бол бага шүү дээ. Ганцхан га газар. Гэтэл манайх Улаанбаатар хотын хүнсний захуудын анхдагч нь. Импортоор ирж байгаа бүх төрлийн жимс, хүнсний ногоо манайд буудаг. Улаанбаатар төмөр замтай гэрээ байгуулж хоногт 2-8 вагон хүлээж авах хүчин чадалтай зам түрээсэлдэг байсныгаа өөрийн

Гурилын үнэ буурчээ

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр Улаанбаатар хотын хүнсний зах, дэлгүүрт 2011 оны хоёрдугаар сарын 9-ний байдлаар худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг дүнгээр нь өмнөх сарын мөн үеийн дундаж үнэтэй харьцуулахад 0.3 хувиар өссөн бол, өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад 0.4 хувиар буурсан байна.

Харин гурилын үнийн хувьд нэгдүгээр сарын дундаж үнэтэй харьцуулахад “Алтан тариа”-н задгай дээд гурилын үнэ 0.2 хувь, 1-р зэргийн гурилын үнэ 0.8 хувь, савласан дээд гурилын үнэ 0.3 хувь, хятад дээд гурилын үнэ тус тус 0.3 хувиар өссөн бол, тус компанийн савласан 1-р зэргийн гурилын үнэ 0.1 хувь, Орос дээд гурилын үнэ 2.5 хувиар буурсан байна. Бусад гурилын үнэ тогтвортой байжээ. ■

болгосон. Баяр ёслолын үеэр арваад вагон буух жишээтэй. Түүнчлэн бүх хүнсний зах, дэлгүүрүүд, ресторан, цайны газрууд манайхаас жимс, ногоогоо авахаас гадна хөдөө, орон нутаг руу эндээс ачилт хийдэг” гэв.

“Барс” зах үүсгэн байгуулагдаад 15 жилийг үджээ. Нэг вагон 60 тоннын багтаамжтай гэж тооцоход энд хэчнээн тонн хүнсний барааг багтаан шингээж, хадгалан, борлуулж байдаг нь ойлгомжтой. Эрдэнэчимэг захирлын ярьснаар бол эдний том том агуулахуудад жимс, ногоо буугаад удалгүй дуусдаг гэсэн.

600 орчим түрээслэгчтэй аж. Тэгэхээр улаанбаатарчуудын нэлээд хэсэг нь зөвхөн энэ захаас аж амьдралаа залгуулж байна гэсэн үг. Их хөлийн газар болоод ч тэр үү жаахан заваандуу юм билээ. Вагон байнга буудаг болохоор цэвэрлээд ч нэмэргүй байдаг гэж үйлчлэгч эмэгтэй нь ярьсан. Байнга жимс, ногооны хальс, навч хөглөрөөстэй байдаг бололтой. Гэхдээ Дэнжийн 1000-ын “Хүчит шонхор” зах ч гэсэн Улаанбаатар хотыг махаар хангадаг махны бөөний төв. Бүх л хөдөөнөөс орж ирж байгаа мах ачсан машин тэнд очиж зогсдог. Нийслэлийн бүх хүнсний зах дэлгүүр, зоогийн газар, рестораныхан зөвхөн тэндээс мах, ногоогоо цуглуулдаг. Бас л түм түжигнэж бум бужигнасан газар. Махны үнэр танар, өөх тос жимс ногооныхоос ч илүү заваарна. Мөн гэр хорооллын үйлчлүүлэгч ихтэй. Задгай талбай, чингэлэгийн худалдаа ч олон. Тэгсэн хэрнээ “Хүчит шонхор”-ыг нийслэлийн задгай талбайтай хүнсний захуудаас хамгийн цэвэрхэн нь гэж хэлэхэд олон хүн маргахгүй байх. Хэдэн жилийн өмнөөс “Хүчит шонхор” зах цэмцэйн нийслэлчүүд сайн мэднэ. “Барс” захынхан цэвэр цэмцгэр байдлаараа бас “Хүчит шонхор”-оос үлгэр дууриал авч болох.

Эрдэнэчимэг захирлын өрөөнд шил толь болсон өндөр сүрлэг байшингийн зураг төсөл өлгөөтэй харагдана лээ. Манай зах өргөжөөд ийм болох зорилготой байгаа. Бүх зураг төслөө Хотын захиргаа болон холбогдох төр, засгийн байгууллагуудад хүргүүлсэн ч манайд газар өгөх талаар шийдтэй хариу өгдөггүй хэмээн ярьсан. Тэрбээр мөн “Дулааны шугам хоолой манай энүүгээр их байдаг нь бидэнд байр саваа өргөтгөхөд нөлөөлдөг тал бий л дээ” гэж учирласан. Энд мөнөөх л олон жилийн өмнөөс үзэн ядаж ирсэн чингэлэгийн худалдаа мэр сэр байна лээ. Эндээс сэтгүүлчийн нүдээр харахад бараа, хүн хоёр нь ахадсан их хөлийн газар санагдсан. Бас бага зэргийн эмх цэгцэнд оруулаад, наймаачид нь эргэн тойрноо цэмбийлгээд хэвшчихвэл “Барс” –аар хүмүүс бүр л ая тухтай, сэтгэл хангалуун үйлчлүүлэх нь дамжиггүй.

Жимс, жимсгэний нийт хэрэгцээний 80 хувийг зөвхөн эндээс хангадаг байна. Сардаа 100-120 вагон жилдээ 1600 вагон хүнс буудаг гээд бод доо. Эрдэнэчимэг захирал одоо төмс урдаас орж ирэхээ больчихсон шүү дээ. Төмснөөс бусад хүнсний ногоо ирдэг гэсэн. Иргэд Хятадаас төмс огт орж ирэхгүй болсон гэдэгт итгэж чаддаггүй. Тийм болохоор төмс үнэхээр орж ирээгүй байна уу гэж “Барс”-ын хүнсний ногооны бөөний худалдаагаар нэлээд явлаа. Хятад төмс үнэхээр алга. Сонгино, байцаа, манжин зэрэг хүнсний ногоо бөөний болон жижиглэнгийн үнэтэй байв. Мөн эднийх 2007 оноос хүнсний бүтээгдэхүүн шинжилдэг итгэмжлэгдсэн лабораторитой болжээ. ■

Америк мөрөөдлийн биелэл буюу “Алиман” компанийн эцэг



Microsoft-ын үүсгэн байгуулагч Билл Гейтсийн нэрийг найман настай балчирас 80 настай буурал хүртэл мэддэг. Харин Стив Жобс гэх нэрийг мэдэх хүн олон ч Биллтэй зүйрлэшгүй ээ. Гэхдээ өмнө нь бол байдал тэс өөр байж. Эртээ урьдын цагт, хэрэглээний компьютер гэдэг ойлголт инээдтэй, бүтэшгүй үлгэр мэт байх үед л дээ. Их сургуулиа хаяад мөрөөдлөө дагасан энгийн л нэгэн америк залуу ертөнцийг тэр чигээр нь өөрчилсөн тухай энд өгүүлэх гэсэн юм. 1984 онд Стив Жобс хүн төрөлхтөнд хэрэглээний компьютерийн шинэ загвар болох “Macintosh”-ийг танилцуулж байлаа.

Тэр үед Америкийн тэргүүний сэтгүүлүүдийн нүүрт Стив Жобсын зураг хэвлэгдэж, од болж байхад Билл Гейтсийг хэн ч мэддэггүй байсан гэвэл Та итгэх үү? 1985 онд Жобс ажлаасаа халагдсаны дараа л Билл Гейтс “Apple” компанийн нэлээд хувийг авч, удалгүй Америкийн толгой баячуудын жагсаалтад багтах болсон ажгуу. “Financial Times” сонин Стив Жобсыг “2010 оны хүн”-ээр нэрлэсэн билээ. “iPad”, “iPhone” болон “MacBook Air” нөүтбүүкийн шинэчилсэн загварыг өнгөрсөн онд олон нийтийн хүртээл болгосон “Apple” компанийн ерөнхий захирал Стив Жобс энэ өргөмжлөлийг авах нь гарцаагүй байв. Ялангуяа зах зээлийн хувьд хамгийн шинэлэг бүтээгдэхүүн болох “iPad” нь дэлхийг доргиож байгаа өнөө үед “Financial Times” сонинхоон өөр хэнийгээ ч сонгох билээ дээ. Монголын УИХ-ын гишүүд хүртэл энэ бүтээгдэхүүнээр ижилсэж байгаа. 2010

оны нэгдүгээр сард “iPad” анх гарч ирэхэд “Windows”-гүй ертөнц бий боллоо хэмээн “Financial Times” сонин онцолсон нь бий.

Хэрэглээний компьютерийг хүн төрөлхтөнд хүртээмжтэй болгоход томоохон хувь нэмэр оруулсан Стив Жобс өнөөгийн “Facebook”-ийн үүсгэн байгуулагч хийгээд “Time” сэтгүүлийн “2010 оны хүн” болох Марк Зукербергээс ч залуудаа хэвлэл, мэдээллийн анхаарлын төвд орж байсныг дурдах нь зүйтэй болов уу. Стив Жобс “Apple” компаниа 21 настайдаа үүсгэн байгуулсан бол 1980 онд тус компани IPO хийхэд тэрбээр ердөө 25 хүрч байжээ.

Харьцаа муутай, яхир зантай Стив Жобсын үг, үйлдэл бүхэн сэтгүүлчдэд сонин байдаг гайхах зүйлгүй. Америкийн “нэрийн хуудас” гэж хэлж болохоор “Apple” компанийн хувьцааны ханш хүртэл энэ хүний үг, үйлдлээс хамааран хэлбэлзэж байдаг юм хойно. “Fortune” сэтгүүл түүнийг 2007 оны хамгийн нөлөө бүхий бизнесмэнээр нэрлэсэн нь “Google” болон “Microsoft”-ын удирдагчдаас ч өндрөөр үнэлсэн хэрэг болж байлаа. Харин одоо хоолойтой хар цамцнаас салдаггүй энэ хүний хачирхалтай амьдрал руу нэг өнгийж харах уу?

Стив Жобс нэрээрээ олны танил болсон Стивен Пол Жобс нь 1955 оны хоёрдугаар сарын 24-нд Америкийн Калифорни мужийн Маунтин-Вью хэмээх жижигхэн хотын энгийн л нэгэн айлд мэндэлжээ. Пол болон Клара Жобсын өргөмөл хүү тэрбээр сурагч байхаасаа л электроник сонирхдог байж. Ээж нь дунд сургуулийн нарийн бичиг, аав нь лазер үйлдвэрлэдэг нэгэн компанид механикч хийдэг байв. Араб төрхөө тэрбээр төрсөн эцэг болох Абдулфаттах Жон Жандали гэх Сири улсад төрж, АНУ-д цагаачилж ирсэн улс төрийн шинжлэх ухааны профессор хүнээс өвлөн авчээ.

Стив Жобс дунд сургуульд сурч байхдаа л өөрөөсөө ахмад Стивен Возняктай найзалж, утсаар үнэгүй ярихад зориулсан “BlueBox” хэмээх төхөөрөмж бүтээн хүүхдүүдэд зарж байсан аж. Энэхүү хууль бус үйлдэл нь хоёр залуугийн их ажлын эхлэл болжээ. Хожим нь яг тэрхүү “BlueBox”-ийн бүтцэд тулгуурлан 1970-аад оны сүүлчээр Жобс, Возняк хоёр хамтран хэрэглээний компьютер зохион бүтээсэн гэх яриа бий.

1972 онд дунд сургуулиа дүүргэж, Орегон мужийн Рида хэмээх коллежид суралцаж эхэлсэн Жобс нэг жил ч бололгүй сургуулиа орхиж, найз нөхдийнхөөрөө хоног төөрүүлж эхлэв. Түүнийг жил хагасын хугацаанд



“Кока-кола”-ны лааз тушаан хоногийн хоолоо залгуулж байсан гэх “домо” ч яригддаг. Ийм л нэгэн мөнгөгүй, боловсролгүй, техникийн мэдлэггүй хүн өнөөгийн “Apple” компанийг үүсгэсэн хачирхалтай хэрнээ үнэн түүх олны сонирхлыг одоо ч татсан хэвээр.

1976 оны дөрөвдүгээр сарын 1. Энэ бол хоёр америк залуу “Apple” компанийг үүсгэн байгуулсан түүхэн өдөр. Тэгэхдээ хаана ажиллаж байсан гээч? Машины гараажинд... Үнэндээ бүх зүйлийг Стивен Возняк бүтээж, Жобс маркетингийг нь л хариуцаж байсан гэж ойлгож болно. Хэрэглээний микрокомпьютер бүтээх санааг тэр л гаргаж, өөрийн найз Стивен Вознякийг ятгаж дөнгөжээ. Ингээд мань хоёрын анхны бүтээл болох “Apple I” 666 доллар 66 центээр үнэлэгдэж байсан нь тухайн үедээ тэнгэрт хадсан тоо боловч борлуулалт нь чамлахааргүй байв. За тэгээд “Apple II” гарч ирсэн нь зах зээлийг алмайруулж чадсан юм. Шинэлэг бүтээлүүдээрээ олны талархлыг хүртсэн “Apple” компани 1980 оны арванхоёрдугаар сард IPO амжилттай хийснээр Стив Жобс, Стивен Возняк хоёр саятан боллоо.

Харин 1984 онд “Macintosh”-ийг бүтээсэн нь жинхэнэ хувьсгал болсон юм. Гэхдээ Америкийн идэр залуу од гэгдсэн Стив Жобс харилцааны тал дээр жаахан тиймхэн байжээ. Ажилчдаа хоёр, гурав хоногоор нойргүй суулгаж, элдвээр харааж зүхэх нь энгийн үзэгдэл болсон байлаа. Удалгүй компани хэдэн хэсэг хувааж, хүмүүсээ өрсөлдүүлэн үр бүтээмжийг нь сайжруулах нэрээр өстөн дайснуудаа бэлдэж эхлэв. 1985 онд Жобс захирлуудын зөвлөлтэйгээ муудалцаж, өөрийн үүсгэн бий болгосон “Apple” компаниасаа халагдсан хойноо мөн л IT салбарын “NeXT” компаниа байгуулсан байна. Харин 1997 онд “Apple”-д түр гүйцэтгэх захирлаар эргэж ирэхдээ дээрх хоёр компани нэгтгэж, дэлхийн хэмжээний “акул” болгосон түүхтэй.

“Алиман” компаниасаа халагдсан хойноо Жобс нэлээд ажил амжуулсныг дурдахгүй байж боломгүй. 1986 онд тэрбээр “The Graphics Group” студийг “Lucasfilm” компаниас таван сая доллараар худалдан авч, “Pixar” хэмээн нэрлэсэн юм. Тэгээд “Тоглоомын түүх”, “Мангасуудын корпораци” зэрэг хүүхдүүдийн төдийгүй насанд хүрэгсдийн дунд шуугиан дэгдээж, “Хит” болсон хүүхэлдэйн кино бүтээснийг үзээгүй хүн байхгүй болов уу. Харин 2006 онд Жобс “Pixar”-ын хувьцааг “Walt Disney”-д 7.4 тэрбум доллараар заржээ. Тэгээд зогссонгүй, “Walt Disney”-н ТУЗ-д үлдэж, долоон хувийг нь эзэмшиж байгаа юм. Энэ бүхнээс Жобсын ямар сайн бизнесмэн болох нь харагдана биз ээ.

1997 онд Жобс “Apple” компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалыг түр хугацаагаар хашихаар эргэж ирснийг дээр дурдсан. Яг нэг жилийн дараа “iMac” хэмээх шинэ компьютер мэндэлж, борлуулалт нь гэрлийн хурдаар өсчээ. 2000 онд түүний албан тушаалаас “түр” гэдэг үг бүрэн хасагдсан. Харин өөрөө ертөнцийн хамгийн бага цалинтай гүйцэтгэх захирал гэдгээр Гиннесийн номонд бичигджээ. Тэрбээр жилдээ нэг долларын цалин авч байсан гээд бод доо. 2001 онд Жобс “iPod” плеерээ зах зээлд гаргасан нь “Apple” компанийн орлогын гол эх үүсвэл боллоо. За тэгээд “Intel” процессортой анхны нөүтбүүк, “Apple TV”, “iPhone” гээд шинэ бүтээгдэхүүн хөвөрч гарав. 2008 онд хамгийн нимгэн нөүтбүүк болох “MacBook Air” мэндэлсэн бол өнгөрсөн жил “iPad”, “iPhone 4”, “iPod 4”, шинэчилсэн “MacBook Air” гарч ирсэн билээ.

Дээд боловсрол ч эзэмшээгүй хэрнээ дэлхийд нэрээ дуурсгасан, өндөр технологийн салбарт өөрийн өнгө төрхөө бүрдүүлсэн энэ эрхмийн амжилтын нууц юунд байна вэ?

Нүүрэмгий, мятрашгүй, өөртөө хэтэрхий итгэлтэй

Стив Жобсд бурхнаас заяасан увидас байгаа хэмээн үзэх хүн олон. Тэрбээр өөрийн толгойд орж ирсэн санааг хэрэгжүүлэхээр нэг л зорьсон бол хэнийг ч түүндээ итгүүлж, дагуулах чадалтай нэгэн ажээ. Нөгөө талаас тэр давтагдашгүй сайн удирдагч гэгддэг. Стив Жобс энэ ертөнцийн хамгийн ухаантай хүмүүсийг олж ирээд, эрч хүчээр цэнэглэн ажиллуулж чаддаг гэж зарим хүн итгэдэг. АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама “Америк мөрөөдлийн биеллийн тод жишээ” хэмээн Жобсыг нэрлэсэн удаатай.

Харин зарим хүн Жобсыг хулгайч, дээрэмчин, “ховсдогч” гэнэ. “Тэр зүгээр л хэрэгтэй үедээ хэрэгтэй газраа байж таарсан бөгөөд хэрэгтэй хүмүүстэй харьцаж байснаас л 30 хүрээгүй байхдаа тэрбумтан болсон юм” хэмээн дүгнэнэ. Яг л “Pirates of Silicon Valley” (“Силикон хөндийн дээрэмчид”) кинонд гардагчлан Стив Жобсыг “XX зууны агуу залилагч” гэж цоллох нь ч бий. Гэхдээ энэ цолыг Билл Гейтс ч мөн түүнтэй хуваалцах тавилантай ажээ.

Суут ухаантан нь ч байна уу, сонгодог залилагч нь ч байна уу, ямартай ч Жобс, Гейтс хоёр Америкийн IT салбарын нүүр царай болсон нь хөдлөшгүй үнэн. Мөрөөдлөөс өөр юу ч үгүйгээр гараагаа эхэлсэн энэ хоёр эрхэм өөр хоорондоо өрсөлдөхдөө өрсөлдөж, хамтрахдаа хамтарсаар дэлхийн толгой баячуудын тоонд орсон билээ. 2009 онд Жобс “Forbes” сэтгүүлийн гаргасан Америкийн хамгийн баян хүмүүсийн жагсаалтын 43 дугаарт 5.1 тэрбум доллараар бичигдэж байсан бол 2010 онд түүний хөрөнгө ялимгүй өсөж, 5.5 тэрбум доллар болсон ч 136 дугаар байрт жагссан байна.

Харин “Apple” компанийн хувьд 2010 оны тавдугаар сарын 26-нд зах зээлийн үнэлгээгээрээ олон жилийн өрсөлдөгч болох “Microsoft”-ыг гүйцэж, дэлхийд гуравдугаарт жагсах болсон нь Стив Жобсын шидэт менежменттэй холбоотой гэдэг.

Сонирхуулахад, Стив Жобс “Mercedes SL55 AMG” маркийн номергүй автомашин хөлөглөдөг аж. Номерын оронд штрих-код хэрэглэдэг гэсэн таамаглал ч байдаг гэх. Тэрбээр 2009 онд элэг шилжүүлэн суулгах мэс засалд орсныхоо дараа автомашинаа тахир дутуу иргэдийн зогсоолд тавих эрхтэй болжээ. 2004 онд Жобс нойр булчирхайн хавдартай болох нь тогтоогдсон боловч эдгэрч чадсан тухайгаа нийтэд зарлаж байлаа. Чухам тэр үеэс л Жобс компаниа орхиж магадгүй гэх болгоомжлол “Apple”-ийн хувьцаа эзэмшигчдийн санааг зовоох болсон билээ. “Алиман” компанийн хувьд энэ эрхэм ямар чухал болохыг гэрчлэх зүйл мундахгүй.


Стив Жобс өвчний улмаас чөлөө авч буйгаа өнгөрсөн сард мэдэгдэхэд “Apple” компанийн хувьцааны ханш огцом буурсанд гайхах зүйлгүй ээ. “Би компаниа удирдаж, бүх чухал асуудлыг шийдвэрлэсэн хэвээр байна. Намайг байхгүйд Тим Кук захирал компанийн ажлыг хариуцах юм. Бидний энэ онд хийнэ хэмээн төлөвлөж байсан бүхнийг Тим Кук биелүүлж чадна гэдэгт итгэлтэй байгаа” хэмээн Стив Жобс мэдэгдсэнийг “Reuters” дамжуулсан юм.

Дандаа нэг л янзаар хувцасладаг Жобс одоо ч хоолойтой хар цамц, “Levi’s”-ын жинсэн өмд, “New Balance” брэндийн пүүзээ өмсөн хаа нэгтээ алхаж яваа

байх. “Apple” компанийн үүсгэн байгуулагч энэ хүний ар гэрийн амьдрал ч тун өвөрмөц. Түүний анхны охин Лиза Бреннан-Жобс нь 1978 онд Крис-Энн Бреннанаас төржээ. Стив Жобс энэ бүсгүйтэй хэзээ ч гэрлэж байгаагүй агаад охиноо ч өөрийн хэмээн хүлээн зөвшөөрөхөөс татгалзан олон жилийг үдсэн байна. Гэхдээ “Macintosh”-ийн өмнө бүтээсэн хэрэглээний компьютерээ тэрбээр өөрийн охины нэрээр буюу “Lisa” хэмээн нэрлэж байсан юм. 1991 онд Жобс Лорин Павелл гэх өөрөөсөө есөн насаар дүү бүсгүйтэй гэрлэж, нэг хүү, хоёр охинтой болжээ.

Харин одоо Стив Жобсын нэгэн сонирхолтой ишлэлээр нийтлэлээ дуусгах нь зүйтэй гэж бодлоо. 2005 онд Билл Гейтс, Стив Жобс хоёр хамтдаа шууд нэвтрүүлэгт оролцох үеэр сонирхолтой хэлэлцүүлэг өрнөсөн нь түүхэн ярилцлага болж үлдсэн байдаг.

Стив Жобс: -Би 10 жилийн дараа “Apple” компанидаа эргэж ирэхдээ хамгийн түрүүнд ганц л зүйл хийсэн. Бүх хог новшоо толгойноосоо гаргаж чулуудсан гэх үү дээ. Байнга эргэж харахгүй байх нь зөв гэж шийдсэн юм. Маргааш юу болох вэ гэдэг л хамгийн чухал шүү дээ. Хэрвээ чи байнга өнгөрснөө дурсаж, “Би ингэх хэрэггүй байсан юм”, “Тэр үед ажлаасаа халагдаагүй бол ч...” гэж бодож байвал энэ нь утгагүй, бас ямар ч үр дүнгүй. Тэрний оронд өчигдөр юу болсноо мартаад, зүгээр л маргаашийг хамтдаа бүтээцгээе. ■





Д.Батжаргал:
/СЭЗДС-ийн захирал/

Өрсөлдөн тэмцэлдэх хэрэггүй

Монголын менежментийн холбооноос нэгдүгээр сарын 28-нд “Бизнесийн байгууллагын менежментийн чадамж” нэртэй үндэсний зөвлөлгөөнийг анх удаа зохион байгуулсан. Тус зөвлөлгөөнд аж ахуйн нэгж, байгууллагын захирлууд, тэргүүлэх мэргэжилтэн, эрдэмтэн судлаач нийт 260 орчим хүн оролцсон. Уг арга хэмжээний ач холбогдлын талаар Монголын менежментийн холбооны тэргүүн Д.Цэрэндорж “Монгол оронд менежментийн орчин үеийн сэтгэлгээ төлөвших үйл явц, түүний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, аж ахуйн нэгж, байгууллагуудын менежментийн чадамж, цаашдын зорилтыг тодорхойлох явдал” хэмээв. Энэ үеэр менежментийн чадамжийг сайжруулахтай холбоотой олон илтгэл тавьснаас “Mongolian Economy” сэтгүүл хамгийн сонирхолтойг нь хүргэе.

Монгол оронд менежментийн орчин үеийн сэтгэлгээ төлөвших үйл явцад ерөнхийлсөн дүн шинжилгээ хийж, байгууллагын менежментийн чадамжийг тодорхойлогч зангилаа асуудалд та бүгдийн анхаарлыг хандуулахыг хүсэж байна.

Бидний амьдарч буй өнөөгийн ертөнцийг ерөнхийд нь хөгжил дэвшил хурдасч байна гэсэн нэгэн онцлог шинжээр тодорхойлж болно. Тийм учраас бизнесийн байгууллагын менежментийн чадамж ямар байх нь хөгжлийн энэ хурдцыг ойлгож, мэдэрч, бизнестэйгээ холбон харж, ухаарах явдлаас шууд хамаарна.

Өнөөгийн ертөнцийн бас нэг чухал онцлог шинж нь юмс үзэгдлийн, бизнесийн болон бусад аливаа байгууллага, төр засгийн үйл ажиллагааны харилцан хамаарал улам бүр хүчтэй болж байгаа явдал юм. Үүний учир шалтгаан нь дэлхийн хүн амын өсөлт, техник технологийн дэвшил, энэ бүгдээс үүдэлтэй хүрээлэн буй орчны асуудал, даяаршлын сөрөг талууд, бүтцийн өөрчлөлт, хүчний хуваарилалт гээд дэлхий ертөнц нарийн уялдаа холбоо бүхий цогц систем болон хөгжиж байгаатай холбоотой. Энэ бүгдээс үүдэн ирээдүйгээ төсөөлөн харвал нэг хэсэг нь дэлхийн хэмжээний хямрал, сүйрэл, дайн тулаан, үгүйрэл хоосрол, өлсгөлөн өвчлөл ихсэнэ гэсэн бараан төсөөлөлтэй байна.

Энэ бүгдийг ярихаар төр, засаг буруутай, улс төрчид буруутай, олигархууд буруутай, Хятад, Орос, Америк, Хойт Солонгос буруутай гээд буруутныг хайж эхэлдэг.

Өнөөдрийн энэ зөвлөлгөөн иймэрхүү ойворгон хийрхэлд автахгүй гэж зохион байгуулагч байгууллагууд тохирсныг Та бүхэн болгооно уу.

Нэг талаас, айдас хүйдэс, бараан дүр төрх харагдаж байгаа ч нөгөө талаасаа соёлт, ухаант хүн төрөлхтөний эрүүл саруул хүчин үүнийг даван туулж чадна. Үгүй ядаж өнөөгийн “Индиго” үр ач нар маань сайн сайхан, эрүүл саруул ертөнцийг бүтээн байгуулахаар илгээгдсэн гэж ярилцах юм.

Манай бизнес эрхлэгчид бизнесээ хэрхэн амжилтад хүргэх вэ гэж өдрийн бодол, шөнийн зүүд болж яваа нь мэдээж. Та бизнесээ амжилтад хүргэж чадна. Энэ бол зөвхөн таны сэтгэлгээний хэв маягаас хамаарна.

Сэтгэлгээний ямар хэв маяг таныг амжилтад хүргэх вэ? гэдэг талаар та бүхэнтэй санал бодлоо хуваалцъя.

Эдийн засаг, бизнесийн удирдлагын ухаанд нөөц баялаг буюу ресурс ховор хомс хязгаарлагдмал гэсэн урьдач нөхцөлийг авдаг. Нөгөө талд нь хэрэгцээ хязгааргүй. Тиймээс зах зээл л нууц гараараа сайн зохицуулж энэ асуудлыг шийднэ гэж үздэг. Хаа сайгүй ингэж номлож, түүндээ итгэж үнэмшсэн орон

бүхний “эдийн засгийн хүмүүсийн” сэтгэл зүрхэнд яаж өрсөх вэ? яаж өрсөлдөх вэ? гэдэг үзэл бодол, ухамсар шингэн, түүнийхээ дагуу л үйлдэл хийдэг. Ховор юмнаас хоосон хоцрох вий гэсэн айдас, түгшүүр, хардлага. Үүнээс ангижрах ганц арга нь ховор, хомс нөөц баялгийн хуваарилалтад оролцох эрх мэдэл, тэр нь ч бас хомс. Үүний үр дүнд байнгын мөргөлдөөн, сөргөлдөөн, тулаан, дайн дажин, байгаль дэлхийгээ цөллөн эцэстээ өөрсдийгөө сүйрлийн ирмэгт хүргэсэн. Монгол орны өнөөгийн дүр зураг үүнээс илүү сайхан бил үү дээ?

Өнгөрсөн үеийн онол, номлол, ойлголтоор сэтгэлгээ нь төлөвшсөн бизнес эрхлэгчид бизнесээ амжилтад хүргэх арга замаа буюу стратегия ихэнх тохиолдолд “ялан дийлэх арга ухаан, ялан дийлэх урлаг” гэж дийлэнх нь үзсээр л байна. Ер нь л ер бусын, нууцлаг, хосгүй удирдагчаас гарах ид шийдийн мэт ялан дийлэх ур ухаан, ямар ч үнээр хамаагүй ялах дийлэх” гэх мэтээр бодож төсөөлдөг. Тиймээс л өрсөлдөх, өрсөлдөөний стратеги, өрсөлдөөний давуу тал, өрсөлдөх чадвар гэдэгт чухал холбогдол өгсөөр байна. Энэ нь олонхи тохиолдолд байршил ба эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн, эрх мэдэлд үйлчлэх, эрх мэдэлтний эрх ашгийг хамгаалахын төлөөх өрсөлдөөн болон хувирна.

Ийм хатуу ширүүн өрсөлдөөнд орсон бол харилцагч, хамтрагч,

хэрэглэгч, ажилтан ажиллагсад, олон нийтийн эрх ашгийг бус зөвхөн өөрийн эрх ашгийг урьтал болгох тул сайн засаглал гэдэг бол бодит байдалд хэзээ ч бий болохгүй, хоосон мөрөөдөл гэж үзнэ. Харин ч эрх мэдэлтэнд үйлчлэх засаглал бодитойгоор оршин байгаа биз дээ гэж ам асууна. Гэхдээ л олон түмэн, хэрэглэгч, харилцагч, ажиллагсадын хазаарлах хүчний өмнө хүчин мөхөстөх тул “нийгмийн хариуцлагатай” болон дүр эсгэж, нийгмийн сайн сайхны төлөө хөрөнгө үл хайрлагч буянтай үйлстэн болж өнгөлөн далдлалт хийнэ. Энэндээ тохируулж хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагуудыг худалдан авч, хар пиарын зохиомжийг бүр сүрхий ашиглана. Үүнийгээр бүр эерэг имидж бүрдүүлэх маркетинг, пиарын стратеги, удирдахуйн ухааны нэг арга техник гэх нь холгүй өөрийгөө зөвтгөнө. Түүний дараагийн шаг нь төр засгийн өндөрлөг өөд авирах, төрийн хүчний байгууллагаар хамгаалуулах, түүний тулд улс төрийн намуудад шургалан тэмцэлдэнэ, самууруулна, юу эсийг сэдэж хийхэв. Тэр хэрээр хүзүүн дэх олсны ороолт нь нэмэгдэж чангарсаар. Залуу бизнес эрхлэгчдийн маань зарим нь ханцуй шамлан орж байна, үүнийгээр амжилтад хүргэх арга энэ л байна гэж сохроор зүтгэж бас өөрсдөө шоглуулна.

Энэ бүхний үр дүнд нийтийг хамарсан бухимдал, цөхрөл, авлигал, хүчирхийлэл, хүнлэг бус үйлдэл, гэмт хэргийн гааралт, хагарал, эв түнжингүй хагарч бутрах, гадны есөн бүрийн луйварчдын занганд орооно.

Энэ яавч бидний явах зам биш ээ. Бизнесээ ингэж хэзээ ч амжилтад хүргэхгүй, нэг удаа амжилтад хүрсэн мэт, цөм цөм ашиг хийсэн мэт боловч энэ бол дампуурлын эхлэл.

Яагаад ийм болов гэж буруутан хайхын оронд явал ийм сэтгэлгээ, санаа бодлоос ангижрах вэ? Энд ямар нэг шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар байна уу? Эдийн засаг, менежментийн ухааны өнгөрсөн үеийн онол, номлол, ойлголтоос үүдэлтэй сэтгэлгээний өнөөгийн зонхилох хэв маягийг халахын тулд эрдэмтэд, судлаачид, багш нар, бизнес эрхлэгчид, бодлого боловсруулагчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд бүгдээрээ анхдагч урьдач нөхцөлөө эргэн харъя.

20-р магадгүй хэдэн мянган зууны турш хүн төрөлхтний бүтээж бий болгосон, өнөөгийн даяарчлагдсан дэлхий ертөнцийн бүтээж бий болгох чадавх, хуримтлуулсан мэдлэг чадвар, түүнийг тээгч шинэ үеийнхэн улам бүр олшрохын хэрээр нөөц, баялаг ховор хомс, хязгаарлагдмал биш болсон. Нөөц, баялгийг бүтээн бий болгох боломж хязгааргүй их болсон. Ямар ч байсан бид

интернетийн ачаар цаг хугацаа, орон зайн хязгаарлалтыг давж чадаад, үр шимийг нь хүртээд яваа биш үү. Нийт хүн төрөлхтний хувьд нөөц, баялаг хязгаартай хэвээрээ шүү гэж маргах байх. Тиймээ, тэгэхдээ нэг орны хувьд, Монгол Улсын хувьд л, илүү прагматикаар бодъё. Монгол Улс хөгжлийн шинэ үе шатныхаа гараан дээр ирлээ гэдэг бидний монголчуудын өмнө хязгааргүй их боломжийг нээж өгч байгаа юм.

Нэг улс орон, нэг байгууллагын хувьд хязгааргүй их боломж нээлттэй байгаа юм бол хоосон хоцрох вий гэсэн айдас, түгшүүр, хардлага алга болно. Эрх мэдлийн төлөөх тэмцэл ч утга учраа алдана.

Хязгааргүй их боломжийг чинээнд нь хүртэл ашиглахын тулд харилцан ашигтайгаар хамтран ажиллах, түншлэх л арга зам ямар ч бизнесийг амжилтад хүргэх арга зам болон дурайн харагдаж, төсөөлөгдөж байвал Та шинээр сэтгэж эхэллээ гэсэн үг. Энэ бол таны амжилтын баталгаа болно.

Хоосон хоцрох вий гэдэг айдас хүйдэсгүй, бизнесээ амжилтад хүргэх ямар арга зам байна, ямар стратеги байна гээд амар тайван бодъё. Өрсөлдөн тэмцэлдэх хэрэггүй. Өрсөлдөгчөө хараад юу хийхийг харж дуурайх, эсвэл өрсөх гэж битгий бачимд. Чамд ашиг өгөх хүн чинь чиний хэрэглэгч. Түүн лүүгээ л анхааралтай хар, хүсэл сонирхлыг нь, чамаас юу хүлээж байгааг нь, ямар хэрэгцээт чанарыг хүлээж байгааг нь олж мэдээд, тэр хүсэнийг нь хийж өг. Хэрэглэгчид чинь ач тустай бол тэр худалдаж авна. Хэрэглэгчдэд хэрэгцээт чанар, үнэ цэнийг бүтээж өгч сэтгэл хангалуун болгосон, түүнийг бүтээлцсэн бүх оролцогчдодоо хувь оролцоонд нь тохируулан орлого ашгаа хуваа. Хөрөнгө оруулагч, эзэн танд нэгж бараа үйлчилгээний орлого ашгаас ногдож байгаа хувь хэмжээ чамлалттай бол, тэгээд нэгж тутмаас өөрт ногдох хувь хэмжээгээ ихэсгээд эхэлбэл бусдад, хэрэглэгчид, харилцагчид, түншүүдэд чинь, ажиллагсадад чинь очих ашиг багасахаар тэд таныг орхин явна. Тэд наргүйгээр Та ашиг орлого олж чадахгүй, Та итгэл даах бизнесмэн биш болно. Харин нэгж бараа үйлчилгээ тутмаас өөрт ногдох ашгаа багасгаад, бусдад очихыг нь шудрага оролцоо хувь нэмэрт нь тохируулан ихэсгээд байвал таны хэрэглэгч, харилцагч, түнш, чадварлаг ажилтнууд чинь олшроод л байна. Эндээс таны олох ашиг нийт дүнгээрээ нэмэгдээд, бүгдээрээ харилцан ашигтай ажиллана. Зах зээл орон зайн хувьд хязгааргүй гэж үзэж болхоор болсон тул өргөжилтийн хэмнэлтийн хууль таныг ивээх болно.

Энэ бол таны бизнесээ амжилтад

хүргэх арга зам, бизнесийн чинь стратегийн гуйвашгүй зарчим нь байх ёстой. Өрсөлдөх стратеги биш, хэрэглэгч үйлчлүүлэгчийнхээ сэтгэл зүрхийг, хайр хүндлэлийг булаах стратеги л таныг амжилтад хүргэнэ. Ялан дийлэх биш, нууцлаг ер бусын биш амьдралын энгийн үнэнд суурилсан ийм л стратегийг манай монгол бизнесмэнүүд бахдалтайгаар баримтлаасай.

Энэ стратегиа хэрэгжүүлэхийн тулд байгууллагынхаа засаглалыг хөгжүүлж байж л энэ бүх амжилт биеллээ олно. Танай байгууллагын дээд удирдлагад хэрэглэгч, харилцагч, түншлэгч, хөрөнгө оруулагч, ажилтнууд, олон нийт, мэргэшсэн шинжээчид, болон хөрөнгө оруулагчдын тэнцвэртэй төлөөлөл, оролцоо бүхий удирдлагатайгаар ажил хэргээ ил тод, тооцоотой, хариуцлагатай, шудрагаар явуулж хэвшүүлбэл сайн засаглал төлөвшлөө гэсэн үг. Мэдээллийн технологийн хөгжил энэ бүгдийг хийх хялбархан арга хувилбаруудыг аль хэдийнэ бий болгосон. Сайн засаглалтай газар луу шилдэг нь тэмүүлж, харилцан ашигтайгаар хамтрагч талууд бие биенээ дэмжин, тэр нь эрчлэгдсээр өөдлөн дэвших дотоод унтаршгүй хүчирхэг хөдөлгүүр ажиллаж эхэлнэ.

Ийм байгууллагуудыг олон түмэн, ер нь хэн ч ямар ч өнгө будаг, элдэв өргөмжлөл, нэр хаяггүйгээр, магтаал сайшаалгүйгээр хүндлэн хайрладаг юм. Ийм байгууллагуудыг л НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАТАЙ байгууллага гэж нэрлэдэг билээ. Ийм байгууллагууд л монгол орныг хүчирхэг, бие даасан, хангалуун амар тайван улс болгон хувиргах учиртай. Энд ярьсанаа эргэж нэгтгэн дүгнэе.

Бизнесийг амжилтад хүргэх арга зам бол хэрэглэгчийнхээ сэтгэл ханамжийг ихэсгэх стратеги байх хэрэгтэй бөгөөд үүнийг оролцогч бүх талуудын хамтын ажиллагаанд тулгуурлан, тэдэнд ашигтай байхуйцаар зохион байгуулж байж л хэрэгжүүлнэ. Энэ бол сайн засаглалыг байгууллагадаа төлөвшүүл гэсэн үг. Засаглал гэдэг үгнээс эрх мэдэл, засаг захирах гэсэн санаа сонсогдох ёсгүй. Засаглал гэдэг үгийг төлөөлөн оролцож засаж сайжруулах гэдэг анхдагч утгаас нь эхлэн ойлго. Оролцогч бүх талын эрх ашиг тэнцвэртэйгээр хамгаалагдах механизмыг бүрдүүлж, ажиллуулж байж бие биенээ дэмжиж эрчлэгдэх хүчээр байнга цэнэглэгдэж бизнес амжилтаа баталгаажуулсаар байх болно. Үүнтэй хамт аливаа байгууллагын нийгмийн өмнө хүлээх хариуцлага биеллээ олж, урт хугацаанд оршин тогтнож хөгжих уг сурвалж нь бүрэлдэнэ. Энэ байгууллагад ажиллагсадын амьдрал нь ч гэсэн утга учиртай болох тул хөгжлийн, амжилтийн зогсолтгүй хөдөлгүүр ажилласаар л байх ■


Төслөө хэрхэн танилцуулах вэ?

Та бизнесийн сайхан санаа сэдсэн боловч түүнийгээ хэрэгжүүлэх гэхээр хөрөнгө мөнгө хүрэлцэхээргүй байна уу? Тэгвэл төслөө бичээд урагшаа! Дэлхийд томоохонд тооцогдох хөрөнгө оруулалтын сангийн мэргэжилтнүүд санхүүжилт олохын тулд төлөвлөгөөгөө хэрхэн танилцуулах талаар зөвлөгөө өгч байна.



Игорь Табер

“Intel Capital” сангийн салбарын захирал. 1991 оноос тус сан дэлхийн 47 орны 1050 компанид нийт 9.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. Игорь Табер долоо хоногт багаар бодоход 10-20 санал хүлээж авдаг ч ердөө заримтай нь л цаг гарган уулздаг байна. Харин сангийн мөнгийг мэдээж тоотой хэдэн төсөлд л зарцуулдаг ажээ.



Жереми Левайн

“Bessemer Venture Partners” хөрөнгө оруулалтын сангийн мэргэжилтэн. Тус сангийн мэдэлд хоёр тэрбум ам.доллар байдаг агаад эдүгээ 150 гаруй төсөл санхүүжүүлж байгаа юм. Жилдээ 20-30 компани сонгож хөрөнгө оруулалт хийдэг “Bessemer Venture Partners” сангийн төлөөлөгчид жил бүр хэдэн мянган төсөлтэй биеслэн танилцаж байж сонголтоо хийдэг байна.



Жузеппе Цокко

“Index Ventures” хөрөнгө оруулалтын сангийн мэргэжилтэн. 1996 онд Женевт байгуулагдсан уг сан 1.5 тэрбум гаруй еврогийн санхүүжилт хийгээд байгаагийн дотор “Skype”, “MySQL”, “Betfair” зэрэг дэлхийд нөлөө бүхий компаниуд ч багтаж байна.

1. Та бизнесээ танилцуулж байхдаа төслөө өөр хэн нэгэнд зарж болох тухай битгий дурдаарай. Хөрөнгө оруулагчийн хувьд хөгжлийн төлөө явж буй компани сонирхолтой болохоос биш зарж мөнгө олох бизнес сонин биш.
2. Таны бизнес хязгааргүй хэмжээгээр тэлэх боломжтой гэж битгий хэл. Тийм зүйл байдаггүй юм. Бодит амьдралын хөрсөн дээр буу.
3. Орлогын хэдэн арван эх үүсвэр байж болохыг онцлоод хэрэггүй. Тиймээс анхаарлаа нэг чухал эх үүсвэрт төвлөрүүлсэн нь хялбар байна.
4. Танилцуулгын хуудсуудад гарч байгаа өгүүлбэр бүрийг ярьж, нуршив аа! Тэрийг чинь тэртэй тэргүй уншаад л ойлгогчихно шүү дээ.
5. Товч бөгөөд тодорхой ярь. Өөрийн бүтээгдэхүүнээ гаргаж ирээд, онцлогийг нь тэмдэглэ. Энэ нь 2-3 өгүүлбэрт багтаж байвал маш сайн.
6. Яагаад таны бүтээгдэхүүн хүний амьдралд чухал вэ, тэгээд түүнийг яагаад заавал танай баг хэрэгжүүлэх ёстой гэж? Энэ хоёр асуултад л анхаарлаа төвлөрүүлж, хөрөнгө оруулагчийг алмайртал яриарай.

1. Хэзээ ч битгий “бүдүүн төлөвлөгөө” бэлтгэж бай. Хэрвээ таны санааг 15 хуудаснаас дээшгүй танилцуулгад хураангуйлж болохооргүй төвөгтэй бол хөрөнгө оруулагчдад таалагдах нь юу л бол.
2. Хөрөнгө оруулагчийн сонирхлыг татаж болох хамгийн чухал гурван асуудал бий. Ажлын баг, зах зээлийн судалгаа, таны бүтээгдэхүүний давтагдашгүй байдал. Хэрвээ та эдгээрийг үндэслэн шинэ санаагаа амьдралд хэрэгтэйг баталж өгөхгүй бол хөрөнгө оруулагч танд цаг үрэх нь дэмий хэрэг болно.
3. Албаны үг хэллэг аль болох бага хэрэглэ. Таны санаа хамгийн шинэлэг байлаа ч энэ бүх үг, өгүүлбэрүүд “Энэ тухай би өмнө нь сонсож байсан шиг л санагдах юм...” гэсэн сэтгэгдлийг төрүүлэх болно.
4. Ярилцлагын үеэр “нууц” гэдгийг мартаж хэрэгтэй. Шинэ санаа хямдхан байдаг бол түүнийг амьдралд хэрэгжүүлэх нь хамгийн үнэ цэнэтэйг бүү март. Та санхүүжилт авахын тулд харилцаж буй хүндээ итгэн, санаа бодлоо илэн далангүй чөлөөтэй илэрхийлэх нь зүйтэй. “Энэ хүн миний санааг аваад, өрсөлдөгч компанид хөрөнгө оруулчих вий” гэж айх хэрэггүй. Итгэлцэл гэдэг хамгийн чухал шүү дээ.

1. Санхүүгийн таамаглалаа маш тодорхой гаргах гэж хичээх хэрэггүй. Үнэндээ гурван жилийн дараа таны бизнесийн орлого ямар байхыг хэн ч хэлж чадахгүй шүү дээ. Харин төслөө хэрэгжүүлэхэд хэдий хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдахыг тодорхой гаргаж, түүнийгээ хэрхэн юунд зарцуулахаа л нарийн тооцоолж, танилцуулаарай.
2. Та бизнес эрхлэх гэж буй салбараа сайн мэддэг, энэ зах зээлийг ойлгодог болохоо харуул. Түүнчлэн төслийг хэрэгжүүлэх ажлын баг танд бүрэн итгэдгийг хөрөнгө оруулагчдаа мэдрүүлээрэй. Ер нь яагаад заавал та энэ багийг удирдаж, энэ бизнесийг эрхлэх ёстой гэж?
3. Бүхнийг мэддэг юм шиг царайлах хэрэггүй. Бүтэлгүйтэл ч гэсэн амжилттай дүйцэхүйц чухал байдаг юм. Нэг ч удаа алдаа гаргаж байгаагүй, өөрийгөө “бүхнийг мэдэгч” гээд бодчихсон хүнээс илүүтэй өмнө нь унаж байсан, гэхдээ юунаас болсноо сайн ойлгож, хаширсан хүнийг би л хувьдаа илүүд үздэг.
4. Шударга бай. Хэрэглэгчдийг тохуурхсан ч юм уу, хууран мэхэлж мөнгө олох төслийг хэн нэгэнд харуулахгүй байсан нь дээр. Та үйлчлүүлэгчдээ мэхэлж байгаа бол хөрөнгө оруулагчаа хуурахгүй гэсэн баталгаа байна гэж үү?
5. Ухаан санаагаа төвлөрүүл. Аль нэг нь бүтчихэж магадгүй гээд алхам бүрээ тоочих нь хөрөнгө оруулагчийн сонирхлыг татдаггүй юм. Өөрөөр хэлбэл, энэ алхам бүтэлгүйтлээ гэхэд өөр ямар арга зам сүвэгчлэх вэ гэдгээ яриад хэрэггүй. Тэр бүхнийг чинь санхүүжүүлэгч өөрөө олоод харчихна.

(“Forbes” сэтгүүлээс орчуулав)

Бизнесийн завсарлага

Та хамгийн сүүлд бизнесийн ямар шинэ санаа олсон бэ?

Та ямар ном уншиж байна вэ?

Т.Лхагвадорж:

/“Хүннү коал” компанийн ерөнхий захирал/


-Ажил хэрэгч хүмүүс аялахдаа бизнес классын нислэгийн тасалбарт өндөр үнэ төлж байгаа. Ингэхдээ ямар компанийн нислэг илүү тохь тухтай вэ гэдгийг бодолцох нь мэдээж. Ихэвчлэн л олон цаг нисдэг, тийм ээ? Миний бодлоор МИАТ компани багахан хөрөнгө зараад, бизнес классын суудлууддаа хөлний массажны төхөөрөмж суурилуулчихвал зүгээр юм шиг ээ. Одоо тийм төхөөрөмж хаа сайгүй л байдаг болчихсон ш дээ. Хүмүүс ч сэтгэл ханамжтай байх болов уу. Үүнийхээ хаяуд тасалбарын үнээ жаахан нэмсэн ч яах вэ дээ...

Тэрбээр “Kennedy and the Promise of the Sixties” гэдэг ном уншиж байна. “Хүйтэн дайны үед Жон Кеннеди залуугаараа АНУ-ын Ерөнхийлөгч болсон. 1960-аад оны Америкийн амьдралыг энэ номын зохиогч маш сонирхолтой гаргаж ирсэн юм билээ. Жон Кеннедигийн нүдэн дээр улс орон нь шилжилтийн үеийг туулдаг. Вьетнамын дайн, “Baby boom” гээд л... Америкчууд хөгжилд хүрэхдээ ямар зам туулав аа?” хэмээн Т.Лхагвадорж яриу.

Х.Түмэнгэрэл:

/“Жуулчин говь” компанийн ерөнхий захирал/

-Эртний хүний мөрөөр нэртэй гоё ном уншиж байна. Монголын говиос үлэг гүрвэлийн анхны өндөг, мөн эртний хүмүүсийн ул мөр, ан амьтны араг яс олдсон нь бий. Ер нь Ази нь бүх тивийн өлгий, эх тив гэж нэрлэгддэг. Энэ бүх сонирхолтой мэдээлэл, баримт, түүхийг “Эртний хүний мөрөөр” номонд өгүүлсэн байгаа. Олон жилийн өмнө шинжлэх ухааны баримттайгаар судалж, бичсэн тус номыг анх удаа



“Kennedy and the Promise of the Sixties”, В.Ж.Рорабах

В.Ж.Рорабах 1960-аад оны эхэн үеийн Америкийн нийгмийн амьдралыг Жон Кеннеди Ерөнхийлөгчийн амьдралаар илэрхийлжээ. Хүйтэн дайны бүүдгээр онууд. Хүний эрхийн төлөөх хөдөлгөөн, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хамгаалах тэмцэл туйлдаа хүрнэ. Улс төрийн аллага, Вьетнам дахь бүтэлгүйтэл гээд маш олон үйл явдал Жон Кеннедигийн нүдэн дээр болж байв. 1963 оны

наймдугаар сард Мартин Лютер Кинг “Надад мөрөөдөл бий” алдарт илтгэлээ тавилаа. Америкийн улс төр, нийгэм, соёл өөрчлөгдөж, америкчууд шилжилтийн үеийг туулж байна. Энэ он жилүүдэд америкчуудыг итгэл үнэмшил л хөтөлж байсан тухай В.Ж.Рорабах бичжээ.

монгол хэлнээ Д.Гэрэлтгөв оруулагч хөрвүүлэн буулгаж, монголчуудын сонорт хүргэсэнд талархаж байна. Монголд хамгийн их борлуулалттай ном болж байна шүү дээ.


Дээрх номыг зохиогч Рой Чэнтмэн Эндрюс 1923-1928 онд хамгийн олон автомашинтай, мөн 150 тэмээгээр Монголын говиор аялж, энэхүү түүхэн судалгааг хийсэн байдаг. Монголыг судалсан хамгийн том аялалд тооцогддог. Монголчуудын заавал унших ёстой энэ номыг “Оюутолгой” ХХК ивээн тэтгэсэн.

-Өмнөговь аймгийн Булган сумын Баянзэг гэдэг газарт үлэг гүрвэлийн хүрээлэн байгуулах санааг сэдээд ажил хэрэг болгоход анхаарч ажиллаж байна. Булган сум бол анхны хүн амьдарч байсан, анхны торгоны зам бий болсон, анхны үлэг гүрвэлийн өндөг олдсон, дэлхийн үлэг гүрвэлийн өлгий нутаг юм.

Ө.Ганзориг:

/Монголын санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч/

Тэрээр “The Grand Design” гэдэг ном уншиж байна. “Орчлон ертөнцийн утга учрыг маш сонирхолтойгоор илэрхийлсэн ном. Сүүлийн үед философийн ухаан астрофизик, биологи зэрэг бусад шинжлэх ухаантай холилдон хоршиж байгааг гаргаж ирсэн. Астрономи, физик, философийн тухай ном гэх үү дээ” хэмээн Ө.Ганзориг тайлбарлав.



“The Grand Design”, Стефен Хоукинг болон Леонард Млодинов

Бид өөрсдийгөө олсон дэлхийг яаж ойлгох вэ? Үнэн гэж юу юм бэ? Ертөнц ямар нэгэн зохион бүтээгчтэй юу? Хүн төрөлхтөн бид эдгээр асуултыг байнга боддоггүй боловч бидний хэн нь ч энэ асуултуудыг хааяа өртөө тавьдаг. “Уламжлал ёсоор энэ нь философийн асуултууд. Гэвч философи үхчихлээ. Эрдэмтэд ертөнцийн шинэ зургийг зурж байна. Энэ нь 10, эсвэл 20 жилийн өмнөхөөс тэс өөр зураг юм” хэмээн номын зохиогч Стефен Хоукинг бичээд, “Энэ бүх асуултад хариулахын тулд Леонард Млодинов бид хоёр хичээсэн. Үр бүтээл нь бидний дөрвөн жилийн хөдөлмөр-The Grand Design” гэжээ.

Валютын зах

Дотоодын бэлэн бус валютын зах

Валют	Код	2/10		1/10		Өөрчлөлт (авах ханш)
		авах	зарах	авах	зарах	
Доллар	USDMNT	1,254	1,266	1,267	1,279	-1.0%
Евро	EURMNT	1,717	1,745	1,610	1,669	6.6%
Иен	JPYMNT	15.12	15.44	15.1	15.65	0.1%
Юань	CNYMNT	190	193.8	190	195.3	0.0%
Фунт	GBPMNT	1,986	2,081	1,939	2,034	2.4%
Рубль	RUBMNT	42.4	44	40.9	42.4	3.7%
Вон	KRWMNT	1.11	1.19	1.11	1.19	0.0%

Дотоодын бэлэн валютын зах

Валют	Код	2/10		1/10		Өөрчлөлт (авах ханш)
		авах	зарах	авах	зарах	
Доллар	USDMNT	1,265.00	1,268.00	1,275.00	1,278.00	-0.8%
Евро	EURMNT	1,730.00	1,740.00	1,650.00	1,670.00	4.8%
Иен	JPYMNT	15.33	15.38	15.40	15.60	-0.5%
Юань	CNYMNT	192.50	193.30	193.50	194.50	-0.5%
Фунт	GBPMNT	2,020.00	2,040.00	1,970.00	2,010.00	2.5%
Рубль	RUBMNT	42.70	43.30	40.90	41.20	4.4%
Вон	KRWMNT	1.16	1.18	1.14	1.17	1.8%

Монголбанкнаас зарласан ханш

Валют	2/10	1/10	Өөрчлөлт
Доллар	1,256.21	1,279.63	-1.83%
Евро	1,713.03	1,661.86	3.1%
Иен	15.24	15.33	-0.6%
Юань	190.68	193.03	-1.22%
Фунт	2,018.54	1,975.49	2.2%
Рубль	42.86	41.65	2.9%
Вон	1.13	1.14	-0.9%

Олон улсын валютын зах

Суурь валют	2/10		1/10		Өөрчлөлт
1 EUR =	1.3687	USD	1.2893	USD	6.2%
1 USD =	82.65	JPY	83.155	JPY	-0.6%
1 GBP =	1.6085	USD	1.5532	USD	3.6%
1 EUR =	113.1	JPY	107.19	JPY	5.5%
1 USD =	6.58	CNY	6.634	CNY	-0.81%
1 USD =	29.29	RUB	30.577	RUB	-4.2%
1 USD =	1116.78	KRW	1124.38	KRW	-0.7%

Төгрөгийн ханш суларсаар байх уу

2010 онд төгрөгийн ханш ам.долларын эсрэг 15 хувиар чангарснаар дэлхийн хамгийн өндөр өсөлттэй валютаар шалгарч байлаа. Харин он гарсаар Монголын үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш суларч эхлээд байна. Монголбанкнаас зарласан ам.долларын ханш 2010 оны арванхоёрдугаар сарын 10-нд 1213 төгрөг байсан бол хоёр сарын дотор энэ үзүүлэлт 1256 төгрөгт хүрч, 3.5 хувиар чангарчээ. Евро, фунт, рублийн ханш ч мөн төгрөгийн эсрэг мэдэгдэхүйц дээшилсэн байгааг хүснэгтээс харна уу.

Шинэ жил, Цагаан сарын үеэр их хэмжээний валют гадагшилснаас төгрөгийн ханш суларсныг “Найман шарга” валют арилжааны цэгүүдийн ченжүүд тайлбарлав. Түүнчлэн энэ үеэр барилга, уул уурхайн үйл ажиллагаа идэвхжиж эхэлснээс гадаад валютын эрэлт улирлын шинжтэйгээр нэмэгдэж байгааг мэргэжилтнүүд ярьж байна. Гадаад худалдааны тэнцэл энэ оны нэгдүгээр сард 139.6 сая ам.долларын алдагдалтай гарсан бол 2010 оны мөн үед 31.5 сая ам.долларын ашигтай гарч байсныг Үндэсний статистикийн хороо мэдээлэв. Уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор өндөр үнэтэй тоног төхөөрөмж импортоор орж ирж байгаа нь гадаад худалдааны алдагдал нэмэгдэхэд нөлөөлсөн аж. Энэ бүхнийг үл харгалзан Монголын үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш цаашид сулрахгүй, харин ч чангарах төлөвтэйг шинжээчид онцлов. Учир нь дэлхийн санхүү, эдийн засгийн байдал сэргэж эхэлснээс Монголд орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өссөөр байгаагийн зэрэгцээ хилийн чанадад ажиллаж буй монголчуудын эх орон руугаа гуйвуулах валютын урсгал нэмэгдэж байгааг статистик харуулна. Үүний хажуугаар алт, зэс, нүүрсний үнэ асар өндөр байгаа нь манай экспортод сайнаар нөлөөлж, төсвийн орлого төлөвлөж байснаас ч илүү гарах хандлагатайг мэргэжилтнүүд тэмдэглэж байна.

Мөнгөний зах


UBIBOR

UBIBOR (1 жил)











Монголын санхүүгийн зах зээлийн холбоо нь олон улсын санхүүгийн мэдээллийн тэргүүлэгч компани болох “Томсон Ройтерс”-той хамтран UBIBOR буюу Улаанбаатарын банк хоорондын суурь хүүг 2007 оны гуравдугаар сараас эхлэн тооцоолж, зах зээлд оролцогчдод түгээх болсон. Энэхүү суурь хүүг нийтэд мэдээлж эхэлснээр санхүүгийн зах зээлд хөвөгч хүүтэй санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн үнийг тогтоох боломжтой болсон билээ.

UBIBOR /Ulaanbaatar InterBank Offered Rate/ нь Монголын мөнгөний захын суурь хүү бөгөөд Монголын томоохон банкууд хоорондын төгрөгийн мөнгөн хадгаламж/ зээл өгөх, авах дундаж хүүг өдөр бүр тооцоолдог.




Улаанбаатарын банк хоорондын захын суурь хүү нэгдүгээр сарын 10-наас хоёрдугаар сарын 10-ныг хүртэлх хугацаанд тогтвортой байсныг графикаас харна уу. Сарын дундаж өдрийн хүү 7.000, сарын хүү 8.1702, жилийн хүү 10.0737 байсан нь өмнөх сараас дунджаар нэг хувиар буурсан үзүүлэлт юм.

Хувьцааны зах



Топ 20 индекс түүхэн дээд түвшиндээ хүрэв

	Код	10-Feb	Нэг сарын өөрчлөлт (хувиар)	Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)
Багануур	BAN	32,199	154.6%	675.42
Тавантолгой	TTL	970,000	69.1%	510.85
Шивээ-Овоо	SHV	30,010	143.8%	402.71
АПУ	APU	3,400	50%	252.58
Шарын гол	SHG	20,900	86.1%	151.14
Монголын цахилгаан холбоо	MCH	3,900	6%	100.89
Адуун чулуун	ADL	20,650	83.5%	65.07
Говь	GOV	6,900	23.2%	53.83
Би ди сек	BDS	3,100	22%	34.1
Могойн гол	BDL	38,001	187.5%	31.53
Улсын их дэлгүүр	UID	690	73.1%	25.4
Монголиа девелопмент ресорсез	MDR	1,700	41.7%	23.38
Ремикон	RMC	145	90.3%	18.51
Хөх ган	HGN	179	-3.7%	18.14
Ээрмэл	EER	4,255	32.1%	14.8
Баянгол зочид буудал	BNG	31,200	30.5%	13.2
Махимпэкс	MMX	3,000	32.6%	11.4
Дархан нэхий	NEH	10,300	96%	11.39
Улаанбаатар зочид буудал	ULN	31,860	15.8%	10.68
Женко тур бюро	JTB	102	14.4%	10.2



тавдугаар сард IPO хийн, таван тэрбум төгрөг босгосон тус компанийн хувьцааны үнэ 2009 оны есдүгээр сард хоёрдогч зах зээлд гарахдаа нэрлэсэн үнээсээ нэлээд доогуур арилжаалагдаж байсан юм.

Он гарсаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын зах зээлийн нийт үнэлгээ түүхэнд байгаагүйгээр огцом нэмэгдэж, анх удаагаа гурван их наяд төгрөгөөс давсан тухай мэргэжилтнүүд онцолж байна. Манай хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд улирлын чанартайгаар жил бүрийн нэгээс дөрөвдүгээр сард өсөх хандлага байдаг ч энэ онд дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ өндөр байгаагийн зэрэгцээ Лондоны хөрөнгийн бирж “Монголын хөрөнгийн бирж” компанийн менежментийг сайжруулах гэрээ, хэлэлцээр хийсэн

Топ 20 индекс 2010 онд 138 хувиар өсч, бөмбөрцгийг алмайруулсан билээ. Тэгвэл нэгдүгээр сарын 10-наас хоёрдугаар сарын 10-ны хооронд буюу ганцхан сарын дотор уг индекс 67.4 хувиар дээшилснийг графикаас харна уу. “Могойн гол”, “Адуун чулуун”, “Багануур”, “Шивээ Овоо”, “Шарын гол”, “Тавантолгой” зэрэг






нүүрсний компанийн хувьцааны үнэ огцом нэмэгдсэн нь Топ 20 индексийн өсөлтөд шууд нөлөөлжээ.

Түүнчлэн “Ремикон” компанийн хувьцааны ханш энэ хугацаанд 90 гаруй хувиар өсч, нэгдүгээр сарын 21-нд 103 төгрөгөөр арилжаалагдсанаар анх удаагаа нэрлэсэн үнэдээ хүрсэн байна. 2008 оны

Монголд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын хувьцааны ханш

	Бирж	Код	2/10/2011 (ам.доллар)	Нэг сарын өөрчлөлт (хувиар)	Зах зээлийн үнэлгээ (сая ам.доллар)
Ivanhoe Mines	NYSE, TSX	IVN	28.17	15.6%	12,731.80
Mongolian Mining Corp	HKEx	975	1.38	6.9%	5,127.30
Centerra Gold	TSX	CG	17.91	-8.3%	4,211.20
SouthGoby Energy Resources	TSX, HKEx	SGQ, 1878	16.07	16.1%	2,956.20
Mongolia Energy Corporation	HKEx	276	0.27	-13.5%	1,653.10
Aspire Mining Limited	ASX	AKM	0.66	22.2%	450.00
Entrite Gold	TSX, AMEX	ETG, EGI	3.24	0.9%	368.00
Petro Matad	LSE	MATD	2.1	5.5%	329.10
Hunnu Coal	ASX	HUN	1.3	4%	209.20
Erdene Resource Development	TSX	ERD	1.47	-7.6%	130.90
Khan Resources	TSX	KRI	0.55	19.6%	29.80

Таваарын зах



Зэсийн үнэ 10 мянган ам.доллараас давлаа

Зэсийн ханш туулай жилийн гараагаа “халуухан” эхэллээ. Хоёрдугаар сарын 3-нд монголчуудыг битүүрч байх зуур манай төсвийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлэгч зэсийн үнэ Лондоны металлын биржид түүхэнд анх удаагаа 10 мянган ам.доллараас давсан байна. Энэ нь дэлхийн зах зээлд зэсийн хомсдол нүүрлэсэнтэй холбоотойг мэргэжилтнүүд тайлбарлажээ.


Металлын хэрэгцээгээрээ дэлхийд тэргүүлдэг Хятадын хэрэглээ 2008 оны сүүлчээс гурав дахин нэмэгджээ. Дэлхийн нийт зэсийн хэрэгцээ жилд ойролцоогоор 18 сая тонн байдгаас 30 орчим хувийг нь урд хөрш дангаараа “уудаг” гэсэн тооцоо бий. Хятадууд Цагаан сараа тэмдэглэж, долоо хоног арилжаанд оролцохгүй байх үед л зэсийн үнэ эргээд ялимгүй буурсан нь урд хөрш энэ зах зээлд ямаршуу том байр суурь эзэлдгийг харуулна. “Хятадууд тоглоомоос түр гарч байх үед үнэ буурах нь аргагүй шүү дээ” хэмээн “Country Hedging” компанийн шинжээч Стерлин Смит онцолжээ.

Дэлхийн зэсийн нийлүүлэлтийн хомсдол 2011 онд 822 мянган тоннд хүрэх бөгөөд энэ нь өнгөрсөн жилийнхээс хоёр дахин өндөр үзүүлэлт болохыг “Barclays Capital”-ын шинжээчид анхааруулж байна. Түүнчлэн “JP Morgan”, “Morgan Stanley” зэрэг томоохон хөрөнгө оруулалтын банк ч зах зээлд зэсийн хомсдол нүүрлэнэ гэсэн дүгнэлтэд хүрээд байгаа юм. Чилийн “CodeLco” компанийн мэргэжилтнүүд зэсийн хомсдол хагас сая тоннд

хүрнэ хэмээн үзэж буй аж. Гэтэл “Societe Generale” банкны шинжээчдийн тэмдэглэж буйгаар уг металлын хомсдол аль хэдийнэ бий болжээ. Биржүүдэд байгаа зэсийн нийт нөөц дэлхийн хэрэгцээг 10 хоног ч хангаж хүрэхгүй гэдэгт тус банкныхан мөрийцөхөд ч бэлэн байгаа гэх.

“Goldman Sachs” банкны шинжээчид 2011 онд тонн зэсийн үнэ 10,230 долларт хүрнэ хэмээн дүгнэж, өмнөх таамаглалаа 15 хувиар нэмсэн байна. Австралийн зэс, алтны олборлолтын “Oz Minerals Ltd” компанийн захирал Терри Бержесийн үзэж буйгаар “Нийлүүлэлтийн асуудал тийм ч сайн биш байгаа болохоор зэсийн үнэ асар өндөр түвшинд тогтворжих хандлагатай байна. Уурхайнуудын үйл ажиллагаа тасалдаж байгаа тухай мэдээлэл хөвөрсөөр байхад шинэ төслүүд санаж байсан шиг хурдан ашиглалтад орохгүй байна шүү дээ” гэжээ.

Бөмбөрцгийг донсолгосон санхүү, эдийн засгийн хямралын үеэр зэсийн үнэ навс унаж, хөрөнгө оруулалт буурсан болохоор одоогийн ихэнх уурхайн чансаа буурчээ. Чилийн зэсийн уурхайнуудын хүдрийн чанар муудаж, үйлдвэрлэлийн хэмжээ багасч байгааг мэргэжилтнүүд онцлов. Үүний тод жишээ гэвэл 2011 онд “Рио Тинто”-гийн гаргах зэсийн хэмжээ өнгөрсөн оныхоос ч доогуур байх тухай Том Албаниз мэдэгдсэн явдал юм. Харин одоо зэсийн үйлдвэрлэлээр дэлхийд толгой цохьдог компаниуд



хөрөнгө мөнгөө шинэ төслүүдэд хайр найргүй цацаж эхэллээ. Ирэх таван жилд “CodeLco” компани 15 тэрбум ам.доллар зарцуулж, зэсийн шинэ уурхайнууд ашиглалтад оруулахаар зэхэж буйг тус компанийн захирал Диего Хернандез мэдэгджээ.

Манай орны нийт экспортын 30 орчим хувийг эзэлдэг зэсийн үнэ өндөр байна гэдэг таамаглал гарч байгаа нь мэдээж сайн хэрэг. Гэхдээ санаанд оромгүй явдал гарахыг үгүйсгэх аргагүй. 2008 оны долдугаар сард 8930 ам.долларт хүрч байсан тонн зэсийн ханш хагас жилийн дотор 2770 ам.доллар болтлоо навс унаж байсан удаатай. Ийм зүйл болохыг хэн ч урдчилан хараагүйг болов уу...

Монгол Улсын төсвийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлсээр ирсэн “Эрдэнэт” үйлдвэр жилдээ 20 гаруй сая тонн хүдэр боловсруулж, 520 орчим мянган тонн баяжмал гаргадаг билээ. Үүнээс ердөө 120 мянган тонн цэвэр зэс үйлдвэрлэх боллоцоотойг мэргэжилтнүүд онцолж байна. Дэлхий даяар жилд 18 орчим сая тонн зэс хэрэглэдэгтэй харьцуулахад 120 мянган тонн гэдэг өчүүхэн бага тоо. Харин 2013 оноос Оюутолгойн уурхай ашиглалтад орсноор жилдээ 500 мянган тонн зэс гаргана гэсэн тооцоо бий. Энэ нь Чилийн томоохонд тооцогдох “CodeLco Norte”